



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

# МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ 2020

WHITE PAPER ON CRIME

Улаанбаатар хот  
2021 он

## ЗАХИАЛАГЧ



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

## ГҮЙЦЭТГЭГЧ



ДОТООД ХЭРГИЙН  
ИХ СУРГУУЛЬ

## ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ  
ЗӨВЛӨЛ



УЛСЫН ЕРӨНХИЙ  
ПРОКУРОРЫН ГАЗАР



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН ХОРОО



АВЛИГАТАЙ  
ТЭМЦЭХ ГАЗАР



ЦАГДААГИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР



ШҮҮХИЙН ШИЙДВЭР  
ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ  
ГАЗАР



ШҮҮХИЙН  
ШИНЖИЛГЭЭНИЙ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

## СУДАЛГААНЫ БАГ

### Зөвлөх

Л.Нямгэрэл МУГХУСАЗЗ-ийн Ажлын албаны дарга  
П.Батбаатар Хууль зүйн доктор, профессор, ДХИС-ийн захирал

### Судалгааны багийн ахлагч

О.Зоригт Хууль зүйн доктор, дэд профессор

### Судлаачид

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор,  
Т.Оюунчимэг Хууль зүйн доктор, профессор, Ч.Нямсүрэн Хууль зүйн доктор, профессор,  
Б.Алтангэрэл Хууль зүйн доктор, дэд профессор, В.Болор-Эрдэнэ Хууль зүйн доктор,  
Д.Мөрөн, Н.Амарзаяа, Л.Одхүү, Н.Сайнбаяр, Э.Дашгаадан, З.Сүлд, М.Хүрэлбат, Г.Ганхүлэг,  
Н.Буяннэмэх, Б.Балжмаа, Б.Анар, Б.Жамсран (ДХИС).  
Х.Эрдэм-Ундрах (Dr.jur), О.Энххүслэн, Х.Буянбат (ХЗҮХ)



## АГУУЛГА

### ӨМНӨХ ҮГ 4

#### ЦАГДАА - POLICE

1. Товч танилцуулга	10
2. Гомдол, мэдээлэл	10
3. Гэмт хэрэг	14
4. Мөрдөн шалгах ажиллагаа	23
5. Зөрчил	26
6. Зам тээврийн осол, хэрэг	26
7. Эрүүлжүүлсэн хүн	36
8. Урьдчилан сэргийлэх ажил	36

#### ПРОКУРОР - PROSECUTOR

1. Товч танилцуулга	40
2. Гомдол, мэдээлэл	42
3. Хяналт тавьсан эрүүгийн хэрэг, түүний шийдвэрлэлт	46
4. Хяналт тавьсан зөрчлийн хэрэг, төрөл	69
5. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил	73

#### ШҮҮХ – COURT

1. Товч танилцуулга	76
2. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт	80
3. Зөрчлийн шийдвэрлэлт	93

#### ШҮҮХИЙН ШИЙДВЭР

#### ГҮЙЦЭТГЭЛ – CORRECTION

1. Товч танилцуулга	100
2. Хорих ялын шийдвэр гүйцэтгэл	102
3. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний шийдвэр гүйцэтгэл	106
4. Баривчлах шийтгэлийн гүйцэтгэл	115
5. Цагдан хорих арга хэмжээний шийдвэр гүйцэтгэл	116

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР -

### ANTI CORRUPTION

1. Товч танилцуулга	118
2. Гомдол, мэдээлэл	118
3. Мөрдөн шалгах ажиллагаа	120
4. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил	122
5. Монгол Улсын Авлигын индекс	122
6. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил	123

### ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭ –

#### FORENSIC

1. Товч танилцуулга	126
2. Хийсэн шинжилгээ К р и м и н а л и с т и к и й н шинжилгээ Шүүх эмнэлгийн шинжилгээ Эдийн засгийн шинжилгээ Тусгай шинжилгээ	129
3. Хэргийн газрын үзлэгт оролцсон байдал	135

### ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ –

#### CRIME VICTIM

1. Гэмт хэргийн хохирол, түүнийг нөхөн төлүүлэр эрх зүйн зохицуулалт	138
2. Цагдаагийн статистик	141
3. Прокурорын статистик	145
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тоон мэдээ	147

### НЭГДСЭН ДҮГНЭЛТ 150

### ЗӨВЛӨМЖ 153

### ЭХ СУРВАЛЖ 156

### ХАВСРАЛТ 160

**М**онгол Улсын Их Хурлаас 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдөр баталсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллага гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын судалгааг хоёр жил тутам гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг гурван жил тутам улсын хэмжээнд, эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд, эсхүл тодорхой гэмт хэрэг, зөрчлийн төрлөөр олон нийтийн дунд зохион байгуулна” хэмээн заасан нь гэмт хэргийн талаар хийх бүхий л судалгаа, эрдэм шинжилгээний ажлын хууль зүйн үндэслэл болсон билээ.

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх газраас жил бүр НҮБ-ын гишүүн 130 улсаас гэмт хэргийн чиг хандлагын судалгааны мэдээлэл цуглуулж, дэлхий нийтэд түгээхээс гадна тодорхой төрөл, чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийж, нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдалтай хэрхэн үр дүнтэй тэмцэх талаар санал, зөвлөмж боловсруулан гаргадаг.

Монгол Улс дэлхийн зарим улсын туршлагаар “Гэмт хэргийн цагаан ном” /white paper on crime/-ыг 2016 оноос эрхлэн гаргаж, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулж, олон нийтийн хүртээл болгосоор байна.

Энэ удаагийн “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2020”-ыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн захиалгаар Дотоод хэргийн их сургуулиас статистик, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагатай хамтран боловсруулж гаргалаа.

Энэхүү судалгааг хийхдээ өмнөх туршлага, уламжлал, жишгийг харгалзахын сацуу криминологийн шинжлэх ухааны орчин үеийн үзэл баримтлалын дагуу гэмт хэргийн төлөв байдал, түвшин, хөдөлгөөн, бүтэц, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийж, тодорхой дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулсан нь онол, практикийн ач холбогдолтой.

Гэмт хэргийн цагаан номыг бэлтгэхэд шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангасан шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтнууд, судалгааны үр дүнг боловсруулах, дүн шинжилгээ хийхэд хичээл зүтгэл гарган ажилласан судалгааны багийн гишүүдэд талархал илэрхийлье.

Гэмт хэргийн цагаан номыг улам сайжруулж, боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөгөө, шүүмжийг тус Их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн хаяганд ирүүлнэ үү

**П.БАТБААТАР**

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР (Ph.D),  
ПРОФЕССОР, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

## ТОВЧИЛСОН ҮГ

АТГ	Авлигатай тэмцэх газар
АТХХАБАЖЗГХ	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг
БГХ	Бүртгэсэн гэмт хэрэг
ГХМБТГ	Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар
МУГХУСАЗЗ	Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕЭЗК	Европын эдийн засгийн комисс
МХХ	Монголын хуульчдын холбоо
МША	Мөрдөн шалгах ажиллагаа
НААСЭГХ	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
НТАХЯ	Нийтэд тустай ажил хийлгэх ял
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОНАБАСЭГХ	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УПЕГ	Улсын прокурорын ерөнхий газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАБТХАЖЭГХ	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
ХБОЭГХ	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг
ХБМБ	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт
ХБЭЧХБЭГХ	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХТАБЭТЭГХ	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг
ХХУТЭЭЧЭГХ	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг
ХХЧБЭЭГХ	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг
ХЭМХБЭГХ	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦМАБЭГХ	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
SDG	Sustainable Development Goals
UNODC	United Nations Office on Drug and Crime

# МОНГОЛ УЛСАД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ (2020)

УЛСЫН ХЭМЖЭЭНД

23064 -26.8%


14633 -27.8%  
НИЙСЛЭЛД




8420 -24.8%  
ОРОН НУТАГТ



## ГЭМТ ХЭРГИЙН БҮТЭЦ




## АНГИЛАЛ



■ ХӨНГӨН (83.5%) ■ ХҮНД (16.5%) ■ ИЛ (59.2%) ■ ДАЛД (40.8%)

## ҮЙЛДЛИЙН АРГА



## ЗОНХИЛОХ ТӨРӨЛ




## ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ШИНЖ






АЙМГУУДАД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ



ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ





## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## ЦАГДАА - POLICE

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
3. ГЭМТ ХЭРЭГ
4. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА
5. ЗӨРЧИЛ
6. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРЭГ
7. ЭРҮҮЛЖҮҮЛСЭН ХҮН
8. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ



## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

### 1.Цагдаагийн байгууллагын танилцуулга

Монгол Улсын цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар хэрэгжүүлж ирсэн.

“Монголын цагдаагийн байгууллага” гэсэн тогтолцоо бие дааж бүрэлдэн тогтох үйл явц 1990 оны 4 дүгээр сард Нийгмийг аюулаас хамгаалах яамыг татан буулгаж, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрыг төрийн захиргааны төв байгууллагын түвшинд байгуулснаар эхэлж, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатайгаар хөгжих болсон.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийг УИХ-аас 1993 онд баталж, 1994 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр шинэ үеийн цагдаагийн байгууллагын үндэс суурь бүрэлдэж тогтсон ч нийгмийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулан 2017 онд УИХ-аас Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Цагдаагийн байгууллага нь Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Экологийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын алба, Тээврийн цагдаагийн алба, Интерполын үндэсний товчоо, Санхүү, аж ахуйн алба, Захиргааны удирдлагын газар, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас бүрдэнэ.

Шинэ төрлийн коронавируст (Covid-19) халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжсэн үед цагдаагийн байгууллага тэргүүн шугамд ажиллаж, халдвар тээгч болон хавьтлыг олж тогтоох, газар орныг бүсчлэн хаах, тусгаарлах байр, эмнэлгийн бүс, гудамж, зам талбайг хамгаалалтад авах, хөл хорионы дэглэм сахиулах, замын хөдөлгөөнийг зохицуулах, иргэд, олон нийтэд ухуулга, сурталчилгаа явуулах, эргүүл, хяналтын постуудад үүрэг гүйцэтгэсэн хэдий ч гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргээ биелүүлж ажилласан. Тухайлбал, энэ үед цагдаагийн байгууллагад иргэд, байгууллагаас 242094 дуудлага, мэдээлэл ирүүлсний 9433 нь гэмт хэргийн шинжтэй, 206432 нь зөрчлийн шинжтэй, 26229 нь зам тээврийн ослын шинжтэй, 19110 нь гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй байсан бөгөөд хуулийн хугацаанд шалган шийдвэрлэжээ.

Цаг үеийн онцлогтой холбоотойгоор гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал өөрчлөгдөн, хулгайлах болон гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчил буурсан бол хууль бусаар согтууруулах ундаа худалдах, тээврийн хэрэгслийн тусгай зөвшөөрлийг хуурамчаар үйлдэх, цахим орчинд хуурамч мэдээлэл тараах, мөрийтэй тоглох, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг, зөрчил нэмэгдсэн.

### 2.Гомдол, мэдээлэл

Цагдаагийн байгууллага нь 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 260,357 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 67,547 буюу 25.9% нь гэмт хэргийн шинжтэй, 192,810 буюу 74.1% нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл иржээ. Өмнөх онтой харьцуулбал, гомдол, мэдээлэл 1178 буюу 0.5%-иар өссөн, гэмт хэргийн шинжтэй гомдол 6,612 буюу 8.9%-иар буурсан, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 7,790 буюу 4.2%-иар өсжээ.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 25,721 буюу 38.1%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 38,867 буюу 57.5%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 599 буюу 0.9%-ийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэжээ. Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 104,996 буюу 54.5%-ийг зөрчлийн хэрэг нээж, 85,853 буюу 44.5%-ийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 947 буюу 0.5%-ийг харьяаллын дагуу шилжүүлжээ<sup>1</sup>.

<sup>1</sup> Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны “Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2020”. УБ., 2021. 11 дэх тал.



Хүснэгт №1. Цагдаагийн байгууллагад ирүүлсэн дуудлага, мэдээллийг бүртгэсэн нэгжээр нь харуулав.

№	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Өмнөх үлдэгдэл гомдол, мэдээлэл	Үүнээс		Тухайн онд шинээр хүлээн авсан гомдол, мэдээлэл	Нийт шалгасан гомдол, мэдээлэл
			Шийдвэрлэсэн.			
А		1	2	3	4	
1	Баруун бүс	Баян-Өлгий	20	19	2523	2543
2		Говь-Алтай	7	1	1381	1388
3		Завхан	8	4	1143	1151
4		Үүнээс: Тосонцэнгэл	2	1	338	340
5		Увс	10	10	1583	1593
6		Ховд	9	5	3155	3164
7		Үүнээс : Булган	3	1	553	556
8	Хангайн бүс	Архангай	13	4	2064	2077
9		Баянхонгор	19	9	4825	4844
10		Булган	8	5	2683	2691
11		Орхон	59	55	6183	6242
12		Өвөрхангай	35	32	5417	5452
13		Үүнээс: Хархорин	4	2	1158	1162
14		Хөвсгөл	12	10	3950	3962
15	Төвийн бүс	Говьсүмбэр	3		886	889
16		Дархан-Уул	18	11	4527	4545
17		Дорноговь	21	9	1963	1984
18		Үүнээс: Замын-Үүд	10	7	787	797
19		Дундговь	15	13	1556	1571
20		Өмнөговь	21	20	3279	3300
21		Үүнээс:Цогтцэций сум	3	3	847	852
22		Сэлэнгэ	37	25	3159	3196
23		Үүнээс: Мандал	10	8	1227	1237
24		Төв	39	30	4181	4220
25	Үүнээс: Заамар	4	2	1096	1100	
26	Зүүн бүс	Дорнод	48	43	5797	5845
27		Сүхбаатар	20	12	2505	2525
28		Хэнтий	27	19	3738	3765
29		Үүнээс: Бор-Өндөр	10	6	898	908
30	Нийслэл	1788	1253	158152	159940	
31	Баянгол	254	210	24749	25003	
32	I хэлтэс	138	116	12718	12856	
33	II хэлтэс	116	94	12031	12147	
34	Баянзүрх	477	359	44339	44816	
35	I хэлтэс	196	136	17388	17584	
36	II хэлтэс	199	156	12743	12942	
37	III хэлтэс	82	67	14208	14290	
38	Сүхбаатар	314	210	18083	18397	
39	I хэлтэс	193	128	8838	9031	
40	II хэлтэс	121	82	9245	9366	
41	Сонгинохайрхан	369	254	34252	34621	
42	I хэлтэс	143	107	16246	16389	
43	II хэлтэс	103	68	9750	9853	
44	III хэлтэс	123	79	8256	8379	
45	Хан-Уул	141	74	15231	15372	

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2020

46	I хэлтэс	71	31	7323	7394
47	II хэлтэс	70	43	7908	7978
48	Чингэлтэй	206	129	15759	15965
49	I хэлтэс	122	77	6960	7082
50	II хэлтэс	84	52	8799	8883
51	Багануур	9	7	1694	1703
52	Багахангай	6	3	257	263
53	Налайх	12	7	3788	3800
54	ИАТ	6	1	35	41
55	Төмөр зам	6	5	312	318
56	Мөрдөн байцаах алба	4		215	219
57	Эрүүгийн цагдаагийн алба	25	2	527	552
58	Тээврийн цагдаагийн алба	21	20	31532	31553
59	Экологийн цагдаагийн алба			293	293
60	НЦУГ	ХГХМХ	1	38	39
61		ХОХГХТХ	9	30	39
62		Халаасны хулгай	10	1	58
63	Хар тамхитай тэмцэх газар	4	3	207	211
64	НХЖХ, ОНАБХА	3	1	134	137
65	Улсын дүн	2326	1622	258031	260357

Ирүүлсэн дуудлага, мэдээллийг өнгөөр нь авч үзвэл, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 24844, хулгайлах 27414, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг 52592, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 37890 тус тус эзэлж байна.

Хүснэгт №2. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт.

№	Бус	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Хэрэгсэхгүй болгосон хэрэг 32.5 /ЭХХШТХ-ийн зүйл, хэсэг/			Хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан 1.5 /ЭХХШТХ-ийн зүйл, хэсэг/			Бүгд	Үүнээс											
			32.5.1.1	32.5.1.2	32.5.1.3	1.5.1.1	1.5.1.4	1.5.1.5		Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 10.1-10.6	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 11.1-11.7	Хүчиндэх 12.1	Хулгайлах 17.1	Дээрэмдэх 17.2	Залилах 17.3	Хөрөнгө завших 17.4	Мал хулгайлах 17.12	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах 20.16	Автомобилын хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 27.10	Бусад	
А			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	
1	Баруун бус	Баян-Өлгий	4			9			13	4			1		2	1	1		2	2	
2		Говь-Алтай	3			14			17	3	1	1	4		2	4					2
3		Завхан				2			2												2
4		Үүнээс: Тосонцэнгэл					1			1											1
5		Увс					15			15	1			1				5		1	7
6		Ховд	1				17			18	1	2	2	3				7			3
7		Үүнээс: Булган					4			4		1		1							2
8	Хангайн бус	Архангай				44			44		1		12		11	3	3			14	
9		Баянхонгор	1			16			17	1	3		3	1		1	3		3	2	
10		Булган	2			17			19	2	2		1		1	3	4			6	
11		Орхон				23			23	2	2	2	2	1	8	1				1	4
12		Өвөрхангай				15			15		1	1	6	1						2	4
13		Үүнээс: Хархорин					7			7		1		3	1						2
14		Хөвсгөл	2				60			62	2	8	5	16		7	1	5		5	13
15	Төвийн бус	Говьсүмбэр	2			8			10	2	1	1	2				1			3	
16		Дархан-Уул	2			12			14	2	2		2		2					6	
17		Дорноговь	10				82			92	11	6		30	1	14	3	8		3	16



18	Үүнээс: Замын-Үүд	1	18	19	1	3	6	2	1	6									
19	Дундговь	1	15	16	1	6	5	1	1	2									
20	Өмнөговь	7	28	35	6	7	12	4	2	2									
21	Үүнээс: Цогтцэций	3	12	15	2	2	7	1	2	1									
22	Сэлэнгэ	7	45	52	7	3	13	1	6	1	5								
23	Үүнээс: Мандал	7	14	21	7	2	3	1	1	1									
24	Төв		10	10	1		3	1	1										
25	Үүнээс: Заамар		2	2				1											
26	Дорнод		22	22	2		11	1	3		3								
27	Сүхбаатар		3	3			1				1								
28	Хэнтий	3	31	34	3	2	2	7	1	1	10								
29	Үүнээс: Бор-Өндөр		4	4			1				2								
30	Нийслэл	69	717	1 787	70	61	9	346	16	121	4	3							
31	Баянгол	18	83	101	17	14	1	34	1	19									
32	I хэлтэс	11	23	34	12	6	1	6		8									
33	II хэлтэс	7	60	67	5	8		28	1	11									
34	Баянзүрх	27	132	159	26	12	4	70	5	28									
35	I хэлтэс	11	28	39	11	3	3	6	2	7									
36	II хэлтэс	7	83	90	6	5	1	57	3	16									
37	III хэлтэс	9	21	30	9	4		7		5									
38	Сүхбаатар	7	212	1 220	7	12		124	4	28	3								
39	I хэлтэс	3	90	1 94	3	5		34	3	24	1								
40	II хэлтэс	4	122	126	4	7		90	1	4	2								
41	Сонгинохайрхан	6	83	89	8	14	2	36	2	13		1							
42	I хэлтэс	2	51	53	3	12	2	23		8		1							
43	II хэлтэс	3	18	21	4	1		7	1	4									
44	III хэлтэс	1	14	15	1	1		6	1	1									
45	Хан-Уул	2	141	143	2	3	1	51	1	22	1								
46	I хэлтэс		89	89	1	1		22		7	1								
47	II хэлтэс	2	52	54	2	2		29	1	15									
48	Чингэлтэй	7	56	63	7	6	1	29	3	9									
49	I хэлтэс	3	34	37	3	4		14	3	8									
50	II хэлтэс	4	22	26	4	2	1	15		1									
51	Багануур	2	5	7	2			2		2									
52	Багахангай																		
53	Налайх		5	5	1						2								
54	Бусад		1	1						1									
55	ИАТ																		
56	Төмөр зам		4	4	1	1					1								
57	Мөрдөн байцаах алба		7	7															
58	Эрүүгийн цагдаагийн алба	1	6	7															9
59	Тээврийн цагдаагийн алба		9	9															
60	НЦУГ ХГХТХ																		
61	НЦУГ ХОХГХТХ		5	5	1		4												
62	ХТТГ		3	3															3
63	Экологийн цагдаагийн алба		5	5															5
64	Улсын дүн	114	1206	1 1321	118	105	24	481	23	189	25	60						33	263



### 3. Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллага 2020 онд нийт **23064**, Улаанбаатар хотод **14633 буюу** 63.4%, орон нутагт 8420 буюу 36.5%, бусад газар (хилийн чанадад үйлдсэн) 11 буюу 0.1% гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Улсын хэмжээнд нийт 8460 хэрэг буюу 26.8%-иар,
- Нийслэлийн хэмжээнд 5628 хэрэг буюу 27.8%-иар,
- Орон нутгийн хэмжээнд 2784 хэрэг буюу 24.8%-иар,
- Бусад газар (хилийн чанадад)-т 48 хэрэг буюу 81.4%-иар тус тус буурсан.

#### 3.1. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг)

2020 онд цагдаагийн байгууллагад нийт 23064 гэмт хэрэг шинээр бүртгэсэн. Тэдгээрээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 382 шинээр бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 1.7%-ийг эзэлж байна. Энэ бүлгийн гэмт хэрэг нь өмнөх оноос 254 буюу 39.9%-иар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 51.9%-тай байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад, 7%-иар өсжээ.

##### 3.1.1. Хүнийг алах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл)

2020 онд 192 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 5 буюу 2.5%-иар буурчээ. Улсын хэмжээнд нийт бүртгэсэн 23064 гэмт хэргийн 192 буюу 0.8%-ийг хүнийг алах гэмт хэрэг эзэлж байна. Харин нийслэлийн хэмжээнд хүнийг алах гэмт хэрэг 95 бүртгэсэн нь өмнөх оны түвшинд байгаа бол, орон нутгийн хэмжээнд 97 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 10 хэргээр буюу 11.5%-иар өсжээ.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 24 буюу 12.5% нь Даваа гарагт, 21 буюу 10.9% нь Мягмар гарагт, 31 буюу 16.1% нь Лхагва гарагт, 37 буюу 19.3% нь Пүрэв гарагт, 31 буюу 16.1% нь Баасан гарагт, 25 буюу 13.1% нь Бямба гарагт, 23 буюу 12.0% нь Ням гарагт тус тус бүртгэсэн. Цагаар нь авч үзвэл, 35 буюу 18.2% нь 06:00-14:00 цагт, 37 буюу 19.3% нь 14:00-19:00 цагт, 42 буюу 21.9% нь 19:00-22:00 цагт, 78 буюу 40.6% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Гэмт хэрэг үйлдсэн газрыг авч үзвэл, бүртгэсэн гэмт хэргийн 121 буюу 63% нь гэр, орон сууцанд, 26 буюу 13.5% нь гудамж, талбайд, 6 буюу 3.1% нь олон нийтийн газарт, 1 буюу 0.5% нь аж ахуйн нэгжид, 3 буюу 1.6% нь төрийн байгууллагад, 1 буюу 0.1% нь авто замд, 35 буюу 18.2% нь бусад газарт үйлдсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал.* Хүнийг алах гэмт хэргийн 141 буюу 73.4% нь согтуугаар, 1 буюу 0.5% нь хүүхэд оролцож, 19 буюу 9.9% нь эмэгтэй хүн оролцож, 10 буюу 5.2%-ийг бүлэглэн үйлджээ.

*Гэмт хэргийн илрүүлэлт.* Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 98.5% байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 100% байгаа нь 3.0 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 95.8% байгаа нь 3.0 нэгжээр тус тус өссөн байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Хүнийг алах гэмт хэрэгт нийт 211 хүнийг холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 5 буюу 2.3%-иар буурсан, холбогдогчдын 21 буюу 9.9% нь эмэгтэй, 190 буюу 90.1% нь эрэгтэй, 1 буюу 0.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 5%-иар, хүүхэд 87.5%-иар тус тус буурч, эмэгтэй хүн 31.3%-иар өсжээ.

*Хохирогч.* Гэмт хэргийн улмаас 196 иргэн хохирсноос 190 хүн нас барж, өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 2 буюу 1%-иар тус тус буурч, гэмтсэн хүн 2.0 дахин өссөн байна.

*Учирсан хохирол.* Энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 798.3 сая төгрөгийн хохирлын 86.1%-ийг нөхөн төлүүлж, 158.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 234.9 сая төгрөг буюу 22.8%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 122.1 сая буюу 15.1%-иар, битүүмжилсэн хөрөнгө 17.2 сая төгрөг буюу 9.8%-иар тус тус буурсан байна.

#### 3.2. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг)

2020 онд цагдаагийн байгууллагад нийт 23064 гэмт хэрэг шинээр бүртгэсэн



бөгөөд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7405 шинээр бүртгэсэн нь нийт хэргийн 32.1%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд өмнөх оноос 860 хэргээр буюу 10.4%-иар, нийслэлийн хэмжээнд 4564 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 619 хэргээр буюу 13%-иар, орон нутагт 2841 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 241 хэргээр буюу 8.5%-иар тус тус буурчээ.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг үйлдсэн гарагаар нь авч үзвэл, 1034 буюу 14% нь Даваа гарагт, 1072 буюу 14.% нь Мягмар гарагт, 996 буюу 13.5% нь Лхагва гарагт, 1017 буюу 13.7% нь Пүрэв гарагт, 1065 буюу 14.4% нь Баасан гарагт, 1086 буюу 14.6% нь Бямба гарагт, 1135 буюу 15.3% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 1085 буюу 14.6% нь 06:00-14:00 цагт, 1736 буюу 23.4% нь 14:00-19:00 цагт, 1551 буюу 21% нь 19:00-22:00 цагт, 3033 буюу 41% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Гэмт хэрэг үйлдсэн газрыг авч үзвэл, бүртгэсэн гэмт хэргийн 3264 буюу 44.1% нь гудамж, талбайд, 2034 буюу 27.5% нь гэр, орон сууцанд, 842 буюу 11.4% нь олон нийтийн газарт, 10 буюу 0.1% нь нийтийн тээвэрт, 41 буюу 0.5% нь төрийн байгууллагад, 24 буюу 0.3% нь төрийн бус байгууллагад, 266 буюу 3.6% нь аж ахуйн нэгжид 1 буюу 0.2% нь төрийн бус байгууллагад, 8 буюу 0.1% нь авто замд, 916 буюу 12.2% нь бусад газарт үйлджээ.

*Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 3677 буюу 49.7% нь согтуугаар, 224 буюу 3% нь хүүхэд оролцож, 863 буюу 11.7% нь эмэгтэй хүн оролцож, 228 буюу 3.1%-ийг бүлэглэн үйлдсэн байна

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Холбогдогчдын 830 буюу 12.% нь эмэгтэй, 5976 буюу 87.8% нь эрэгтэй, 254 буюу 3.7% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 67 буюу 1.1%-иар, хүүхэд 7 буюу 2.8%-иар, эмэгтэй хүн 67 буюу 8.8%-иар тус тус өссөн байна.

*Хохирогч.* Гэмт хэргийн улмаас 7798 иргэн хохирч, үүнээс 19 нь нас барж, 7202 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 744 буюу 8.7%-иар, гэмтсэн хүн 214 буюу 2.9%-иар тус тус буурч, нас барсан хүн 6 буюу 46.1%-иар өссөн. Гэмтсэн иргэдийн гэмтлийн зэргээр нь авч үзвэл, 6325 буюу 87.8% нь хөнгөн, 550 буюу 7.6% нь хүндэвтэр, 327 буюу 4.5% нь хүнд гэмтэл учирсан байна.

*Учирсан хохирол.* Хэргийн улмаас иргэнд учирсан 7795.3 сая төгрөгийн хохирлын 81.4%-ийг нөхөн төлүүлж, 424.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 567.3 сая буюу 7.9%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 615.4 сая буюу 10.7%-иар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 584.8 сая буюу 58%-иар буурсан байна.

**3.2.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл)** 2020 онд цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 111 шинээр бүртгэсэн нь нийт бүртгэсэн гэмт хэргийн 0.5%-ийг эзэлж, өмнөх оноос 96 хэргээр буюу 46.4%-иар буурсан байна.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 170 буюу 15% нь Даваа гарагт, 179 буюу 15.7% нь Мягмар гарагт, 146 буюу 12.8% нь Лхагва гарагт, 167 буюу 14.7% нь Пүрэв гарагт, 163 буюу 14.3% нь Баасан гарагт, 127 буюу 11.2% нь Бямба гарагт, 186 буюу 16.3% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 191 буюу 16.8% нь 06:00-14:00 цагт, 283 буюу 24.9% нь 14:00-19:00 цагт, 244 буюу 21.4% нь 19:00-22:00 цагт, 420 буюу 36.9% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Гэмт хэрэг бүртгэсэн газрыг авч үзвэл, гэмт хэргийн 973 буюу 85.5% нь гэр, орон сууцанд, 74 буюу 6.5% нь гудамж талбайд, 18 буюу 1.5% нь олон нийтийн газарт, 2 буюу 0.2% нь нийтийн тээвэрт, 3 буюу 0.3% нь төрийн байгууллагад, 10 буюу 0.9% нь аж ахуйн нэгжид, 58 буюу 5.1% нь бусад газарт үйлдсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 655 буюу 57.6% нь согтуугаар, 7 буюу 0.6% нь хүүхэд оролцож, 100 буюу 8.8% нь эмэгтэй хүн оролцож, 12 буюу 1.1%-ийг бүлэглэн үйлдсэн байна.

**Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.** Нийт 1152 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 108 буюу 10.3%-иар өссөн. Холбогдогчдын 1058 буюу 91.8% нь эрэгтэй, 94 буюу 8.2% нь эмэгтэй, 6 буюу 0.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 90 буюу 9.3%-иар, хүүхэд 3 буюу 50%-иар, эмэгтэй хүн 18 буюу 23.7%-иар тус тус өссөн байна.

**Хохирсон хүн.** Гэмт хэргийн улмаас 1082 иргэн, хохирч үүнээс 953 хүн гэмтэж, 18 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 188 буюу 21%-иар, гэмтсэн хүн 221 буюу 30.2%-иар, нас барсан хүн 10 буюу 2.3 дахин өсч, энэ гэмт хэргийн улмаас 928.3 сая төгрөгний хохирол учирсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 562, хамтран амьдрагч 239, нөхөр 47, төрсөн хүүхэд 44, төрсөн ах, эгч 7, дагавар хүүхэд 38, төрсөн эцэг, эх 25, төрсөн дүү 7, хадам эцэг, эх 8, үрчилж авсан хүүхэд 1, өвөг эцэг, эмэг эх 2, бусад 102 хүн байна.

График №1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчид.



**3.2.2. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл).** 2020 онд цагдаагийн байгууллагад хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг 301 шинээр бүртгэсэн нь нийт хэргийн 1.3%-ийг эзэлж, өмнөх оноос 63 хэргээр буюу 26.5%-иар, нийслэлийн хэмжээнд 162 гэмт хэрэг өмнөх оноос 63 хэргээр буюу 26.5%-иар тус тус өсч, орон нутагт 139 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх онтой адил түвшинд байна.

**3.2.3. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйл)** Цагдаагийн байгууллагад 2020 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэг 6373 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 27.6%-ийг дангаараа эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 1018 хэргээр буюу 13.7%-иар буурчээ.

Нийслэлийн хэмжээнд хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 3973 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 790 хэргээр буюу 16.5%-иар, орон нутагт 2400 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 226 хэргээр буюу 8.6%-иар тус тус буурсан байна.

**3.3. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг)** 2020 онд Монгол Улсад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 505 шинээр бүртгэсэн нь нийт бүртгэсэн гэмт хэргийн 2.2%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд шинээр бүртгэсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос 105 хэргээр буюу 17.2%-иар буурсан, нийслэлийн хэмжээнд 255 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 6 хэргээр буюу 2.3%-иар өссөн бол, орон нутагт өмнөх оноос 111 хэргээр буюу 18.1%-иар буурсан, гэмт хэргийн илрүүлэлт 54.2% байна.

**3.3.1. Хүчиндэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл)** Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2020 онд 505 бүртгэсэн нь нийт хэргийн 2.2%-ийг эзэлж байна.

Энэ төрлийн гэмт хэргээс хүчиндэх гэмт хэрэг 401 буюу 79.4%, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 14 буюу 2.7%-ийг эзэлж байна. 2019 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 0.8%-ийг эзэлж байсан бол 2020 онд 3.5%-ийг эзлэх болжээ.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 66 буюу 16.5% нь Даваа гарагт, 65 буюу 16.2% нь Мягмар гарагт, 61 буюу 15.2% нь Лхагва гарагт, 60 буюу 15% нь Пүрэв гарагт, 52 буюу 13% нь Баасан гарагт, 55 буюу 13.7% нь Бямба гарагт, 42 буюу 10.4% нь Ням гарагт тус тус үйлдсэн. Цагаар нь авч үзвэл, 86 буюу 21.4% нь 06:00-14:00 цагт, 107 буюу 26.7% нь 14:00-19:00 цагт, 45 буюу 11.2% нь 19:00-22:00 цагт, 163 буюу 40.7% нь 22:00-06:00 цагт тус тус үйлджээ.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Хүчиндэх гэмт хэргийг үйлдсэн газрыг авч үзвэл, бүртгэсэн гэмт хэргийн 259 буюу 64.4% нь гэр, орон сууцанд, 36 буюу 9% нь гудамж талбайд, 22 буюу 5.5% нь олон нийтийн газарт, 7 буюу 1.7% нь аж ахуйн нэгжид, 2 буюу 0.5% нь нийтийн тээвэрт, 75 буюу 18.9% нь бусад газарт үйлдсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал.* Нийт бүртгэсэн хүчиндэх гэмт хэргийн 124 буюу 30.9% нь согтуугаар, 20 буюу 5% нь хүүхэд оролцож, 3 буюу 0.7% нь эмэгтэй хүн оролцож, 53 буюу 13.2% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 15 буюу 3.7% нь бүлэглэн үйлдсэн байна.

*Гэмт хэргийн илрүүлэлт.* Хүчиндэх гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 56.4% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.6 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 50% байгаа нь 2.8 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 63.8% байгаа нь 2.3 нэгжээр тус тус өссөн байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Хүчиндэх гэмт хэрэгт нийт 294 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 20 буюу 6.4%-иар буурсан. Холбогдогчдын 1 буюу 0.3% нь эмэгтэй, 293 буюу 99.7% нь эрэгтэй, 20 буюу 6.8% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 5.8%-иар, эмэгтэй хүн 66.7%-иар тус тус буурч, хүүхэд 3 буюу 17.6%-иар өссөн байна.

*Хохирогч.* Хүчиндэх гэмт хэргийн улмаас 406 иргэн хохирч, үүнээс 1 хүн нас барж, 52 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс хохирсон хүн 86 буюу 17.5%-иар, нас барсан хүн 2 буюу 66.7%-иар, гэмтсэн хүн 84 буюу 32%-иар тус тус буурсан.

Хохирсон иргэдийн 248 буюу 61.1% нь 17 хүртэлх насны хүүхэд байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон 10 хүний 6 нь хүүхэд байна гэсэн үг юм. Хохирсон хүүхдийг насаар нь авч үзвэл 15 буюу 6.1% нь 7 хүртэлх, 98 буюу 39.5% нь 8-13 насны, 135 буюу 54.4% нь 14-17 насны хүүхэд байна.

**3.4. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг)** 2020 онд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 189 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.9%-ийг эзэлж байна.

Улсын хэмжээнд уг төрлийн 189 гэмт хэрэг, нийслэлд 130 бүртгэсэн нь өмнөх оныхтой харьцуулахад, 41 гэмт хэрэг буюу 46%-иар өссөн үзүүлэлттэй байна. Орон нутагт 59 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оныхоос 33 хэргээр буюу 66.2%-иар өсжээ.

**3.5. Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 14 дүгээр бүлэг)** 2020 онд 5 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 2 хэргээр буюу 66%-иар өссөн байна. Нийслэлийн хэмжээнд 1 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 1 хэргээр буурсан.

**3.6. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлэг)** 2020 онд 22 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 17 хэргээр буюу 43.6%-иар, нийслэлийн хэмжээнд 16 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 12 хэргээр буюу 42.8%-иар, орон нутагт 6 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оныхоос 5 хэргээр буюу 45.4%-иар тус тус буурсан байна.

**3.7. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэг)** 2020 онд хүүхдийн эсрэг 17 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 14 хэргээр буюу 45.2%-иар, нийслэлийн хэмжээнд 13 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 13 хэргээр буюу 50%-иар, орон нутагт 4 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 1 нэгжээр тус тус буурсан байна.

Энэ төрлийн гэмт хэргээс хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах 8 (47%), хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх 6 (35.2%) гэмт хэрэг бүртгэсэн нь нийт бүртгэсэн энэ бүлгийн гэмт хэргийн 82%-ийг эзэлж байна.

**3.8.Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг)** 2020 онд цагдаагийн байгууллагад өмчлөх эрхийн эсрэг 12061 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь нийт хэргийн 52.3%-ийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 6280 хэргээр буюу 34.2%-иар, нийслэлийн хэмжээнд 8355 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 4271 хэргээр буюу 33.8%-иар тус тус буурч, орон нутагт шинээр 3706 бүртгэсэн нь өмнөх оноос 2009 хэргээр буюу 35%-иар буурсан үзүүлэлттэй байна.

**3.8.1.Хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл)** 2020 онд цагдаагийн байгууллагад хулгайлах гэмт хэрэг 5100 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 22.1%-ийг эзэлж, өмнөх оноос 3868 хэргээр буюу 43.1%-иар, нийслэлийн хэмжээнд 3481 бүртгэсэн нь өмнөх оноос 3056 хэргээр буюу 46.7%-иар, орон нутагт 1619 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 812 хэргээр буюу 33.4%-иар тус тус буурсан байна.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 811 буюу 15.9% нь Даваа гарагт, 765 буюу 15% нь Мягмар гарагт, 708 буюу 13.9% нь Лхагва гарагт, 770 буюу 15.1% нь Пүрэв гарагт, 694 буюу 13.6% нь Баасан гарагт, 654 буюу 12.8% нь Бямба гарагт, 698 буюу 13.7% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 1365 буюу 26.8% нь 06:00-14:00 цагт, 1374 буюу 26.9% нь 14:00-19:00 цагт, 555 буюу 10.9% нь 19:00-22:00 цагт, 1806 буюу 35.4% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Гэмт хэрэг үйлдсэн газрыг авч үзвэл, үйлдсэн гэмт хэргийн 2404 буюу 47.1% нь гэр, орон сууцанд, 918 буюу 18% нь гудамж талбайд, 612 буюу 12% нь олон нийтийн газарт, 404 буюу 7.9% нь аж ахуйн нэгжид, 1 буюу 0.1% нь авто замд, 761 буюу 14.9% нь бусад газарт үйлдсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 387 буюу 7.6% нь согтуугаар, 355 буюу 7% нь хүүхэд оролцож, 283 буюу 5.5% нь эмэгтэй хүн оролцож, 413 буюу 8.1% нь бүлэглэн үйлдсэн байна

*Гэмт хэргийн илрүүлэлт.* Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 37.4% байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.9 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 33.4% байгаа нь 9.9 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 47.1% байгаа нь 4.5 нэгжээр тус тус өссөн байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Нийт 2821 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 629 буюу 18.2%-иар буурсан. Холбогдогчдын 251 буюу 8.9% нь эмэгтэй, 2570 буюу 91.1% нь эрэгтэй, тэдний 480 буюу 16.7% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй 18.4%-иар, эмэгтэй 16.1%-иар, хүүхэд 38.7%-иар тус тус буурсан байна.

*Хохирсон хүн, хуулийн этгээд.* Гэмт хэргийн улмаас 5141 иргэн, 8 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 3863 буюу 42.9%-иар, хуулийн этгээд 7 буюу 46.7%-иар тус тус буурсан. Хүн, хуулийн этгээдэд учирсан 11128.8 сая төгрөгийн хохирлын 30.1%-ийг нөхөн төлүүлж, 351.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс 7561.8 сая төгрөг буюу 40.5%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 366.6 сая буюу 9.9%-иар, битүүмжилсэн хөрөнгө 59.8 сая төгрөг буюу 14.6%-иар тус тус буурсан байна.

**3.8.1.1.Мал хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл)** Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагад 1041 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 4.5 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 768 хэргээр буюу 42.5%-иар, нийслэлийн хэмжээнд 63 бүртгэсэн нь 65 хэргээр буюу 50.8%-иар, орон нутгийн хэмжээнд 978 бүртгэсэн нь 703 хэргээр буюу 41.8%-иар тус тус буурсан байна.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 135 буюу 13% нь Даваа гарагт, 166 буюу 15.9% нь Мягмар гарагт, 159 буюу 15.3% нь Лхагва гарагт, 132 буюу 12.7% нь Пүрэв гарагт, 169 буюу 16.2% нь Баасан гарагт, 128 буюу 12.3% нь Бямба гарагт, 152 буюу 14.6% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 148 буюу 14.2% нь 06:00-14:00 цагт, 173 буюу 16.6% нь 14:00-19:00 цагт, 146 буюу 14% нь 19:00-22:00 цагт, 574 буюу 55.2% нь 22:00-06:00 цагт тус тус үйлдсэн байна.



*Гэмт хэрэг үйлдсэн байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 33 буюу 3.2% нь согтуугаар, 10 буюу 1% нь хүүхэд оролцож, 20 буюу 1.9% нь эмэгтэй хүн оролцож, 252 буюу 24.2% нь бүлэглэн, 659 буюу 63.3% нь тээврийн хэрэгсэл ашиглаж тус тус үйлдсэн байна

*Гэмт хэргийн илрүүлэлт.* Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 48.3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.1 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 16.4% байгаа нь 4.3 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 50.6% байгаа нь 7.2 нэгжээр тус тус өссөн байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Нийт 933 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 257 буюу 21.6%-иар буурсан. Холбогдогчдын 17 буюу 1.8% нь эмэгтэй, 916 буюу 98.2% нь эрэгтэй, 10 буюу 1.1% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 21.6%-иар, эмэгтэй хүн 19.1%-иар, хүүхэд 73.7%-иар тус тус буурсан байна.

*Хохирогч.* Гэмт хэргийн улмаас 1054 иргэн, 1 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 768 буюу 42.2%-иар буурсан.

*Учирсан хохирол.* Хэргийн улмаас иргэдэд учирсан 4390.9 сая төгрөгийн хохирлын 45.5%-ийг нөхөн төлүүлж, 620.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 3152.7 сая төгрөгөөр буюу 41.8%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 730.2 сая төгрөг буюу 26.8%-иар тус тус буурсан байна.

*Алдагдсан малын тоо.* Адуу 2960, Үхэр 1991, Тэмээ 72, Ямаа 2229, Хонь 5683 байна.

**3.8.2.Залилах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйл)** Энэ төрлийн гэмт хэрэг 2020 онд 4270 бүртгэсэн нь өмнөх оноос 418 хэргээр буюу 8.9%-иар, нийслэлийн хэмжээнд 3621 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 238 буюу 6.1%-иар, орон нутагт 649 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 180 хэргээр буюу 21.9%-иар тус тус буурсан дүнтэй байна. Энэ зүйлд заасан гэмт хэрэг 4270 бүртгэсэн нь нийт бүртгэсэн гэмт хэргийн 18.5%-ийг эзэлж байна.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 708 буюу 16.6% нь Даваа гарагт, 690 буюу 16.2% нь Мягмар гарагт, 681 буюу 15.9% нь Лхагва гарагт, 610 буюу 14.3% нь Пүрэв гарагт, 698 буюу 16.3% нь Баасан гарагт, 465 буюу 10.9% нь Бямба гарагт, 418 буюу 9.8% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 1735 буюу 40.6% нь 06:00-14:00 цагт, 1703 буюу 39.9% нь 14:00-19:00 цагт, 397 буюу 9.3% нь 19:00-22:00 цагт, 435 буюу 10.2% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Гэмт хэрэг үйлдсэн газрыг авч үзвэл, бүртгэсэн гэмт хэргийн 1140 буюу 26.7% нь гэр, орон сууцанд, 658 буюу 15.4% нь гудамж талбайд, 410 буюу 9.6% нь олон нийтийн газарт, 962 буюу 22.5% нь аж ахуйн нэгжид, 1 буюу 0.1% нь авто замд, 1099 буюу 25.7% нь бусад газарт үйлдсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 25 буюу 0.6% нь согтуугаар, 69 буюу 1.0% нь хүүхэд оролцож, 1526 буюу 35.7% нь эмэгтэй хүн оролцож, 143 буюу 3.3% нь бүлэглэн үйлдсэн байна.

*Гэмт хэргийн илрүүлэлт.* Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 40.7% байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.8 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 41.8% байгаа нь 9.1 нэгжээр тус тус өсөж, орон нутгийн хэмжээнд 35.4% байгаа нь 5.8 нэгжээр буурсан байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Нийт 2269 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 441 буюу 24.1%-иар өссөн. Холбогдогчдын 1279 буюу 56.4% нь эмэгтэй, 990 буюу 43.6% нь эрэгтэй, тэдний 70 буюу 3.1% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эмэгтэй хүн 2.0 дахин өсөж, эрэгтэй хүн 17.3%-иар, хүүхэд 30%-иар тус тус буурсан байна.

*Хохирогч.* Гэмт хэргийн улмаас 4273 иргэн, 4 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 418 буюу 8.9%-иар, хуулийн этгээд 4 буюу 50%-иар тус тус буурсан.

*Учирсан хохирол.* Хүн, хуулийн этгээдэд учирсан 65747.4 сая төгрөгийн хохирлын 38.3%-ийг нөхөн төлүүлж, 1435.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс

учирсан хохирол 23784.8 сая буюу 26.6%-иар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 11942.4 сая буюу 90.2%-иар, битүүмжилсэн хөрөнгө 700.5 сая буюу 95.3%-иар тус тус өссөн байна.

**3.9.Эдийн засгийн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэг)** 2020 онд 123 эдийн засгийн гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 124 хэргээр буюу 50.2%-иар, орон нутагт шинээр 53 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 64 хэргээр буюу 54.7%-иар, харин нийслэлд 70 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 60 хэргээр буюу 46.1%-иар тус тус буурсан байна.

**3.10.Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 19 дүгээр бүлэг)** 2020 онд үндэсний аюулгүй байдлын эсрэг 1 гэмт хэрэг шинээр бүртгэсэн өмнөх оноос 28 нэгжээр буюу 96.5%-иар буурсан байна. Энэ бүлэгт заасан гэмт хэрэгт шалгагдсан хүн болон хохирлын талаар мэдээлэл байхгүй байна.

**3.11.Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг)** 2020 онд энэ бүлэгт заасан гэмт хэрэг 291 шинээр бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 1.3%-ийг эзэлж, өмнөх оноос 42 хэргээр буюу 12.6%-иар, нийслэлд 237 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 5 хэргээр буюу 2.0%-иар, орон нутагт 54 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 37 хэргээр буюу 11.1%-иар тус тус буурсан байна.

**3.11.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйл)** Цагдаагийн байгууллагад нийт 23064 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд нийт гэмт хэрэгт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 0.87%-ийг эзэлж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020 онд 202 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 55 гэмт хэргээр буюу 21.4 хувиар, нийслэлийн хэмжээнд 178 бүртгэгдсэн нь 23 гэмт хэргээр буюу 11.4 хувиар, орон нутгийн хэмжээнд 24 бүртгэгдсэн нь 32 гэмт хэргээр буюу 57.1 хувиар тус тус буурсан байна.

*Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 36 буюу 17.8% нь Даваа гарагт, 40 буюу 19.8% нь Мягмар гарагт, 36 буюу 17.8% нь Лхагва гарагт, 28 буюу 13.9% нь Пүрэв гарагт, 32 буюу 15.8% нь Баасан гарагт, 22 буюу 10.9% нь Бямба гарагт, 8 буюу 4% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 27 буюу 13.4% нь 06:00-14:00 цагт, 58 буюу 28.7% нь 14:00-19:00 цагт, 46 буюу 22.8% нь 19:00-22:00 цагт, 71 буюу 35.1% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Гэмт хэрэг бүртгэсэн газрыг авч үзвэл, үйлдсэн гэмт хэргийн 74 буюу 36.6% нь гэр, орон сууцанд, 68 буюу 33.7% нь гудамж талбайд, 21 буюу 10.4% нь олон нийтийн газарт, 1 буюу 0.5% нь нийтийн тээвэрт, 1 буюу 0.5% нь төрийн байгууллагад, 3 буюу 1.5% нь төрийн бус байгууллагад, 5 буюу 2.5% нь аж ахуйн нэгжид, 29 буюу 14.3% нь бусад газарт үйлдсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 3 буюу 1.5% нь согтуугаар, 9 буюу 4.5% нь хүүхэд оролцож, 17 буюу 8.4% нь эмэгтэй хүн оролцож, 50 буюу 24.8% нь бүлэглэн үйлдсэн.

*Гэмт хэргийн илрүүлэлт.* Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 82% байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 81.2 % байгаа нь 0.4 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 88.9% байгаа нь 18.9 нэгжээр тус тус өссөн байна

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Нийт 269 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 47 буюу 14.9%-иар буурсан. Холбогдогчдын 15 буюу 5.6% нь эмэгтэй, 254 буюу 94.4% нь эрэгтэй, 15 буюу 5.6% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 12.7%-иар, эмэгтэй хүн 40%-иар, хүүхэд 37.5%-иар тус тус буурсан байна.

#### **Эд мөрийн баримтаар хурааж авсан бодисын хэмжээ**

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн судалгаагаар 2020 онд эд мөрийн баримтаар хурааж авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээ өмнөх онтой харьцуулахад, “мөс” - 747.83 грамм буюу 82.8%-иар, “мими” - 10



орчим килограммаар, морфин 37 ширхэгээр тус тус өсөж, “каннабис” - 37,665 грамм буюу 40.7%-иар, “гашиш” – 5,109.55 гр буюу 8 дахин тус тус буурсан байна.

**3.12.Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг)** Цагдаагийн байгууллагад бүртгэсэн 23064 гэмт хэргээс хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг 80 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.3%-ийг эзэлж байна.

Энэ бүлэгт заасан гэмт хэрэг улсын хэмжээнд шинээр 80 бүртгэгдсэн нь өмнөх оноос 92 хэргээр буюу 53.5%-иар, нийслэлд 50 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 44 хэргээр буюу 46.8%-иар тус тус буурсан, харин орон нутагт 30 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 48 хэргээр буюу 62.5%-иар өссөн байна.

**3.13.Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэг)** Цагдаагийн байгууллагад 211 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.9%-ийг эзэлж байна. Өмнөх оноос 130 хэргээр буюу 38.1%-иар, нийслэлийн хэмжээнд 124 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 105 хэргээр буюу 45.8%-иар, орон нутагт 87 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 24 хэргээр буюу 21.6%-иар тус тус буурсан үзүүлэлтэй байна.

**3.14.Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг)**

Цагдаагийн байгууллагад энэ бүлэгт заасан гэмт хэрэг 2020 онд 622 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 2.7%-ийг эзэлж байна.

Улсын хэмжээнд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг шинээр 622 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад, 133 гэмт хэргээр буюу 27.2%-иар, нийслэлд 52 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 12 хэргээр буюу 30%, орон нутагт 570 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 121 хэргээр буюу 26.9%-иар тус тус өссөн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 91 буюу 14.6% нь Даваа гарагт, 111 буюу 17.8% нь Мягмар гарагт, 103 буюу 16.6% нь Лхагва гарагт, 98 буюу 15.8% нь Пүрэв гарагт, 83 буюу 13.3% нь Баасан гарагт, 67 буюу 10.8% нь Бямба гарагт, 69 буюу 11.1% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 203 буюу 32.6% нь 06:00-14:00 цагт, 239 буюу 38.4% нь 14:00-19:00 цагт, 75 буюу 12.1% нь 19:00-22:00 цагт, 105 буюу 16.9% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Гэмт хэрэг бүртгэсэн газрыг авч үзвэл, 205 буюу 33% нь ойн сан бүхий газар, 55 буюу 8.8% нь хууль бусаар алт олборлож байгаа газар, 173 буюу 27.8% нь хөдөө хээр, 19 буюу 3.1% нь гол, усны ай сав газар, 14 буюу 2.3% нь аж ахуйн нэгжид, 156 буюу 25% нь бусад газарт үйлдсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 2 буюу 0.3% нь согтуугаар, 35 буюу 5.6% нь эмэгтэй хүн оролцож, 142 буюу 22.8% нь бүлэглэн, 23 буюу 3.7% нь галт зэвсэгээр тус тус үйлдсэн байна.

*Гэмт хэргийн илрүүлэлт.* Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 57.6% байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.5 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 58.5 % байгаа нь 9.9 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 57.5% байгаа нь 2.1 нэгжээр тус тус өссөн байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Нийт 588 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 229 буюу 63.8%-иар өссөн. Холбогдогчдын 30 буюу 5.1% нь эмэгтэй, 558 буюу 94.9% нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй 61.3%-иар, эмэгтэй 2.3%-иар тус тус өссөн байна.

*Хохирсон хүн, хуулийн этгээд.* Гэмт хэргийн улмаас 507 иргэн, 18 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 93 буюу 22.5%-иар, хуулийн этгээд 5 буюу 38.5%-иар тус тус өссөн.

*Учирсан хохирол.* Иргэн, хуулийн этгээдэд учирсан 3109.3 сая төгрөгийн хохирлын 58.1%-ийг нөхөн төлүүлж, 1143.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 533.2 сая төгрөг буюу 20.7%-иар, битүүмжилсэн хөрөнгө 442.8 сая төгрөг буюу 63.2%-иар тус тус өсөж, нөхөн төлүүлсэн хохирол 222.6 сая буюу 11.0 %-иар буурсан байна.

**3.15.1.Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйл)** 2020 онд нийт 23064 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг нийт гэмт хэргийн 0.96%-ийг эзэлж байна.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг улсын хэмжээнд 223 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 87 хэргээр буюу 63.9%-иар тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ. Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 57.6%-тай байна.

**3.16.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг)**

Цагдаагийн байгууллага бүртгэсэн нийт 23064 хэргээс соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 5 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.01%-ийг эзэлж байна.

Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 2020 онд шинээр 5 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад өсөлт бууралт байхгүй, нийслэлийн хэмжээнд 1 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх онтой адил, орон нутагт 4 шинээр бүртгэгдсэн нь өмнөх онтой мөн адил түвшинд байна. Энэ бүлэгт заасан гэмт хэргүүдэд холбогдуулан шалгасан этгээдүүд нь 30-34 насныхан байна.

**3.17.Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг)** “Цахим орчинд үйлдэгдсэн” гэмт хэрэг улсын хэмжээнд 2020 онд нийт 1795 гэмт хэрэг бүртгэгдсэн. Бүртгэгдсэн гэмт хэргийн 1349 буюу 75.2 хувь нь Улаанбаатар хотод, 445 буюу 24.8 хувь нь орон нутагт, 1 буюу 0.06 хувь нь бусад газар /хилийн чанадад үйлдэгдсэн/ бүртгэгдсэн байна. өмнөх оноос 1058 хэргээр буюу 2.5 дахин өссөн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Хэргийг гарагаар нь авч үзвэл, 269 буюу 15% нь Даваа гарагт, 292 буюу 16.3% нь Мягмар гарагт, 314 буюу 17.5% нь Лхагва гарагт, 213 буюу 11.9% нь Пүрэв гарагт, 259 буюу 14.4% нь Баасан гарагт, 232 буюу 12.9% нь Бямба гарагт, 216 буюу 12.0% нь Ням гарагт үйлджээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл, 787 буюу 43.8% нь 06-14 цагийн хооронд, 524 буюу 29.2% нь 14-19 цагийн хооронд, 220 буюу 12.3% нь 19-22 цагийн хооронд, 264 буюу 14.7% нь 22-06 цагийн хооронд үйлдэж байна.

*Гэмт хэрэг үйлдсэн газар.* Энэ төрлийн гэмт хэргийн 782 буюу 43.6% нь гэр орон сууцанд, 223 буюу 12.4% нь гудамж талбайд, 148 буюу 8.2% нь аж ахуйн нэгжид, 76 буюу 4.2% нь олон нийтийн газарт, 20 буюу 1.1% нь төрийн байгууллагад, 546 буюу 30.5% нь бусад газарт тус тус бүртгэсэн байна.

*Гэмт хэрэг үйлдсэн байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 11 буюу 0.6% нь согтуугаар, 88 буюу 4.9% нь хүүхэд оролцож, 487 буюу 27.1% нь эмэгтэй хүн оролцож үйлдсэн байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Энэ төрлийн гэмт хэрэг 1 иргэн 2 ба түүнээс дээш тооны гэмт хэрэгт холбогдон шалгагдах нь түгээмэл байдаг бөгөөд 2 ба түүнээс дээш тооны гэмт хэрэгт шалгагдсан 41 иргэн байна.

*Хохирсон хүн.* Гэмт хэргийн улмаас 1718 хүн хохирсны 860 буюу 50.1% нь эрэгтэй, 858 буюу 49.9% нь эмэгтэй, 24 буюу 1.4% нь 11-17 насны хүүхэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт хохирогч 1007 буюу 2.4 дахин, эмэгтэй хүн 462 буюу 2.2 дахин, хүүхэд 14 буюу 2.4 дахин тус тус өссөн байна.

**3.18.Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлэг)**

2020 онд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 981 бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 4.3%-ийг эзэлж байна.

Шинээр бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад, 295 хэргээр буюу 22.8%-иар, нийслэлийн хэмжээнд 431 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 164 хэргээр буюу 27.5%-иар тус тус буурсан, орон нутагт 554 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 127 хэргээр буюу 17.2%-иар буурсан байна.

Энэ төрлийн гэмт хэргээс Эрүүгийн хуулийн 27.10, 27.11 дүгээр зүйлд заасан хэрэг голчлон үйлдэгдсэн бөгөөд нийт гэмт хэргийн 47% нь нийслэлд, 53.3% нь орон нутагт үйлдэгджээ. Гэмт хэргийн илрүүлэлт 74.6% байна.



*Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг.* Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл, 157 буюу 16% нь Даваа гарагт, 130 буюу 13.2% нь Мягмар гарагт, 138 буюу 14.1% нь Лхагва гарагт, 135 буюу 13.8% нь Пүрэв гарагт, 145 буюу 14.8% нь Баасан гарагт, 150 буюу 15.3% нь Бямба гарагт, 126 буюу 12.8% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 250 буюу 25.5% нь 06:00-14:00 цагт, 293 буюу 29.9% нь 14:00-19:00 цагт, 187 буюу 19.1% нь 19:00-22:00 цагт, 251 буюу 25.5% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

*Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.* Гэмт хэргийн 500 буюу 51% нь орон нутгийн замд, 432 буюу 44% нь хотын замд, 7 буюу 0.7% нь аж ахуйн нэгжийн замд, 42 буюу 4.3% нь бусад газарт үйлдсэн байна

*Гэмт хэрэг үйлдсэн байдал.* Нийт бүртгэсэн хэргийн 200 буюу 20.4% нь согтуугаар, 145 буюу 14.8% нь эмэгтэй хүн оролцож, 9 буюу 0.9% нь хүүхэд оролцож, 2 буюу 0.2% нь гадаадын иргэн үйлдсэн байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Нийт 850 хүн гэмт хэрэгт холбогдон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 116 буюу 12%-иар буурсан. Холбогдогчдын 142 буюу 16.7% нь эмэгтэй, 708 буюу 83.3% нь эрэгтэй, 9 буюу 1.1% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 13.6%-иар, эмэгтэй хүн 3.4%-иар тус тус буурч, хүүхэд 28.6%-иар өссөн байна.

*Хохирсон хүн.* Гэмт хэргийн улмаас 1076 иргэн хохирч үүнээс 264 хүн нас барж, 779 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 385 буюу 25%-иар, нас барсан хүн 55 буюу 17.2%-иар, гэмтсэн хүн 281 буюу 26. %-иар тус тус буурсан

*Учирсан хохирол.* Иргэн, хуулийн этгээдэд гэмт хэргийн улмаас учирсан 5008.7 сая төгрөгийн хохирлын 77.5%-ийг нөхөн төлүүлж, 406.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь хохирлын хэмжээ 416.3 сая төгрөгөөр буюу 7.7%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 293.1 сая төгрөг буюу 7%-иар тус тус буурсан байна.

**3.18.1.Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйл)** нийт бүртгэгдсэн 23064 гэмт хэргийн 981 буюу 4.3%-ийг хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Өмнөх оноос 282 хэргээр буюу 22.3%-иар буурсан байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 99%-ийг автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг эзэлж байгаа ба нийслэлд 430 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 158 хэргээр буюу 26.8%-иар буурсан, орон нутагт шинээр 551 бүртгэсэн нь өмнөх оноос 124 хэргээр буюу 18.3%-иар буурсан байна.

### **3.19.Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг)**

Цагдаагийн байгууллагад 2020 онд цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 6 бүртгэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд 6 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 6 хэрэг буюу 50%-иар буурсан байна. Энэ төрлийн гэмт хэрэг 18-23 хүртэлх насныхан холбогдон шалгагдаж байна

**3.20.Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг)** 2020 онд Цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй.

## **4.Мөрдөн шалгах ажиллагаа**

2021 оны 05 дугаар сарын байдлаар Мөрдөн байцаах албанд нийт 477 алба хаагч ажиллаж 19415 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бөгөөд нэг алба хаагчид **40.7** хэрэг ногдож байна. Энэ үзүүлэлтийг газар нутгийн байдлаар авч үзвэл, төвийн нэгжид 105 алба хаагч 1335 хэрэг, нэг мөрдөгчид 12.7 хэрэг, нийслэлд 202 алба хаагч 12837 хэрэг, нэг мөрдөгчид **63.54** хэрэг, орон нутагт 170 алба хаагч 5243 хэрэг, нэг мөрдөгчид 30.8 хэрэг тус тус байгаа нь дүүргийн мөрдөгч нарын ажлын ачаалал хэт өндөр байгааг харуулж байна . Энэ

нь 2002 оны Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль мөрдөгдөж байх үеийнхээс даруй 3-4 дахин их болсныг харуулж байна.

Мөрдөн байцаах албаны алба хаагчдын ажлын ачаалалд сүүлийн 2 жилийн байдлаар судалгаа, дүн шинжилгээ хийхэд 2020 оны эхний хагас жилийн байдлаар 23055 хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулж 18553 хэрэг буюу 80.4%-ийг шийдвэрлэж, нэг мөрдөгч дунджаар **53.6** хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан бол одоо **40.7** хэрэг оногдож байгаа нь нэг мөрдөгчид ногдох ажлын ачаалал 12.9 хэрэг буюу 24%-иар буурсан нь удирдлага зохион байгуулалттай холбоотой бус цар тахлын үед үйлдэж буй гэмт хэргийн тоо буурсантай холбоотой байна<sup>2</sup>.

Цагдаагийн байгууллага 2020 онд 64.242 хэрэгт хэрэг бүртгэлт, 8.775 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 73.017 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсны 35.632 урьд оны үлдэгдэл хэрэг, 33.888 энэ оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 38, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 3459 хэрэг байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэрэг 11750 хэрэг буюу 13.9%-иар буурсан байна. Нийт шалгасан хэргийн 28.587 буюу 39.1%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж, 16.167 буюу 22.1%-ийг шүүхэд шилжүүлж, 3153 буюу 4.3%-ийг хэрэгсэхгүй болгож, 2785 буюу 3.8%-ийг нэгтгэн, 703 буюу 1%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нэгтгэж, нийт шалгасан хэргийн 70.4%, хуулийн анхны хугацаанд 86.8%-ийг шийдсэн байна.


Прокурор, шүүхээс 2814 эрүүгийн хэрэг буцааснаас 2340 /83.2%/ -ийг шийдвэрлэж, 474 эрүүгийн хэрэг буюу 16.8%-ийн үлдэгдэлтэй байна.

График №2. Шийдвэрлэлт



2020 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгасан гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан 768.0 тэрбум төгрөгийн хохирлын 323.2 тэрбум төгрөг буюу 42.1%-ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд төлүүлсэн байна.

График №3. Хохирол нөхөн төлүүлэлт



2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2.045 хүнд холбогдох 22.458 хэргийн үлдэгдэлтэй байна. Үүнд хэрэг бүртгэлтийн 21.197 /94.4%/, мөрдөн байцаалтын 1261 /5.6%/ хэрэг байна.

<sup>2</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургуулийн хамтарсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөгч, эрүүгийн мөрдөгчийн ажлын ачаалал” сэдэвт судалгааны ажлын тайлангаас.

#### 4.1.Түдгэлзүүлсэн хэргийн шийдвэрлэлт

2020 онд “Түдгэлзүүлсэн” үзүүлэлтээр цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд орсон нийт 79 эрүүгийн хэрэг (түдгэлзүүлснээс сэргээн шалгаж байгаа, шийдвэрлэсэн, харьяаллын дагуу шилжүүлсэн, одоо түдгэлзүүлсэн байгаа)-ийн 66 буюу 83.5% нь урьд оны 13 буюу 16.5% нь 2020 оны хэрэг байна.

Үүнээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 14 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 65, 1 дэх заалтад заасан үндэслэлээр 1, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 13 хэрэг тус тус байна.

Хүснэгт №3. Түдгэлзүүлсэн хэргийн үндэслэл

	Хуулийн зүйл	Түдгэлзүүлсэн хэргийн тоо	Түдгэлзүүлсэн нийт хэрэгт эзлэх %
Нийт 79 хэргийн түдгэлзүүлсэн үндэслэл	31.14.1	1	1.3
	31.14.2	65	83.5
	31.14.3		0.0
	Хуучин хуулиар	12	15.2


Хүснэгт №4. Түдгэлзүүлсэн хэргийн шийдвэрлэлт

Түдгэлзүүлсэнээс сэргээн шалгасан 55	Шийдвэрлэсэн	Дахин түдгэлзүүлсэн	Ажиллагаанд	Шилжүүлсэн
	35	12	8	
	63.6%	21.8%	14.6%	

Түдгэлзүүлсэн хэргийн 806.9 сая төгрөгийн хохирлоос эрүүгийн хэргийг сэргээн шалгаж шийдвэрлэх явцад 111.4 сая төгрөг буюу 13.8% хохирол нөхөн төлүүлж, 72.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Мөрдөн байцаалтын шатанд оргон зайлсан 23 яллагдагчийг олж баривчлан хэргийг нь шийдвэрлэсэн байна. Үүнээс урьд оны дугаартай эрүүгийн хэрэгт 20, 2020 оны хэрэгт 3 яллагдагчийг эрэн сурвалжилж олж илрүүлжээ.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар түдгэлзүүлсэн үлдэгдэл нийт 36 хэрэг байгаа бөгөөд 28 хэрэг нь урьд оны, 8 хэрэг нь 2020 оны дугаартай эрүүгийн хэрэг байна.



Үлдэгдэл түдгэлзүүлсэн эрүүгийн хэргийн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 7 /19.4%/, залилах 7 /19.4%/, хулгайлах 4 /11.1%/, мал хулгайлах 2 /5.6%/, хүнийг алах 3 /8.3%/, 13 /36.2%/, бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

2020 онд нийт бүртгэсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 26.8%-иар буурсан эерэг үзүүлэлттэй гарснаас хулгайлах 43.1%, мал хулгайлах 42.5%, дээрэмдэх 53.5%, хүнийг алах



2.5%, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 10.4%, хүчиндэх 16.6%, залилах гэмт хэрэг 8.9%-иар тус тус буурсан байна.

Хэдийгээр дээрх төрлийн гэмт хэргүүд буурсан боловч нийт гэмт хэргийн 80 орчим хувь буюу 10 хэрэг тутмын 4 нь өмчлөх эрхийн эсрэг, 2 нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа нь энэ чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг идэвхжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Харин хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 27.2%, хүний хувийн болон улс төрийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 66.7%, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.6 дахин тус тус өсжээ.

Энэ нь цар тахлын үеийн хөл хориотой холбоотойгоор иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа хязгаарлагдаж, ажилгүйдэл, иргэдийн орлого буурсантай холбоотойгоор дээрх төрлийн гэмт хэрэг өссөн хамааралтай байна. Түүнчлэн бүртгэсэн гэмт хэргийн 83.5% нь хөнгөн, 16.5% нь хүнд ангиллын гэмт хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 23.5%-иар, хүнд гэмт хэрэг 40.1%-иар тус тус буурсан нь мөн цар тахлын хөл хорионы нөхцөл байдалтай холбоотой байна.

Улаанбаатар хотын дүүргүүдэд 2020 онд 10.000 хүн ам тутамд дунджаар 170 гэмт хэрэг ногдож буй бөгөөд Сүхбаатар дүүрэг 330, Чингэлтэй дүүрэг 245 гэмт хэрэг ногдож байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй юм. Үүнээс үзэхэд, Улаанбаатар хотын гэмт хэргийн гаралтад хүн амын тоо, оршин суугчдын нягтрал шууд нөлөөлж байна.

### 5.3. Зөрчил

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 2,276,868 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 101,043 буюу 4.6%-иар, 2,272,346 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 104,011 буюу 4.8 %-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн:

- 2,058,347 буюу 90.4%-ийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих,
- 91212 буюу 4%-ийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах,
- 10,306 буюу 0.5%-ийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих,
- 5311 буюу 0.2%-ийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих,
- 111,692 буюу 4.9%-ийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан:

- 2,148,231 хүн, 85,633 хуулийн этгээдийг 66.0 тэрбум төгрөгөөр торгох,
- 16,891 хүнийг баривчлуулах,
- 21,591 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 24701 буюу 1.2%-иар, хуулийн этгээдийг торгосон шийтгэл 84,639 буюу 86.1 дахин, баривчилсан шийтгэл 1595 буюу 10.4%-иар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 6924 буюу 24.3%-иар буурсан байна.

### 6.3. Зам тээврийн осол, хэрэг

Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн тоо жил ирэх тусам улам өсөх хандлагатай байна. Автомашин тоо 2020 оны байдлаар 1,012,786 байгаа бөгөөд тэдгээрийн 56.6%, тээврийн хэрэгслийн 54.1% нь зөвхөн Улаанбаатар хотод бүртгэлтэй байна.

Монгол Улсын автомашин, тээврийн хэрэгслийн тоо 2011 онд 312,542 автомашин, 349,456 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байсан бол 2020 онд автомашин 1,013,786, тээврийн хэрэгсэл 1,137,208 болж сүүлийн 10 жилд 3-3.2 дахин өссөн байна.




**Тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа.** Монгол Улсад 2020 оны байдлаар бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацааг авч үзвэл 0-3 жил ашиглагдаж байгаа автомашин 52,168 буюу 4.6%-ийг, 4-6 жил ашиглагдаж байгаа автомашин 45,242 буюу 4%-ийг, 7-9 жил 211,525 буюу 18.6%-ийг, 10 ба түүнээс дээш жил ашиглагдаж буй автомашин 828,273 буюу 72.8%-ийг эзэлж байна. Харин өнгөрсөн онтой харьцуулан авч үзэхэд 10 ба түүнээс дээш жил ашиглагдсан тээврийн хэрэгслийн тоо 4.1%-иар буурсан ба шинэ автомашины тоо 1.4%-иар өссөн байна.

Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 1,013,786 автомашин, 1,137,208 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Бүртгэлтэй автомашины 572,432 буюу 56.5%-нь нийслэлд, 441,354 буюу 43.5% нь орон нутагт бүртгэлтэй байна.

**Зам тээврийн ослын ангилал.** “Зам тээврийн осол” гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг<sup>3</sup> хэлнэ.

Монгол Улсын хэмжээнд 2020 онд зам тээврийн ослын шинжтэй 65650 дуудлага хүлээн авч 21768 зам тээврийн осол бүртгэн шалгасан байна. Өнгөрсөн онтой харьцуулахад зам тээврийн ослын шинжтэй дуудлага 11794, бүртгэгдсэн зам тээврийн осол 3534-өөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нийт бүртгэгдсэн ослын 18513 буюу 85% нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

График №4. Нийслэл болон орон нутагт ирүүлсэн дуудлагын тоо



Нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн ослын 20.3% нь Баянзүрх дүүрэгт, 16.8 нь Баянгол дүүрэгт, 19.6% нь Сонгинохайрхан дүүрэгт, 15% нь Хан-Уул, 19.7% нь Сүхбаатар, 7% нь Чингэлтэй дүүрэгт тус тус бүртгэжээ.

Хөдөө, орон нутагт Төв, Өмнөговь, Хэнтий аймгуудад зам тээврийн осол хамгийн их бүртгэгдсэн бол Говьсүмбэр, Баян-Өлгий, Дундговь аймгуудад хамгийн бага бүртгэгдсэн байна. Орон нутагт бүртгэсэн зам тээврийн осол өнгөрсөн оноос 5%-иар буурсан байна. Бүртгэсэн зам тээврийн ослыг эд материалын хохиролтой, хүн гэмтсэн зам тээврийн осол гэж ангилан бүртгэж байна.

Эд материалын хохиролтой зам тээврийн осол гэж зам тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг авч үздэг. Тэгвэл хүн гэмтсэн осол гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн

<sup>3</sup> Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдлыг авч үзнэ.

Улсын хэмжээнд 2020 онд 21,768 зам тээврийн осол бүртгэгдсэний 89.4% нь эд материалын хохиролтой осол байсан бол 10.6% нь хүн гэмтсэн буюу хүний амь нас, эрүүл мэнд хохирсон зам тээврийн осол байсан байна.

Хүснэгт №5. Хохирол

Хохирол	Хүн гэмтсэн	Эд материалын хохирол
Улс	2308	19460
Нийслэл	1481	17032


Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлэг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2020 онд 985 бүртгэсний 698 буюу 70.9%-д нь хэрэг бүртгэлтийн хэрэг, 553 буюу 56.1%-д нь мөрдөн байцаалтын хэрэг үүсгэж, яллагдагчаар татан шалгасан байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт 79.2%-тай байна. Нийт хэргийн 99.6% нь автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг байна.

*Гэмт хэрэгт холбон шалгасан хүн.* Монгол Улсын хэмжээнд 2020 онд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт холбогдон шалгагдсан 857 хүн байсан ба эдгээрийн 716 буюу 83.5% нь эрэгтэй жолооч, 141 буюу 16.5% нь эмэгтэй жолооч байна. Гэмт хэрэгт холбогдсон нийт хүмүүсийн 50.5%-ийг 18-34 насны хүмүүс эзэлж байна.

*Гэмтэж, нас барсан.* Зам тээврийн осолд өртсөн 3148 хүний 430 нь амь насаа алдсан бол 2718 хүн эрүүл мэндээрээ хохирсон байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт өртсөн 1048 хүний 268 нь амь насаа алдсан бол 784 хүн хүнд, хүндэвтэр байдлаар гэмтсэн байна. Зам тээврийн ослоос шалтгаалан амь насаа алдсан хүмүүсийн 319 буюу 74.2% нь орон нутагт, 111 буюу 25.8% нь нийслэлд бүртгэгджээ.

Монгол Улсын хэмжээнд 2020 онд нийт нас барсан хүний 39.4% нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ.

График №5. Хохирсон байдал.




Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний тоон үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд 23.4% нийслэлийн хэмжээнд 15.3%, орон нутагт 25.8%-ийн бууралттай байна.

Улсын хэмжээнд 2718 хүн зам тээврийн ослын улмаас хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэж бэртсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 28.3%-иар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 784 хүн гэмтсэн нь 26.9%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

*Осолд өртсөн хүний нас, хүйс.* Зам тээврийн улмаас улсын хэмжээнд амь нас, эрүүл мэндээрээ хохирсон 3184 хүний насны байдлыг авч үзвэл, 241 буюу 43% нь 35-54 насны, гэмтэл, бэртэл авсан хүний 1273 буюу 33.6 хувийг 18-35 насныхан эзэлсэн байна. Харин амь насаа алдсан хүний 68.9%-ийг, гэмтсэн хүний 55%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Үүнээс үзвэл, 18-45 насны эрэгтэй хүмүүс замын хөдөлгөөнд зөв зүйтэй оролцоогүй, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн буруутай этгээдээс хамаарч амь нас, эрүүл мэндээрээ хохирч байна.

*Гэмтэл.* Зам тээврийн ослын үед амь нас, эрүүл мэндээрээ хохирогчид толгой, цээж, хөлийн гэмтэл хамгийн их авч байна. Орон нутгийн замд гарсан ослын улмаас гэмтэгсэд биеийн бүх хэсэгт буюу толгойн гэмтэл маш их авч байгаа нь осол илүү ноцтой, учирч буй гэмтэл илүү хүнд байгааг харуулж байна.



Амь насаа алдсан хүмүүсийн 44.7% нь толгойдоо, 24.2% нь цээжиндээ хүнд гэмтэл авсан байхад 156 хохирогч хавсарсан гэмтэл авч амь насаа алдсан байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэсэн мэдээллээс харахад зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний 89.3% нь осолд өртсөн даруйдаа буюу 24 цагийн дотор, 10.7% нь осолд өртөж эмнэлгийн тусламж авсны дараа 30 хоногт нас барсан байна.

Орон нутгийн замд буюу төв, суурин газраас алслагдсан замд гарсан осолд эмнэлгийн анхны тусламж авч чадаагүй болон 24 цагийн дотор амь насаа алдсан үзүүлэлтүүдээс харагдаж байна.

Зам тээврийн осолд өртөж хохирсон 3148 хүний 1395 буюу 44.3% нь явганаар замын хөдөлгөөнд оролцож байсан бол 1140 буюу 36.2% нь тээврийн хэрэгслээр зорчигч, 523 буюу 16.6% нь жолооч, 90 буюу 2.9% нь дугуйгаар зорчигч байна. Үүнээс Улаанбаатар хотод хохирсон 1833 хүний 1070 буюу 58.4% нь явган зорчигч байгаа нь явган зорчигчийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг хомс, дүрэм журмын дагуу хөдөлгөөнд оролцдоггүй зэрэг нөхцөл ажиглагдаж байна.

Жолооч, тээврийн хэрэгслээр зорчигчийн 50.8% нь автомашины урд суудалд, 29.6% нь арын суудалд, 15.9% нь бусад суудалд сууж явахдаа бэртсэн байна.

*Хохирол.* Зам тээврийн ослын улмаас 2020 онд иргэн, аж ахуй нэгж байгууллагад 22 тэрбум 243 сая төгрөгийн хохирол учирсны 17 тэрбум 332 сая төгрөгийн буюу 90.8%-ийг нөхөн төлүүлсэн байна.

**Зам тээврийн ослын шалтгаан.** Монгол Улсын хэмжээнд 2020 онд 21768 зам тээврийн осол бүртгэгдсэнээс 21196 буюу 97.4% нь жолоочийн буруутай үйлдлээс, 532 буюу 2.4% нь явган зорчигчийн буруугаас, 40 буюу 0.2% нь замын нөхцөлөөс шалтгаалсан гэж бүртгэгджээ.


Зам тээврийн ослын 97.4% нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан байх бөгөөд эдгээрийг нарийвчлан авч үзвэл гүйцэж түрүүлэх үйлдэл, гэрэл дохио зөрчих, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эргэх үйлдэл буруу гүйцэтгэсэн, хурд хэтрүүлсэн зэрэг үйлдлийн эзлэх хувь өнгөрсөн оноос тодорхой хэмжээгээр ихэссэн байна. Харин эгнээ байр буруу эзлэх, уулзвар гарц нэвтрэх журам зөрчим, эсрэг урсгалд орох, ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн зэрэг тохиолдол буурсан байна.

Ослын үндсэн шалтгаан нь жолооч нарын ур чадвар сул, хариуцлагагүй, хууль дүрмийн мэдлэг тааруу, яарч явсан зэрэг шалтгаанаар хурд хэтрүүлсэн байх бөгөөд жолооч нарт өөрсдийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг эрсдэлд оруулж байгаа талаар сэрэмжлүүлэг өгч, орон нутгийн зам дахь хяналтыг сайжруулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэх хэрэгжүүлэх нь зөвхөн жолоочид биш замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигчид ч хамааралтай. Явган зорчигч гэж замаар явган яваа хүн, жагсаалаар яваа болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж, чарга чирч, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүнийг ойлгоно.<sup>4</sup>

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 2020 онд улсын хэмжээнд 532 буюу нийт бүртгэсэн ослын 2.4%-ийг эзэлж байна. Үүний 417 буюу 78.4% нь нийслэлд, 115 буюу 21.6% нь орон нутагт бүртгэсэн байна. Явган зорчигчийн буруутай үйлдлүүдээс замын хөдөлгөөнд согтуугаар оролцсон нь 44.5%, сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулсан 9%-ийг эзэлж байна. Явган зорчигчоос шалтгаалсан ослуудын нийтлэг тохиолдлууд нь явган хүний гарцаар гараагүй, гарамгүй газраар зам хөндлөн гарах, гэрлэн дохио зөрчиж зам гардаг, зам хөндлөн гүйх, замын зорчих хэсгээр явах, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ замын зорчих хэсгээр явах, замын хашлага давах, сургуулийн өмнөх насны болон бага насны хүүхдийг харгалзах хүнгүй замын хөдөлгөөнд оролцуулах зэрэг үйлдлүүд гаргаж байна.

График №6. Явган зорчигчийн буруутай үйл ажиллагаанаас бий болсон осол



<sup>4</sup> Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

Явган зорчигчийг мөргөсөн ослын шалтгаанаас харахад, явган зорчигчийн өөрийн буруутай үйлдлээс буюу гарц гарамгүй газраас зам хөндлөн гарсан, ойртон ирж байгаа тээврийн хэрэгслийн урдуур гүйсэн зэрэг тохиолдлоос шалтгаалсан байна. Харин жолооч замын хөдөлгөөнд оролцож байгаа явган зорчигчийг хүндэлж, зам тавьж өгдөггүй нь явган зорчигчийг мөргөсөн шалтгаан болж байна.

Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг мөрдөж, үзэгдэх орчин, чанар стандартыг тохируулах шаардлагатай. Замын нөхцөлөөс шалтгаалсан осол улсын хэмжээнд нийт 40 бүртгэгдэн ба үүний 22 нь нийслэлд, 18 нь орон нутагт бүртгэгджээ.

**Зам тээврийн ослын хэлбэр.** Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 17678 буюу 81.2% нь мөргөлдөх, 1371 буюу 6.3% нь явган зорчигчийг мөргөх, 1007 буюу 4.6% нь онхолдох, 1199 буюу 5.5% үл хөдлөх зүйл мөргөх, 99 унадаг дугуй мөргөх, 193 осол мал, амьтан дайрах зэргээр бүртгэгджээ.

Явган зорчигч мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн нийт ослын 960 буюу 80% нь нийслэлд гарсан бол онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн нийт ослын 888 буюу 88.2% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Онхолдох хэлбэрээр гарсан ослын улмаас орон нутагт 152 хүн, нийслэлд 11 нийт 163 хүний амь нас хохирсон байна.

График №7. Ослын хэлбэр



Орон нутагт онхолдох хэлбэрээр гарч буй зам тээврийн осол нь бүрэн бус тээврийн хэрэгсэл буюу мотоциклоор замын хөдөлгөөнд оролцох, согтуугаар жолоодох, хурд хэтрүүлэх зэргээс шалтгаалсан байна.

Зам тээврийн ослын 27.6% нь өвөл, 25.7% нь хавар, 21.4% нь зун, 25.3% нь намар бүртгэгджээ. Өвлийн улиралд замын зорчих хэсэгт өөрчлөлт орох, халтиргаа гулгаанаас хамааралтай зам тээврийн ослын дуудлага өсдөг. Хүний амь нас хохирсон осол зун болон намрын улиралд их бүртгэгдсэн байхад өвлийн улиралд ослын гэмтэл, бэртэл ихэнх хувийг эзэлж байна.

Зам тээврийн ослын улмаас 8, 10 саруудад хүний амь нас их хохирсон нь тухайн саруудад төв орон нутгийн чиглэлд амралт, аялал, зугаалгаар явах аялагч, зорчигчдийн тоо өсч хөдөлгөөн ихэсдэгтэй холбоотой.

Хүний амь нас хохирсон ослын 33.2% нь шөнө, 66.8 нь өдрийн цагт гарсан байна.

Зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн 18832 буюу 86.5% нь суудлын, 1918 буюу 8.8% нь ачааны, 481 буюу 2.2% нь автобус, 36 буюу 0.2% нь механизм, 411 буюу 1.9% нь мотоцикл, 90 буюу 0.4% нь унадаг дугуйгаар үйлдэгдсэн байна. Манай улсын нийт



автомашины 62.9%-ийг суудлын автомашин эзэлдэг бөгөөд үүнтэй холбоотой осолд холбогдсон автомашины 86.5%-ийг энэ төрлийн автомашин эзэлж байна.


Монгол Улсад нийт 67796 мотоцикл бүртгэлтэй ба үүний 9834 буюу 14.5% нь нийслэлд 57962 буюу 85.5% нь орон нутагт бүртгэлтэй байна. Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Төв, Увс аймгуудын мотоциклын хэрэглээ бусад аймгуудаас илүү байна.

Мотоциклоор үйлдэгдсэн ослын үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад орон нутагт 4%-иар, ослын улмаас амь нас хохирсон байдал 39.3%-иар тус тус буурсан байхад нийслэлд осол 7%-иар, хүний амь нас хохирсон байдал 33.3%-иар өссөн байна. Мөн мотоцикл холбогдсон ослын улмаас гэмтсэн хүний тоо 22 буюу 8.1%-иар өсчээ.

Мотоциклоор үйлдэгдсэн ослын улмаас амь насаа алдсан хүний дийлэнх нь жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч хамгаалалтын малгай өмсөж хэвшээгүй, мотоциклийг зориулалтаар нь зөв хэрэглэх дадал, мэдлэг, чадвар хангалтгүй байснаас ослын үед толгойндоо гэмтэл авсан нь үхэлд хүргэх шалтгаан болсон хэвээр байна.

**Хүүхэд өртсөн зам тээврийн осол.** Улсын хэмжээнд 2020 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 543 бүртгэсний 301 буюу 55.4% нь нийслэлд, 242 буюу 44.6% нь орон нутагт бүртгэжээ. Энэ үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулахад, нийслэлийн хэмжээнд 45.8%-иар буурсан боловч орон нутагт 27.4%-иар өссөн байна. Нийт хүүхэд өртсөн 543 осолд 625 хүүхэд өртөж хохирсны 64 нь амь насаа алдсан байна. Зам тээврийн ослыг улмаас амь насаа алдсан нийт хүний 17.2%-ийг хүүхэд, нийт гэмтсэн хүний 20.6%-ийг хүүхэд эзэлж байна.

График №8. Хүүхэд өртөж гэмтсэн осол




Хүүхэд өртсөн осол нийслэлд их бүртгэгдсэн ч амь насаа алдсан хүүхдийн 89.1% нь орон нутгийн замд бүртгэгдсэн байна. Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн маршрутаар явахдаа зам тээврийн осолд ордог байна.

Хүүхэд осолд өртсөн байдлыг авч үзэхэд орон нутагт Төв, Дорнод аймгуудад давамгайлж байна. Харин нийслэлийн дүүргүүдээс Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг буюу хотын захын хүн амын суурьшил ихтэй газруудад хүүхэд өртсөн осол ихээр бүртгэгджээ.

Зам тээврийн осолд өртсөн нийт 625 хүүхдийн 37% нь 0-6 насны хүүхэд, 45.8% нь 7-14 насны хүүхэд, 17.3% нь 15-17 насны хүүхэд байна.

График №9. Осолд өртсөн хүүхдийн нас /улсын хэмжээнд/



Зам тээврийн осолд өртсөн нийт хүүхдийн 361 буюу 57.8% нь явганаар, 214 буюу 34.2% нь тээврийн хэрэгслээр зорчиж байсан, 33 буюу 5.3% нь унадаг дугуйгаар, 17 буюу 2.7% нь бусад хэлбэрээр замын хөдөлгөөнд оролцож байхдаа амь нас, эрүүл мэндээрээ хохирч, гэмтэл бэртэл авчээ.

Нийслэлд 10 хүртэлх насны хүүхэд явганаар замын хөдөлгөөнд оролцож гэмтсэн хүүхдийн 33.3% нь насанд хүрсэн харгалзах хүнтэй оролцож явсан бол 46.8% нь ганцаараа, 19.9% нь насанд хүрээгүй хүнтэй хамт явсан байна.

Орон нутгийн замд гарсан осол нь суурин газар болон суурингийн гаднах замд дийлэнх осол бүртгэгдсэн. Нийслэлд явган зорчигчийг мөргөсөн осолд орох тохиолдол нь хотын захын гэрэлтүүлэг хангалтгүй газрууд байна.

**Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлдсэн зам тээврийн осол, учирсан хохирол.** Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осол үйлдсэн тохиолдол улсын хэмжээнд 2020 онд 1103 бүртгэжээ. Харин явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцож хохирсон осол 174 бүртгэжээ.

Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн осол өмнөх оноос 12.8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Согтуугаар үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас 145 буюу 45% нь явган зорчигч, 86 буюу 27.3% нь тээврийн хэрэгслээр зорчигч, 84 буюу 26.7% нь жолооч байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ автомашин жолоодох нь жолооч хурд хэтрүүлэх, гэрэл дохио болон өөдөөс ирэх саадыг анзаарахгүй, зогсоох арга хэмжээ авч чадахгүй, анхаарал төвлөрөхгүй байх зэрэг өөрийгөө хянах чадварт муугаар нөлөөлж, ноцтой зам тээврийн осол гарах шалтгаан болж байдаг. Согтууруулах ундаа нь автомашин жолоодож байгаа хүний оюун ухаан, жолоодох, самбаачлах ур чадварт шууд нөлөөлдөг.

Монгол Улсад 2011 онд жолоочийн тоо 751000 байсан бол 2020 онд 1335000 болж өссөн байна. Сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр жилд дунджаар 67.6 мянган жолооч шинээр бэлтгэсэн ба 2020 онд 34371 хүн шинээр жолоодох эрх авчээ.<sup>5</sup>

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй хүмүүсийн 842703 буюу 63.1% нь эрэгтэй, 492297 буюу 36.9% нь эмэгтэй жолооч байна. Жолоодох эрхийн В ангилалтай жолооч 1070192 буюу 80.2%, ВС ангиллын жолооч 146675 буюу 11%-ийг эзэлж байна.

<sup>5</sup> Автотээврийн үндэсний төвийн үзүүлэлт

## МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2020

Зам тээврийн осолд холбогдсон 14423 жолоочийн жолоодох эрхийн үнэмлэх авсан жилээр судалгаа хийхэд 0-4 жил болсон жолооч 24.9%, 5-9 жил болсон жолооч 29.7%, 10-14 жил болсон 17.7%-ийг эзэлсэн байна.

Осол гаргасан жолоочийн насны байдлаас авч үзэхэд 4786 буюу 33.2%-ийг 21-30 насны хүмүүс, 4550 буюу 31.5%-ийг 31-40 насны хүмүүс эзэлсэн байна.

График №10. Осол гарсан байршил

№	Замын байршил	Ослын тоо
<b>Баянзүрх дүүрэг</b>		
1	Цайз захын уулзвар	272
2	Дүнжингарав захын уулзвар	265
3	Офицеруудын ордон	246
<b>Баянгол</b>		
1	Саппорогийн уулзвар	341
2	10-р хорооллын уулзвар	267
3	Ахуйн үйлчилгээний уулзвар	235
<b>Сүхбаатар дүүрэг</b>		
1	32-ын тойрог	289
2	100 айлын уулзвар	289
3	Авто плаза төвийн баруун талын уулзвар	182
<b>Сонгинохайрхан дүүрэг</b>		
1	Авто сургуулийн уулзвар	451
2	Баянхошууны дэнжийн уулзвар	380
3	5-р баазын уулзвар	253
<b>Хан-Уул дүүрэг</b>		
1	Төвийн салаа	181
2	Дүнжингаравын баруун уулзвар	171
3	120 мянгатын шинэ уулзвар	156
<b>Чингэлтэй дүүрэг</b>		
1	Баянбүрдийн уулзвар	209
2	Хайлаастын эцэс	174
3	Хүнсний 1-р дэлгүүрийн уулзвар	76
<b>Архангай</b>		
1	Эрдэнэбулган	30
2	Ихтамир	20
3	Цэнхэр	10
<b>Баян-Өлгий</b>		
1	Өлгий	43
2	Ногоон нуур	8
3	Толбо	6
<b>Баянхонгор</b>		
1	Баянхонгор	95
2	Өлзийт	13
3	Баян-Овоо	12
<b>Булган</b>		
1	Булган	36
2	Хутаг-Өндөр	20
3	Орхон	14
<b>Говь-Алтай</b>		
1	Есөнбулаг	43
2	Дэлгэр	11
3	Шарга	6
<b>Орхон</b>		

1	Баян-Өндөр	91
2	Жаргалант	7
<b>Төв</b>		
1	Сэргэлэн	65
2	Аргалант	45
3	Эрдэнэ	44
<b>Сэлэнгэ</b>		
1	Мандал	34
2	Сүхбаатар	20
3	Сайхан	12
<b>Дархан</b>		
1	Дархан	115
2	Хонгор	11
<b>Дорноговь</b>		
1	Замын-Үүд	65
2	Сайншанд	41
<b>Дорнод</b>		
1	Хэрлэн	103
2	Матад	14
<b>Дундговь</b>		
1	Сайнцагаан	37
2	Дэлгэрцогт	13
<b>Завхан</b>		
1	Улиастай	18
2	Тосонцэнгэл	15
<b>Өвөрхангай</b>		
1	Арвайхээр	40
2	Хархорин	13
<b>Өмнөговь</b>		
1	Ханбогд	132
2	Цогтцэций	85
<b>Сүхбаатар</b>		
1	Баруун-Урт	69
2	Мөнххаан	11
<b>Увс</b>		
1	Улаангом	51
2	Өлгий	7
<b>Ховд</b>		
1	Жаргалант	39
2	Булган	20
<b>Хөвсгөл</b>		
1	Мөрөн	94
2	Алаг-Эрдэнэ	21
<b>Хэнтий</b>		
1	Хэрлэн	129
2	Цэнхэрмандал	36

Жолооч, зорчигчид суудлын хамгаалах бүс хэрэглэх нь ослын үед гарах гэмтэл, хор уршгаас сэргийлэхэд нэн чухал үүрэгтэй хэрэгсэл байдаг. Хамгаалах бүс хэрэглэсэн үед урд сууж явсан жолооч болон зорчигчийг учирч болох гэмтлээс 40-50%-иар, ард сууж явсан зорчигчийг 25-75%-иар бууруулж, осол гэмтэл, эрсдлээс хамгаалдаг. Мотоциклийн хамгаалах малгай нь толгой гэмтэх эрсдэл болон гэмтлийн зэргийг 70% бууруулдаг ач холбогдолтой.

Улсын хэмжээнд 2020 оны байдлаар осолд орох үедээ жолооч, тээврийн хэрэгслээр зорчигчдын 23.4% нь хамгаалах бүс хэрэглэсэн байсан бол 72.3% нь хамгаалах бүс хэрэглээгүй, 3.7% нь тогтоогдоогүй байна.

Зам тээврийн осолд өртөж, амь насаа алдсан жолооч, зорчигчийн 167 буюу 72.3% нь зам тээврийн осолд орох үедээ хамгаалах бүс хэрэглээгүй, 43 буюу 18.6% нь хэрэглэсэн эсэх нь тогтоогдоогүй, 21 буюу 9.1% нь хамгаалах бүс хэрэглэсэн байжээ.

Автомашин урд хэсгээрээ мөргөлдөхөд хүмүүс их гэмтдэг болохыг эрдэмтэд тогтоосон. Автомашин урд хэсгээрээ мөргөлдөхөд сууж яваа хүн энерцийн хүчний үйлчлэлээр автомашины мөргөлдөх үеийн хурдтайгаар урагш тэмүүлж, бүхээг доторх эд ангийг мөргөдөг. Зам тээврийн ослын үед хамгаалах бүс хэрэглээгүй хүмүүсийн 32% нь нуруу, 50-иас дээш хувь нь толгой, нүүрэндээ гэмтэл авч, хамар, эрүү, эгэмний яс хугарч, дух нүүрний хэсэг зүсэгддэг байна.

### **7. Эрүүлжүүлэгдсэн хүн**

2020 онд цагдаагийн байгууллага 93863 хүнийг эрүүлжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад, 17213 хүн буюу 15.49%-иар буурсан бөгөөд 2.887.603.000 /хоёр тэр бум найман зуун наян долоон сая зургаан зуун гурван мянга/ төгрөгийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нийт эрүүлжүүлсэн хүмүүсийн 69.726 буюу 74.3% нь Улаанбаатар хотод, 24.137 буюу 25.7% нь орон нутагт байна.

Эрүүлжүүлсэн хүний 8714 буюу 9.28% нь эмэгтэй, 218 буюу 0.23% нь хүүхэд, 658 буюу 0.7% нь төрийн алба хаагч, 112 буюу 0.11% нь оюутан, 78277 буюу 83.39% нь эрхэлсэн тодорхой ажилгүй байгаа нь анхаарал татаж байна.

Эрүүлжүүлэгдсэн хүний 71683 буюу 76.36% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, 4122 буюу 4.39% нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, 10213 буюу 10.88% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, 1055 буюу 1.12% нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зэрэг үндэслэлээр эрүүлжүүлэгджээ. Хүргэгдэн ирж буй нутаг дэвсгэрээр авч үзвэл, 60632 буюу 64.59% нь гэр, орон сууцнаас, 27012 буюу 28.77% нь гудамж, талбайгаас, 2954 буюу 3.14% нь байгууллага, аж ахуй нэгжээс тус тус эрүүлжүүлэгдсэн байна.

### **8. Цагдаагийн байгууллагаас хийсэн урьдчилан сэргийлэх ажил**

Цагдаагийн байгууллага нь 2020 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллагаанд байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог хангах зорилгоор нэгдсэн 17, хэсэгчилсэн 1044 арга хэмжээг төрийн болон төрийн бус бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэсэгчилсэн арга хэмжээний 164-ийг улсын хэмжээнд, 29-г нийслэлийн хэмжээнд, 891-ийг аймаг, дүүргийн хэмжээнд зохион байгуулсан байна. Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 15.795 сургалт, сурталчилгаа, 1341 уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, 251 өдөрлөг, 146 уралдаан тэмцээн зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 13.353.108 иргэнийг хамруулж, цахим орчинд 43.635 мэдээлэл, зурагт, видео контент байршуулж, олон нийтийн газар, зах, худалдааны төв, нийтийн тээвэр, орон сууцны лифтэнд 1.879.732 ширхэг зурагт хуудас, зөвлөмж байршуулж, 16.934 удаа үзлэг шалгалт зохион байгуулсан төдийгүй гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, урьдчилан сэргийлэхээр иргэн, хуулийн этгээдэд 20603 мэдэгдэл өгч, 18065 хариу авч үр дүнг тооцон ажиллажээ.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хүчирхийллийг үл тэвчих, хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг болон бэлгийн хүчирхийллийн эсрэг тэмцэх эерэг хандлага төлөвшүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, гэмт хэрэг үйлдэгчийн зан төлөвийг өөрчлөх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор:





1. Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр **“Сүүдэр бүү тусга”**, **“Хайр өвтгөдөггүй”** арга хэмжээний хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, JCI төрийн бус байгууллага, Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо, Телевизүүдийн холбоо, “Монголын эмэгтэйчүүдийн холбоо”, “Эцэг, эхийн холбоо”, “Хөөрхөн зүрхний аян”, “Лантуун дохио”, “Үжин төв” зэрэг төрийн бус байгууллагууд, УИХ-ын эмэгтэй гишүүдийн холбоо, Европын холбоо, Empasoft зэрэг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, аж ахуй нэгж иргэнтэй хурал, уулзалт, сургалт, зөвлөгөөнийг 18 удаа зохион байгуулж, зорилтот 6, урлаг, соёл, спортын олны танил хүнийг оролцуулан нийт 20 видео шторк, сэрэмжлүүлэх зурган постер 51, зорилтот мэдээ 35, нийт 112 мэдээ, мэдээлэл, контентыг шинээр бүтээж, нийтийн цахим сүлжээгээр түгээснийг 3.726.675 хүн үзэж, 136.159 хүн бусадтай хуваалцсан.

2. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр **“Хуурамч Мөнгө”** хэсэгчилсэн арга хэмжээг улсын хэмжээнд Монгол банкны Олон нийттэй харилцах төвтэй хамтран зохион байгуулж хуурамч мөнгөн тэмдэгт үйлдэх, гүйлгээнд оруулахаас урьдчилан сэргийлэх, хуурамч мөнгөн тэмдэгтийг таних аргыг харуулсан видео контент, постерыг бүтээн цахим орчинд байршуулсныг 119.756 хүн үзсэн, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр **“Ятгах тусам нягтал”** арга хэмжээний хүрээнд видео контент 12 хийж үндэсний телевизүүдийн бүх сувгаар нэвтрүүлсэн, сэрэмжлүүлэх постер 27, хэвлэлийн мэдээ 12, видео контент 4, **“Аюулгүй интернэт”** хэрэглэх 5 төрлийн зөвлөмж бүхий постер бэлтгэн, фейсбүүк, твиттерт байршуулан олон гишүүд, дагагч бүхий 222 группэд түгээсэн бөгөөд цахим гэмт хэргийн хохирогчдын дунд хийсэн судалгаанаас үзэхэд өсвөр насны хүүхдүүд ямар нэг хяналтгүйгээр цахим орчныг өргөн хүрээнд ашигладаг нь энэ төрлийн хэрэгт өртөх магадлал өндөр байгааг тогтоон эцэг эхчүүдэд хандсан **“Та хүүхдийхээ цахим хэрэглээнд хяналт тавьж чадаж байна уу?”** зөвлөмж бүхий постер, сэтгэгцэд нөлөөлөх бодисийн талаар сэрэмжлүүлэг ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс фейсбүүкт 8 видео, 30 постер, 25 мэдээ, мэдээллийг олон гишүүд, дагагчтай 20-30 группэд түгээсэн бол, хөдөлмөр аюулгүй ажиллагааны журам зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх **“Аюулгүй байдал-Амьдралын баталгаа”** нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан байна.

3. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгах, иргэдэд хор уршгийг таниулах, олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх зорилгоор **“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл”** нэгдсэн арга хэмжээний хүрээнд **“Яараад яахав дээ”** аянг Оюутолгой, Мобиком компанитай хамтран улсын хэмжээнд зохион байгуулсан нь үр дүнгээ өгч, зам тээврийн ослын хэмжээ 22.3%-иар буурсан байна.

4. Монгол Улсад анх удаа “Сайжруулсан шахмал түлш” хэрэглэх болсонтой холбоотойгоор **“Яндангаа хөөлье”** аяныг ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албатай хамтран зохион байгуулж, угаарын хийн хордлогод өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор сайжруулсан шахмал түлшийг зөв хэрэглэх талаар арга зүйн зөвлөгөө, сэрэмжлүүлгийг айл өрх бүрт хүргэж ажилласнаар иргэд сайжруулсан шахмал түлшийг зөв хэрэглэж хэвшиж байна.

5. Хүүхдийг ахуйн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий **“Гэрийн эмийн санг цэвэрлэж, цэгцэлж хэвшье”**, **“Миний гэр аюулгүй орчин”** сэдвээр зөвлөмжийг бэлтгэн 2200 ширхгийг хэвлүүлж, 1500 ширхгийг нийслэлийн нийтийн тээврийн 700 автобусанд, бусад зөвлөмжийг томоохон зах, худалдааны төв, дэлгүүр, аж ахуй нэгж байгууллага зэрэг хүний хөдөлгөөн ихтэй газарт байршуулан ажилласан.

6. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх **“Ногоон дуу хоолой”** арга хэмжээний хүрээнд бүтээсэн ухуулга нөлөөллийн видео контент 11, сэрэмжлүүлэх мэдээлэл 5, постер 12, хэвлэлийн мэдээлэл 4-ийг фейсбүүк, твиттер хуудаст байршуулж олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан.

7. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын үед үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын урам зориг, сэтгэл санааг дэмжих зорилгоор тэдний ажлын ачаалал, эрч хүчийг харуулсан “**Баярлалаа**” видео шторк, 8 постер бэлтгэн 4 телевиз, 6 сайтад ярилцлага, мэдээлэл өгч, цахим орчинд түгээсэн.

8. Сургууль орчимд үйлдэгддэг гэмт хэрэг зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээрт эцэг, эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр “**School police**” эргүүлийг нийслэл болон орон нутгийн нийт 185 ерөнхий боловсролын сургуульд 2019 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тухайн жилийн хичээлийг жилийг дуустал ажиллуулсан,

9. Их, дээд сургууль болон коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2020-2021 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан “**Хичээл эхэллээ**” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хүүхдүүдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 199 удаагийн ажил, арга хэмжээг 603 төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ерөнхий боловсролын 196 сургууль, 68 цэцэрлэг, 40 их, дээд сургууль болон коллежийн 29.972 оюутан, сурагч, багш нарыг хамруулсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2017 оны А/253, А/252 дугаар тушаалын дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сайн дурын бүлгэмийн ажиллах журмын хэрэгжилтийг хангах зорилгоор “**Өсвөрийн сэргийлэгч бүлгэм**”-ийг 476 ерөнхий боловсролын сургуульд ажиллуулан, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангасан.

10. “Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс” албан ёсны пэйж хуудсанд ирүүлсэн бусдыг садар самуунд уруу татсан, архи, тамхины хэрэглээг дэмжсэн, хууль бусаар мөрийтэй тоглоом зохион байгуулж байж болзошгүй газрын талаар гомдол, мэдээллийг тухай бүр холбогдох хэлтэст хүргүүлэн, хуулийн дагуу шалгуулжээ.

11. ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд мэдээлэл тогтмол хүргэх, цагдаагийн байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 25 дугаар суваг ТВ-тэй хамтран “**Амрыг эрье**” нэвтрүүлэг, телевизийн урсдаг мэдээгээр гэмт хэрэг, зөрчлөөс сэрэмжлүүлэх, иргэд олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах, **Авто радио 96.3**-ийн шууд эфиртэй хамтран аян замд болгоомжтой зорчих сэрэмжлүүлэг, иргэдийн сонирхсон хууль, эрх зүйн асуултад хариулт өгөх, “Фейсбүүк” цахим орчинд “**Цагдаагийн байгууллагын Урьдчилан сэргийлэх хэлтэс**” пэйж хуудас нээн тогтмол ажиллуулж байна.

Ийнхүү 2020 онд цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа, зохион байгуулж буй ажлын талаар мэдээ, мэдээлэл бэлтгэж, давхардсан тоогоор 5729 телевиз, 1873 радио, 729 сонин хэвлэлд ярилцлага, мэдээлэл өгч, цахим хуудсанд 43.635 мэдээлэл, зурагт, видео контент байршуулсныг давхардсан тоогоор 114.787.728 хүнд хүрсэн байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ПРОКУРОР - PROSECUTOR

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
3. ХЯНАЛТ ТАВЬСАН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ, ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТ
4. ХЯНАЛТ ТАВЬСАН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ
5. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ



## ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

### 1. Прокурорын байгууллагын товч танилцуулга

1930 оны 4 дүгээр сард хуралдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 6 дугаар Их Хурлын шийдвэрийн дагуу Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1930 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор “Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргийн дүрэм”-ийг баталснаар Монгол Улсад Прокурорын байгууллага анх үүсэж хөгжсөн түүхтэй.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1976 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 253 дугаар зарлигаар Прокурорын хяналтын хуулийг анх удаа батлан гаргаж, прокурорын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг баталгаажуулсан байна. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд прокурорын байгууллагын чиг үүргийг “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох” гэж заасан нь өнөөгийн прокурорын байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлсон чухал алхам болсон.

2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Прокурорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт зааснаар Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн. Прокурорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хоёрдугаар бүлэгт зааснаар прокурор нь дараах 5 төрлийн үйл ажиллагааг явуулахаар хуульчлагдсан.

#### *Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт*

Зөрчлийн хэрэг бүртгэлтэд зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд прокурорын хяналт хэрэгждэг бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, улсын хэмжээн дэх зөрчлийн тоо бүртгэлийг нэгтгэн хариуцдаг.

Прокурор зөрчлийн хэрэг, материалыг хянах, танилцах явцдаа зөрчлийн хэрэг бүртгэлтийг бүрэн гүйцэд бодитой явуулах үүднээс тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар өгч болох бөгөөд үүндээ дутуу хийгдсэн болон цаашид хийх ажиллагааны талаар тодорхой заана. Түүнчлэн, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

#### *Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт*

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас эхэлж, хэргийг шалгаж шийдвэрлэх бүхий л явцад байнга, тасралтгүй хэрэгжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль бусаар хязгаарлах явдлыг гаргуулахгүй байхад чиглэнэ.

Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлж буй ажиллагаа, шийдвэрт нь хяналт тавьж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгож, хариуцлага тооцуулах үүрэгтэй.

Түүнчлэн прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйл, мөн Прокурорын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ<sup>1</sup>.

#### *Шүүхэд төрийг төлөөлөх*

#### *Зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох:*

Зөрчлийн хэргийг шалгаж шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтнаас хамаарч захиргааны болон эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэдэг.

<sup>1</sup> Монгол Улсын прокурорын ерөнхий газрын цахим хуудас, <http://prokuror.mn/page/4106>



Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалгаж шийтгэл оногдуулж шийдвэрлэснийг үндэслэлгүй гэж үзвэл шийдвэрийг хүчингүй болгуулах, өөрчлөлт оруулахаар прокурорын дүгнэлт бичиж оролцохоос гадна эрх бүхий албан тушаалтнаас шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авахуулах саналыг шүүхэд хүргүүлсэн, зөрчилд оногдуулсан шийдвэрийг оролцогч эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргасан тохиолдолд, мөн төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр тус тус зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд прокурор оролцож тайлбар, дүгнэлт гаргана.

*Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох:*

Прокурор анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож, шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг нотлох үүрэг хүлээдэг. Шүүх шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэр уншиж сонсгосны дараа, улсын яллагч гэм буруутайд тооцсон Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсгийн хүрээнд шүүгдэгчид оногдуулах ялын төрөл, хэмжээ, хорих байгууллагын нөхцөл, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх болон бусад асуудлын талаар дүгнэлт гаргадаг.

Прокурор шүүхийн шийдвэрийг хүлээн аваад шүүхийн тогтоол хэргийн бодит байдалтай нийцээгүй, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг ноцтой зөрчсөн гэж үзвэл давж заалдах шатны шүүхэд эсэргүүцэл бичнэ. Давж заалдах шатны шүүх хуралдаанд прокурор хэргийн оролцогчийн гаргасан гомдол үндэслэлтэй эсэх, эсэргүүцлийн хууль зүйн үндэслэл, хэргийн нотлох баримтыг шинжлэн судлан, үйл баримт, бодит байдлын талаар тайлбарлаж, дүгнэлт гарган оролцдог. Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэж үзвэл, магадлалыг гардаж авснаас хойш 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд эсэргүүцэл бичнэ. Хяналтын шатны шүүх хуралдаанд прокурор анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалын хууль зүйн үндэслэл, Эрүүгийн хуулийн зөрүүтэй хэрэглээ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргаж оролцоно. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Улсын Ерөнхий прокурорын газрын шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн прокурор оролцдог бөгөөд шүүхийн шийдвэртэй танилцаад үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй гарсан алдааг залруулахаар тухайн шатны шүүхэд нь санал гаргах боломжтой<sup>2</sup>.

*Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах*

Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл, төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар иргэний болон захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцож, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалдаг.

Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл, төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэсэн зохицуулалттай холбоотойгоор тус алба нь хуулиар прокурорт олгосон эрх, үүргийн хүрээнд төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготой.

*Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих*

<sup>2</sup> Монгол Улсын прокурорын ерөнхий газрын цахим хуудас, <http://prokuror.mn/page/4109>



Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд прокурорын байгууллагын чиг үүргийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж тодорхойлсон.

Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа:

-Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;

-Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;

-Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;

-Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэхийг хянана гэж заасан<sup>3</sup>.

Прокурорын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт “Прокурорын байгууллага Улсын Ерөнхий прокурорын газар, аймаг, нийслэлийн прокурорын газар, сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газраас бүрдэнэ” гэж заасан ба 43.2 дахь хэсэгт “Прокурорын хяналтын ажлын онцлогийг харгалзан дагнасан прокурорын газар байгуулж болно” гэжээ. Одоо манай улсад хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, төмөр зам, нисэхийн объектод үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий дагнасан прокурорын газар болох “Тээврийн прокурорын газар” ажиллаж байна. Улсын ерөнхий прокурорын газар, 21 аймаг, Нийслэл, Тээврийн прокурорын газар, 8 сум дундын болон 8 дүүргийн прокурорын газруудаас бүрддэг ба нийт 39 нэгж үйл ажиллагаа явуулж байна<sup>4</sup>.

## **2.Гомдол, мэдээлэл**

### **2.1.Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл**

Прокурорын байгууллагаас 2020 онд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 67312 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд хяналт тавьж ажилласан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал буурсан үзүүлэлттэй буюу 2019 онд 73860 байсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл нь 67312 болж 8.9 хувиар буурсан байна.

Прокурорын байгууллага мөн 2020 онд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 116481 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэлд хяналт тавьж ажилласан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал, буурсан үзүүлэлттэй буюу 2019 онд 227688 байсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл нь 116481 болж 48.85 хувиар буурсан байна.

Нийт 67312 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 35702, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 26657, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 4953 байна. Үүнээс нийслэлд 49006 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл хамаарах бөгөөд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 28192, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 18255, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 2559 байгаа бол орон нутагт нийт прокурорын байгууллагын хяналт тавьсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 18306, үүнээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 7510, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 8402, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 2394 тус тус байна. Үүнийг нийслэлийн болон орон нутгийн прокурорын нэгжүүдээр харьцуулж харуулбал дараах үзүүлэлттэй байна.

<sup>3</sup> Монгол Улсын прокурорын ерөнхий газрын цахим хуудас, <http://prokuror.mn/page/4108>

<sup>4</sup> Мөн тэнд, <http://prokuror.mn/page/4097>

Хүснэгт №1. Нийслэлийн прокурорын байгууллагуудын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд

	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
УЕПГ	0	0	0
Нийслэл ПГ	510	599	12
Баянгол ДПГ	5,584	3,177	135
Баянзүрх ДПГ	6,441	4,087	876
Сонгинохайрхан ДПГ	6,121	2,881	335
Сүхбаатар дүүргийн ПГ	3,221	2,429	405
Хан-Уул ДПГ	2,108	2,244	151
Чингэлтэй ДПГ	2,721	1,878	363
Багануур ДПГ	164	107	73
Налайх, Багахангай ДПГ	260	328	65
Тээврийн ПГ	1,062	525	

Дээрх үзүүлэлтээс үзвэл, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байдлаар Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн прокурорын газрууд тэргүүлж байгаа бол Улсын ерөнхий прокурорын газар, Багануур, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газрууд хамгийн бага үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсний тухайд хамгийн их нь мөн Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь өмнөхтэй адил Багануур, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газрууд байна.

Хүснэгт №2. Орон нутгийн прокурорын байгууллагуудын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд

	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
Архангай АПГ	306	409	145
Баян-Өлгий АПГ	200	357	26
Баянхонгор АПГ	373	394	163
Булган АПГ	217	347	95
Говь-Алтай АПГ	286	170	45
Говьсүмбэр АПГ	110	180	22
Дархан-Уул АПГ	333	452	195
Дорноговь АПГ	316	436	72
Дорнод АПГ	991	577	196
Дундговь АПГ	224	291	22
Завхан АПГ	114	249	62
Орхон АПГ	659	460	181
Өвөрхангай АПГ	145	400	109
Өмнөговь АПГ	400	535	96
Сүхбаатар аймгийн ПГ	424	327	138
Сэлэнгэ АПГ	386	618	92
Төв АПГ	807	606	250
Увс АПГ	210	146	91
Ховд АПГ	413	304	182
Хөвсгөл АПГ	235	540	135
Хэнтий АПГ	361	604	77

Орон нутгийн прокурорын байгууллагын тухайд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн тохиолдол Дорнод, Төв, Орхон аймгийн прокурорын газруудад хамгийн их, Говьсүмбэр, Завхан, Өмнөговь аймгийн прокурорын газруудад хамгийн бага, хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсэн тохиолдол Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгийн прокурорын газруудад хамгийн их, Увс, Говь-Алтай, Говьсүмбэр аймгийн прокурорын газруудад хамгийн бага, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдол Төв, Дархан-Уул, Дорнод аймгийн прокурорын газруудад хамгийн их, Дундговь, Говьсүмбэр, Баян-Өлгий аймгийн прокурорын газруудын хувьд хамгийн бага байх үзүүлэлтийг тус тус үзүүлж байна.

## 2.2.Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл

2020 оны байдлаар прокурорын байгууллагаас хяналт тавьсан нийт 116481 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллээс зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан 84749, зөрчлийн хэрэг нээсэн 29910, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 1508, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 314 гэсэн шийдвэрлэлтийн байдалтай байна. Үүнээс нийслэлд 87549 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл хамаарах бөгөөд зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан 70719, зөрчлийн хэрэг нээсэн 15907, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 827, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 96 байгаа бол орон нутагт нийт прокурорын байгууллагын хяналт тавьсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 28932, үүнээс зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан 14030, зөрчлийн хэрэг нээсэн 14003, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 681, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 218 тус тус байна. Үүнийг нийслэлийн болон орон нутгийн прокурорын нэгжүүдээр харьцуулж харуулбал дараах үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №3. Нийслэлийн прокурорын байгууллагуудын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд*

	Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан	Зөрчлийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
УЕПГ	4	46	0	0
Нийслэл ПГ	290	603	5	0
Баянгол ДПГ	8,518	1,852	59	0
Баянзүрх ДПГ	23,849	3,884	280	83
Сонгинохайрхан ДПГ	18,586	2,671	188	5
Сүхбаатар дүүргийн ПГ	7,442	2,111	165	2
Хан-Уул ДПГ	5,036	2,054	109	3
Чингэлтэй ДПГ	5,612	1,452	10	0
Багануур ДПГ	370	346	9	3
Налайх, Багахангай ДПГ	986	768	2	0
Тээврийн ПГ	26	120	0	0

Дээрх үзүүлэлтээс үзвэл, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байдлаар Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн прокурорын газрууд тэргүүлж байгаа бол Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар хамгийн бага үзүүлэлттэй байна. Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллээс зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсний тухайд хамгийн их нь Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь Улсын ерөнхий прокурорын газар, Багануур дүүргийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар байна. Мөн зөрчлийн шинжтэй гомдол мэдээллээс эрүүгийн хэрэг

бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсэн тохиолдлоос хамгийн их Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь Багануур, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар болон Нийслэлийн прокурорын газар байна. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж шийдвэрлэсэн шийдвэрийн тухайд хамгийн их нь Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрууд бол хамгийн бага нь Нийслэлийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар, Улсын ерөнхий прокурорын газар, Чингэлтэй, Баянгол, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газрууд байх буюу огт тухайн шийдвэрийг гаргаагүй байна.

*Хүснэгт №4. Орон нутгийн прокурорын байгууллагуудын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд*

	Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан	Зөрчлийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
Архангай АПГ	147	554	8	6
Баян-Өлгий АПГ	671	465	45	3
Баянхонгор АПГ	1,078	659	101	0
Булган АПГ	204	604	16	4
Говь-Алтай АПГ	412	443	11	6
Говьсүмбэр АПГ	91	217	25	0
Дархан-Уул АПГ	1,235	504	42	7
Дорноговь АПГ	130	448	16	1
Дорнод АПГ	2,293	556	36	1
Дундговь АПГ	367	169	5	5
Завхан АПГ	290	533	22	3
Орхон АПГ	999	1,273	39	29
Өвөрхангай АПГ	556	1,899	27	25
Өмнөговь АПГ	527	543	44	4
Сүхбаатар аймгийн ПГ	279	430	5	13
Сэлэнгэ АПГ	1,181	794	85	15
Төв АПГ	272	797	27	26
Увс АПГ	574	582	26	4
Ховд АПГ	1,393	846	10	25
Хөвсгөл АПГ	692	736	51	29
Хэнтий АПГ	639	951	40	12

Орон нутгийн прокурорын байгууллагын тухайд зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн тохиолдол Дорнод, Ховд, Дархан-Уул аймгийн прокурорын газруудад хамгийн их, Говьсүмбэр, Дорноговь, Архангай аймгийн прокурорын газруудад хамгийн бага, зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн тохиолдол Орхон, Өвөрхангай, Хэнтий аймгийн прокурорын газруудад хамгийн их, Дундговь, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн прокурорын газруудад хамгийн бага, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн тохиолдол Баянхонгор, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн прокурорын газруудад хамгийн их, Сүхбаатар, Дундговь, Архангай аймгийн прокурорын газруудын хувьд хамгийн бага, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдол Төв, Хөвсгөл, Орхон аймгийн прокурорын газруудад хамгийн их, Говьсүмбэр, Баянхонгор аймгийн прокурорын газруудын хувьд хамгийн бага байх үзүүлэлтийг тус тус үзүүлж байна.

### 3.Хяналт тавьсан эрүүгийн хэрэг, түүний шийдвэрлэлт

#### 3.1.Эрүүгийн хэрэг

2020 онд прокурорын байгууллага нийт 77199 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан байна. Үүнээс хэрэгсэхгүй болгосон 548, шүүхэд шилжүүлсэн 14329, нэгтгэсэн 4994, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан 31064, тухайн жил эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 19001 байна. Тухайн жил шинээр үүссэн хэрэг 34610, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан этгээдийн тоо 16293 (эмэгтэй 2498, насанд хүрээгүй хүн 846) байна. Мөн үүнээс гадна тухайн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн тоо 23303 байх ба үүнээс эмэгтэй 10271, насанд хүрээгүй хүн 1020, амь насаараа хохирсон хүн 2672, эрүүл мэндээрээ хохирсон хүн 10197, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн 362 байсан байна. Хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийг тусад нь авч үзвэл, 2020 онд тухайн жил шинээр бий болсон мөрдөн байцаалтын хэрэг 19001 байгаа бол үлдсэн 58198 хэрэг нь хэрэг бүртгэлтийн болон өмнө нь байсан мөрдөн байцаалтын хэрэг байна.

Энэ нь өмнөх оны хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавьсан хэргээс буюу 88431 хэргээс 12.71%-иар буурсан үзүүлэлтийг харуулж байна. Мөн шинээр бий болсон мөрдөн байцаалтын хэрэг нь өмнөх оны шинээр бий болсон мөрдөн байцаалтын хэрэг болох 19228 хэргээс 1.19%-иар буурсан үзүүлэлттэй, мөн хэрэг бүртгэлтийн болон өмнө нь байсан мөрдөн байцаалтын хэрэг 69203 хэргээс 15.91%-иар тухайн жилийн хэрэг бүртгэлтийн болон өмнө нь байсан мөрдөн байцаалтын хэрэг буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №5. Прокурорын хяналт тавьсан эрүүгийн хэрэг

	Прокурорын байгууллагын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргүүд	Шинээр бий болсон мөрдөн байцаалтын хэрэг	Хэрэг бүртгэлтийн болон өмнө нь байсан мөрдөн байцаалтын хэрэг
2019	88431	19228	69203
2020	77199	19001	58198
Өөрчлөлтийн үзүүлэлт	-12.71%	-1.19%	-15.91%

2020 онд прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийг хэргийн шийдвэрлэсэн байдал, яллагдагчийн байдал, хохирогчийн байдлаар нь өмнөх онтой харьцуулсан байдлаар тодорхойлбол дараах үзүүлэлттэй байна.

#### 3.2.Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтийн хувьд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдол буурсан, шүүхэд шилжүүлж шийдвэрлэсэн тохиолдол өссөн, нэгтгэж шийдвэрлэсэн тохиолдол буурсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн тохиолдол өссөн, тухайн жил шинээр гэмт үүссэн гэмт хэрэг буурсан үзүүлэлтийг тус тус үзүүлж байна.

Хүснэгт №6. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

	Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	Тухайн жил шинээр үүссэн гэмт хэрэг
2019	741	13841	5201	27036	49539
2020	548	14329	4994	31064	34610
Өөрчлөлтийн үзүүлэлт	-26.05%	+3.41%	-3.99%	+12.97%	-30.14%



**Яллагдагч.** Прокурорын байгууллагаас хянасан мөрдөн байцаалтын хэрэгт яллагдагчаар татагдсан этгээдүүд ерөнхийдөө өссөн байна. Үүнээс эмэгтэй яллагдагчийн тоо огцом өссөн байгаа бол насанд хүрээгүй яллагдагчийн тоо буурсан байна.

*Хүснэгт №7. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан этгээд*

	Тухайн жил эрүүгийн хэрэг үүсч яллагдагчаар татагдсан яллагдагчийн тоо	Эмэгтэй яллагдагч	Насанд хүрээгүй яллагдагч
2019	16089	2275	854
2020	16293	2498	846
Өөрчлөлтийн үзүүлэлт	+1.26%	+8.93%	-0.94%

**Хохирогч.** Прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн тоон үзүүлэлт нь ерөнхий байдлаар огцом уналттай байна. Энэ нь нийт хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг багассантай холбоотой. Үүнийг дотор нь дэлгэрүүлж үзвэл эмэгтэй, насанд хүрээгүй хохирогчдын тоо огцом буурсан, эрүүл мэндээрээ хохирсон хүний тоо огцом өссөн байна.

*Хүснэгт №8. Хэргийн хохирогч 2019, 2020 оны харьцуулсан үзүүлэлтүүд*

	Нийт хохирогч	Эмэгтэй хохирогч	Насанд хүрээгүй хохирогч	Амь насаараа хохирсон хүн	Эрүүл мэндээрээ хохирсон хүн	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн
2019	30782	13733	1598	-	8727	-
2020	23303	10271	1020	2672	10197	362
Өөрчлөлтийн үзүүлэлт	-24.3%	-22.40%	-36.18%	-	+14.42%	-

### 3.2.1. Гэмт хэргийн төрөл

*Хүснэгт №9. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг)*

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
10.1 дүгээр зүйл. Хүнийг алах	507	6	271	4	30	234
10.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах	3	1	1	0	0	2
10.3 дугаар зүйл. Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах	0	0	0	0	0	0
10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	3215	0	7	0	2782	2475
10.5 дугаар зүйл. Эх нярай хүүхдээ алах	14	0	3	0	4	11
10.6 дугаар зүйл. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	208	8	81	0	43	104
Нийт	3932	15	358	4	2854	2819

Нийт 3932 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс хүнийг алах гэмт хэрэг, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох, шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд хүнийг алах, нэгтгэсэн хэргийн тухайд хүнийг алах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №10. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг)*

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	782	10	409	3	99	391
11.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах	4	0	1	0	0	1
11.3 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	139	5	62	0	30	73
11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	1059	21	712	10	117	754
11.5 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	159	3	24	1	81	92
11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	10129	160	6306	185	2033	7233
11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	324	5	149	12	99	224
Нийт	12259	199	7428	203	2455	8543

Нийт 12259 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн гэмт хэргийн тухайд хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №11. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг(Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
12.1 дүгээр зүйл.Хүчиндэх	1143	27	388	10	368	626
12.2 дугаар зүйл.Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	32	4	11	0	7	25
12.3 дугаар зүйл.Бэлгийн мөлжлөг	13	0	2	0	6	3
12.5 дугаар зүйл.Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	189	2	58	3	72	114
12.6 дугаар зүйл.Биеэ үнэлэхийг зохион байгуулах	22	0	2	0	7	22
Нийт	1382	33	449	13	460	780

Прокурорын байгууллага нийт 1386 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс хүчиндэх, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн гэмт хэргийн тухайд хүчиндэх гэмт хэрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №12. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
13.1 дүгээр зүйл.Хүн худалдаалах	34	1	9	0	8	15
13.2 дугаар зүйл.Хүн хулгайлах	10	0	2	0	3	4
13.3 дугаар зүйл.Хүн барьцаалах	2	0	0	0	1	1
13.4 дүгээр зүйл.Хүнийг хүчээр алга болгох	7	0	3	0	2	1
13.5 дугаар зүйл.Заналхийлэх	146	0	20	3	89	77
13.6 дугаар зүйл.Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох	57	0	27	3	19	37
13.7 дугаар зүйл.Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх	1	0	0	0	1	1

13.8 дугаар зүйл.Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах	2	0	0	0	2	2
13.9 дүгээр зүйл.Хууль бусаар баривчлах, саатуулах	7	0	2	0	2	5
13.10 дугаар зүйл.Хувь хүний нууцад халдах	54	1	2	22	19	38
13.11 дүгээр зүйл.Хувь хүний нууцыг задруулах	18	0	4	0	9	9
13.12 дугаар зүйл.Хууль бусаар мөрдөж мөшгих	16	0	4	2	7	9
13.13 дугаар зүйл.Албадан хөдөлмөрлүүлэх	4	0	0	0	3	1
13.14 дүгээр зүйл.Худал мэдээлэл тараах	263	0	19	3	122	258
Нийт	607	2	89	33	285	448

2020 онд нийт 607 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс заналхийлэх, худал мэдээлэл тараах гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд хүн худалдаалах, шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох, нэгтгэсэн хэргийн тухайд хувь хүний нууцад халдах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд худал мэдээлэл тараах, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд худал мэдээлэл тараах гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №13. Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 14 дугаар бүлэг)*

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
14.1 дүгээр зүйл.Ялгаварлан гадуурхах	5	0	1	0	3	2
14.2 дугаар зүйл.Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах	0	0	0	0	0	0
14.3 дугаар зүйл.Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах	1	0	1	0	0	0
14.4 дүгээр зүйл.Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах	0	0	0	0	0	0
14.5 дугаар зүйл.Иргэн сонгуулийн эрхээ	25	0	0	0	12	23

эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх						
14.6 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх	0	0	0	0	0	0
14.7 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах	3	0	0	0	2	1
14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах	27	0	0	0	17	26
14.9 дүгээр зүйл. Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах	2	0	0	0	1	1
Нийт	63	0	2	0	35	53

2020 онд нийт 63 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх, сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон хэргийн болон нэгтгэсэн хэрэг огт байхгүй байна. Шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах, ялгаварлан гадуурхах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэргүүд хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №14. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг(Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлэг)*

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
15.1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх	119	8	12	1	53	43
15.2 дугаар зүйл. Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх	10	0	5	0	1	6
15.3 дугаар зүйл. Хүний цус, эд, эрхтнийг хууль бусаар авах	1	0	0	0	1	0
15.4 дүгээр зүйл. Хүний цус, эд, эрхтнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах	1	0	0	0	0	1
15.5 дугаар зүйл. Хууль бусаар үр хөндөх	1	0	0	0	1	1



15.6 дугаар зүйл.Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах	3	0	0	0	1	2
Нийт	135	8	17	1	57	53

2020 онд нийт 135 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд мөн эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №15. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
16.1 дүгээр зүйл.Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах	9	0	6	2	1	3
16.2 дугаар зүйл.Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах	3	0	1	0	1	2
16.3 дугаар зүйл.Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх	18	0	2	0	6	7
16.4 дүгээр зүйл.Хүүхдээр гуйлга гуйлгах	2	0	0	0	2	0
16.5 дугаар зүйл.Хүүхэд солих	0	0	0	0	0	0
16.6 дугаар зүйл.Хүүхэд худалдах	0	0	0	0	0	0
16.7 дугаар зүйл.Хүүхэдтэй хэрцгий харьцах	6	0	1	0	4	5
16.8 дугаар зүйл.Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах	29	0	10	2	7	16
16.9 дүгээр зүйл.Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах	0	0	0	0	0	0
16.10 дугаар зүйл.Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх	0	0	0	0	0	0
16.11 дүгээр зүйл.Хүүхдийг	12	1	4	0	3	8

асран хамгаалах үүргээ үл биелүүлэх						
Нийт	77	1	24	4	23	39

Нийт 77 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх, шүүхэд шилжилжүүлсэн хэргийн тухайд хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, нэгтсэн хэргийн тухайд хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргүүд өндөр үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №16. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг)*

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
17.1 дүгээр зүйл. Хулгайлах	28767	88	1818	1711	12955	7640
17.2 дугаар зүйл. Дээрэмдэх	3433	11	326	162	1553	618
17.3 дугаар зүйл. Залилах	12486	49	979	2376	4237	6063
17.4 дүгээр зүйл. Хөрөнгө завших	1600	18	308	41	674	702
17.5 дугаар зүйл. Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших	2498	10	345	18	1659	1,253
17.6 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх	62	0	17	1	20	26
17.7 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах	227	13	77	32	51	164
17.8 дугаар зүйл. Эд хөрөнгө устгах, гэмтээх	877	19	177	4	483	508
17.9 дүгээр зүйл. Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах	13	1	0	0	7	5
17.10 дугаар зүйл. Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих	19	0	3	1	9	3
17.11 дүгээр зүйл. Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх	50	0	7	0	28	25
17.12 дугаар зүйл.	2907	4	408	356	680	1172

Мал хулгайлах						
Нийт	52301	203	4158	4599	22329	17899

Прокурорын байгууллага 2020 онд нийт 52301 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс хулгайлах, залилах гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд хулгайлах, нэгтгэсэн хэргийн тухайд залилах гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №17. Эдийн засгийн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
18.1 дүгээр зүйл.Зах зээл дэх монополь, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах	2	0	0	0	2	0
18.2 дугаар зүйл.Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх	0	0	0	0	0	0
18.3 дугаар зүйл.Татвар төлөхөөс зайлсхийх	84	1	2	4	32	43
18.4 дүгээр зүйл.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчих	6	0	1	0	2	2
18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	130	7	44	6	39	47
18.6 дугаар зүйл.Мөнгө угаах	280	1	90	10	64	148
18.7 дугаар зүйл.Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	221	3	9	1	142	54
18.8 дугаар зүйл.Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж, арилжаанд оролцох	1	0	0	0	0	1
18.9 дүгээр зүйл.Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах	1	0	0	0	0	0
18.10 дугаар зүйл.Зориуд, зохиомлоор дампуурах	2	0	0	0	1	1
18.11 дүгээр зүйл.Хууль бусаар дампууруулах	1	0	0	0	1	0

18.12 дугаар зүйл.Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах	42	0	7	5	13	33
18.13 дугаар зүйл.Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах	14	0	0	1	8	7
18.14 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх	2	0	0	0	1	1
18.15 дугаар зүйл.Хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах	7	1	0	0	3	1
18.16 дугаар зүйл.Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих	11	0	1	0	6	7
18.17 дугаар зүйл.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих	5	0	0	0	4	2
18.18 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системд холбогдох үйл ажиллагаа хууль бусаар эрхлэх	0	0	0	0	0	0
Нийт	760	13	151	26	300	321

2020 онд 760 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах, мөнгө угаах гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд мөнгө угаах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №18. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 19 дугаар бүлэг)*

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
19.1 дүгээр зүйл.Эх орноосоо урвах	1	0	0	0	1	0
19.2 дугаар зүйл.Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, саатуулах	2	0	0	0	0	0
19.3 дугаар зүйл.Төрийн өндөр	0	0	0	0	0	0

албан тушаалтны амь биед халдах						
19.4 дүгээр зүйл.Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах	1	0	1	0	0	0
19.5 дугаар зүйл.Зэвсэгт үймээн дэгдээх	0	0	0	0	0	0
19.6 дугаар зүйл.Хорлон сүйтгэх	1	0	1	0	0	0
19.7 дугаар зүйл.Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх	0	0	0	0	0	0
19.8 дугаар зүйл.Экстремист үйл ажиллагаа явуулах	0	0	0	0	0	0
19.9 дүгээр зүйл.Үндэсний эв нэгдлийг бусниулах	4	0	0	0	1	0
19.10 дугаар зүйл.Тагнуул хийх	0	0	0	0	0	0
19.11 дүгээр зүйл.Төрийн нууцыг хууль бусаар олж авах	3	0	0	0	0	1
19.12 дугаар зүйл.Төрийн нууцыг задруулах	5	1	0	0	2	3
19.13 дугаар зүйл.Төрийн нууцыг үрэгдүүлэх	6	1	1	0	1	5
19.14 дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх	85	4	22	6	18	40
19.15 дугаар зүйл.Хууль бусаар иргэний харьяалал олж авах	1	0	0	0	1	1
19.16 дугаар зүйл.Хууль бусаар газар орны нэр өөрчлөх	1	0	0	0	0	1
19.17 дугаар зүйл.Улсын хилийн тэмдэг, хилийн шугам дээрх байгууламжийг устгах, гэмтээх, шилжүүлэх	2	0	0	0	0	2



Нийт	111	6	25	6	24	52
------	-----	---	----	---	----	----

Нийт 111 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №19. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг)*

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
20.1 дүгээр зүйл.Террор үйлдэх талаар зориуд худал мэдээлэх	0	0	0	0	0	0
20.2 дугаар зүйл.Террор ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх	0	0	0	0	0	0
20.3 дугаар зүйл.Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх	9	0	3	4	0	5
20.4 дүгээр зүйл.Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших	35	2	14	0	15	16
20.5 дугаар зүйл.Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх	2	0	0	0	1	1
20.6 дугаар зүйл.Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах	1	0	0	0	1	0
20.7 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	346	1	188	40	49	236
20.8 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах	3	0	2	0	0	3
20.9 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд	0	0	0	0	0	0

нөлөөт бодисыг завших						
20.10 дугаар зүйл. Хууль бусаар тариалах	1	0	0	0	0	1
20.11 дүгээр зүйл.Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях	2	0	0	0	2	1
20.12 дугаар зүйл.Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх	2	0	0	0	2	1
20.13 дугаар зүйл.Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах	11	0	0	0	6	4
20.14 дүгээр зүйл.Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	40	3	6	3	19	19
20.15 дугаар зүйл.Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохио хамгаалалтгүй байлгах	33	0	13	0	18	22
20.16 дугаар зүйл.Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	131	0	31	2	59	32
20.17 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом зохион байгуулах	87	0	18	8	14	75
Нийт	694	6	272	55	184	409

Прокурорын байгууллага 2020 онд нийт 694 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн хэргийн тухайд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна

Хүснэгт №20. Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
21.1 дүгээр зүйл. Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах	164	2	28	3	75	84
21.2 дугаар зүйл. Худал мэдүүлэх	134	4	71	2	23	68
21.3 дугаар зүйл. Худал орчуулах, хэлмэрчлэх	0	0	0	0	0	0
21.4 дүгээр зүйл. Шинжээч зориуд худал дүгнэлт гаргах	27	0	1	3	17	13
21.5 дугаар зүйл. Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх	23	0	13	1	0	9
21.6 дугаар зүйл. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх	7	0	1	0	2	7
21.7 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх	121	1	2	0	83	55
21.8 дугаар зүйл. Хуульчийн мэргэжлийн нэрийг хууль бусаар хэрэглэх	6	0	0	0	3	5
21.9 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах	9	0	0	0	8	5
21.10 дугаар зүйл. Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх	13	0	1	0	7	9
21.11 дүгээр зүйл. Оргон зайлах	20	0	5	2	8	5
21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах	60	0	3	0	47	33
21.13 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих	11	0	2	0	6	6

21.14 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах	7	0	2	0	3	2
Нийт	582	7	116	11	282	293

Прокурорын байгууллага 2020 онд 582 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах, худал мэдүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд худал мэдүүлэх, нэгтгэсэн хэргийн тухайд нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах, шинжээч зориуд худал дүгнэлт гаргах хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №21. Авлигын гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс			Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн		
22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	825	16	111	27	322	444
22.2 дугаар зүйл.Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах	3	0	2	0	1	2
22.3 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах	0	0	0	0	0	0
22.4 дүгээр зүйл.Хахууль авах	241	5	66	13	48	121
22.5 дугаар зүйл.Хахууль өгөх	151	4	67	8	11	76
22.6 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах	0	0	0	0	0	0
22.7 дугаар зүйл.Улсын нөөцийг хууль	0	0	0	0	0	0

бусаар зарцуулах, үрэгдүүлэх						
22.8 дугаар зүйл.Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	30	3	5	0	7	15
22.9 дүгээр зүйл.Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	1	0	0	0	1	0
22.10 дугаар зүйл.Үндэслэлгүй гээр хөрөнгөжих	50	2	2	2	21	20
22.11 дүгээр зүйл.Дураараа аашлах	5	0	0	0	2	2
22.12 дугаар зүйл.Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	28	1	3	4	7	15
Нийт	1101	25	176	33	402	579

Нийт 1101 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №22. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг(Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэг)*

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
23.1 дүгээр зүйл.Хууль сахиулагчийг эсэргүүцэх	198	2	116	3	33	143
23.2 дугаар зүйл.Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах	412	24	58	24	183	195
23.3 дугаар зүйл.Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт хулгайлах, устгах, гэмтээх, нуух	30	0	5	1	12	16
23.4 дүгээр зүйл.Улсын бүртгэлд зориуд худал мэдээлэл оруулах, хуурамч	14	1	2	1	4	7



баримт бичиг үйлдэх						
23.5 дугаар зүйл.Хайнга хандах	32	2	5	0	12	18
23.6 дугаар зүйл.Хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах	0	0	0	0	0	0
23.7 дугаар зүйл.Нийтийн албан тушаалтныг заналхийлэх	3	0	1	0	2	1
Нийт	684	29	187	28	246	377

Прокурорын байгууллага нийт 684 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №23. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
24.1 дүгээр зүйл.Байгаль орчныг бохирдуулах	12	0	1	0	6	7
24.2 дугаар зүйл.Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	519	3	126	10	189	370
24.3 дугаар зүйл.Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	46	0	18	0	10	26
24.4 дүгээр зүйл.Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах	1	0	0	0	0	1
24.5 дугаар зүйл.Хууль бусаар ан агнах	154	1	71	2	41	111
24.6 дугаар зүйл.Хууль бусаар мод бэлтгэх	465	8	249	7	145	369
24.7 дугаар зүйл.Ой, хээрийн түймэр тавих	31	0	6	0	19	11
24.8 дугаар зүйл.Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх	72	1	28	4	15	40

24.9 дүгээр зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах	6	0	0	0	3	2
Нийт	1292	13	490	23	427	927

Нийт 1292 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд хууль бусаар мод бэлтгэх, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан хэргийн тухайд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №24. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг(Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
25.1 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах	5	0	2	0	1	2
25.2 дугаар зүйл. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах	4	0	0	1	0	0
25.3 дугаар зүйл. Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх	5	1	1	0	0	4
25.4 дүгээр зүйл. Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх	5	0	0	0	3	2
25.5 дугаар зүйл. Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах	1	0	0	0	0	0
25.6 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх	0	0	0	0	0	0
Нийт	20	1	3	1	4	8

2020 онд 20 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах, соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх, хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн хэргийн тухайд түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх гэмт хэргүүд тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №25. Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
26.1 дүгээр зүйл.Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	304	1	21	65	51	208
26.2 дугаар зүйл.Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах	7	0	1	0	3	4
26.3 дугаар зүйл.Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах	8	0	0	0	4	6
Нийт	315	1	22	65	56	216

Прокурорын байгууллага 2020 онд нийт 315 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс цахим мэдээлэлд хууль бусаар халдах гэмт хэрэг гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд цахим мэдээлэлд хууль бусаар халдах гэмт хэрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №26. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
27.1 дүгээр зүйл.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, усан онгоц, агаарын хөлгийн хөдөлгөөнд аюултайгаар халдах	2	0	1	0	1	2
27.2 дугаар зүйл.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, усан онгоц, агаарын хөлгийн хөдөлгөөнд аюул учруулах	2	0	0	0	2	1
27.3 дугаар зүйл.Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих	9	0	0	0	9	7

27.4 дүгээр зүйл. Нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох	0	0	0	0	0	0
27.5 дугаар зүйл. Осол, зөрчилд өртсөн агаарын хөлгийн бодит хяналтын хэрэгслийг устгах, гэмтээх	1	0	1	0	0	0
27.6 дугаар зүйл. Агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгаж гэмтээх, нислэгийн хөдөлгөөнд саад учруулах	0	0	0	0	0	0
27.7 дугаар зүйл. Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах	0	0	0	0	0	0
27.8 дугаар зүйл. Агаарын хөлгийг авч зугтаах	0	0	0	0	0	0
27.9 дүгээр зүйл. Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	1	0	0	0	1	0
27.10 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1973	14	1079	4	609	1385
27.11 дүгээр зүйл. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах	101	0	57	0	25	69
Нийт	2080	14	1134	4	638	1464

Нийт 2080 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, шүүхэд шилжүүлсэн, нэгтгэсэн, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт №27. Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг(Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
28.1 дүгээр зүйл.Тушаал биелүүлэхгүй байх	0	0	0	0	0	0
28.2 дугаар зүйл.Дарга, захирагчаа эсэргүүцэх	1	0	1	0	0	0
28.3 дугаар зүйл.Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	5	0	2	0	1	4
28.4 дүгээр зүйл.Бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих	2	0	2	0	0	0
28.5 дугаар зүйл.Цэргийн албанаас оргон зайлах	8	0	2	0	3	5
28.6 дугаар зүйл.Биедээ гэмтэл учруулах, өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх	0	0	0	0	0	0
28.7 дугаар зүйл.Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших	2	0	1	0	0	0
28.8 дугаар зүйл.Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх	0	0	0	0	0	0
28.9 дүгээр зүйл.Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих	0	0	0	0	0	0
28.10 дугаар зүйл.Байлдааны машин жолоодох, ашиглалтын журам зөрчих	0	0	0	0	0	0
28.11 дүгээр зүйл.Байлдааны, сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих	0	0	0	0	0	0
28.12 дугаар зүйл.Байлдааны	0	0	0	0	0	0



жижүүр хийх журам зөрчих						
28.13 дугаар зүйл.Дотоод албаны журам зөрчих	0	0	0	0	0	0
28.14 дүгээр зүйл.Харуулын албаны журам зөрчих	0	0	0	0	0	0
28.15 дугаар зүйл.Хилийн алба хаах журам зөрчих	2	0	1	0	0	1
28.16 дугаар зүйл.Байлдааны талбарыг дур мэдэн орхих, дайсантай зэвсэг барьж байлдахаас зайлсхийх	0	0	0	0	0	0
28.17 дугаар зүйл.Сайн дураараа дайсанд бууж өгөх	0	0	0	0	0	0
28.18 дугаар зүйл.Байлдааны талбарт тонуул хийх	0	0	0	0	0	0
28.19 дүгээр зүйл.Байлдааны талбарт Улаан загалмайн тэмдгийг хууль бусаар зүүх, урвуулан ашиглах	0	0	0	0	0	0
Нийт	20	0	9	0	4	10

Нийт 20 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба үүнээс цэргийн албанаас оргон зайлах, дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх гэмт хэрэг дийлэнх хэсгийг эзэлж байна. Хэрэгсэхгүй болгосон, нэгтгэсэн хэрэг тухайн онд гараагүй ба шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих, цэргийн албанаас оргон зайлах, дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэг хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

2020 онд хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг)-т прокурорын байгууллага хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавиагүй байна.

### 3.2.2.Прокурорын байгууллагын хяналт тавьсан эрүүгийн хэрэг (нутаг дэвсгэрээр)

Хүснэгт №28.Нийслэл дэх прокурорын байгууллагын хяналт тавьсан эрүүгийн хэрэг

Нутаг дэвсгэр дэх прокурорын байгууллагын нэгж	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
Нийслэл ПГ	1601	33	336	161	410	845
Баянгол ДПГ	8893	51	928	776	4202	3478
Баянзүрх ДПГ	13962	65	2006	1061	5903	5538
Сонгинохайрхан ДПГ	8632	66	1197	404	4388	3513
Сүхбаатар дүүргийн ПГ	8954	62	1029	704	4022	3237
Хан-Уул ДПГ	5571	40	775	291	2252	2613

Чингэлтэй ДПГ	6094	22	855	349	2829	2364
Багануур ДПГ	297	2	132	5	93	177
Налайх,Багахангай ДПГ	893	16	245	9	282	492
Тээврийн ПГ	940	4	496	0	359	685
Нийт	55837	361	7999	3760	24740	22942

Тухайн жилд нийслэл дэх прокурорын байгууллагууд нь нийт 55837 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан байна. Үүнээс Баянзүрх дүүргийн прокурорын газар хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 25%-ийг, Багануур дүүргийн прокурорын газар хамгийн бага үзүүлэлттэй буюу 0.5%-ийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, хамгийн их үзүүлэлттэй прокурорын газар нь хамгийн бага үзүүлэлттэй прокурорын газраас 50 дахин илүү хэрэгт хяналт тавьсан байна. Бусад үзүүлэлтийн тухайд хэрэгсэхгүй болгосон хэргийн тоогоор хамгийн өндөр үзүүлэлтийг Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Багануур дүүргийн прокурорын газар, шүүхэд шилжүүлсэн хэргийн тоогоор хамгийн өндөр үзүүлэлтийг Баянзүрх дүүргийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Багануур дүүргийн прокурорын газар, нэгтгэсэн хэргийн тухайд хамгийн өндөр үзүүлэлтийг Баянзүрх дүүргийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Тээврийн прокурорын газар, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан хэргийн тухайд Баянзүрх дүүргийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Багануур дүүргийн прокурорын газар, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд хамгийн өндөр үзүүлэлтийг Баянзүрх дүүргийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Багануур дүүргийн прокурорын газар тус тус үзүүлж байна.

*Хүснэгт №29. Орон нутаг дахь прокурорын байгууллагын хяналт тавьсан эрүүгийн хэрэг*

Нутаг дэвсгэр дэх прокурорын байгууллагын нэгж	Нийт ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүссэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
Архангай АПГ	1275	6	297	78	330	559
Баян-Өлгий АПГ	593	19	230	46	159	444
Баянхонгор АПГ	1193	3	414	72	415	667
Булган АПГ	847	12	236	21	226	450
Говь-Алтай АПГ	371	2	113	17	115	224
Говьсүмбэр АПГ	316	1	89	12	100	204
Дархан-Уул АПГ	1229	14	416	56	255	638
Дорноговь АПГ	967	9	245	25	297	501
Дорнод АПГ	1388	0	418	87	526	794
Дундговь АПГ	571	7	126	25	187	304
Завхан АПГ	499	1	196	29	106	348
Орхон АПГ	1498	21	407	74	408	699
Өвөрхангай АПГ	1198	11	315	48	338	571
Өмнөговь АПГ	982	8	329	47	308	689
Сүхбаатар аймгийн ПГ	802	1	239	87	154	474
Сэлэнгэ АПГ	1,297	19	392	56	439	811
Төв АПГ	1987	12	660	192	728	991
Увс АПГ	535	9	185	13	135	262
Ховд АПГ	769	13	310	51	203	514
Хөвсгөл АПГ	1616	8	406	98	406	770
Хэнтий АПГ	1429	11	307	100	489	754
Нийт	21362	187	6330	1234	6324	11668

Тухайн жилд орон нутаг дахь прокурорын байгууллагууд нь нийт 21362 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан байна. Үүнээс Дорнод аймгийн прокурорын газар хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 6.5%-ийг, Говьсүмбэр аймгийн прокурорын газар хамгийн

бага үзүүлэлттэй буюу 1.48%-ийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, хамгийн их үзүүлэлттэй прокурорын газар нь хамгийн бага үзүүлэлттэй прокурорын газраас 4.5 дахин илүү хэрэгт хяналт тавьсан байна. Бусад үзүүлэлтийн тухайд хэрэгсэхгүй болгосон хэргийн тоогоор хамгийн өндөр үзүүлэлтийг Орхон аймгийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Дорнод аймгийн прокурорын газар, шүүхэд шилжүүлсэн хэргийн тоогоор хамгийн өндөр үзүүлэлтийг Төв аймгийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Говьсүмбэр аймгийн прокурорын газар, нэгтгэсэн хэргийн тухайд хамгийн өндөр үзүүлэлтийг Төв аймгийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Говьсүмбэр аймгийн прокурорын газар, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан хэргийн тухайд Төв аймгийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Говьсүмбэр аймгийн прокурорын газар, тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд хамгийн өндөр үзүүлэлтийг Төв аймгийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Говьсүмбэр аймгийн прокурорын газар тус тус үзүүлж байна.

#### 4.Хяналт тавьсан зөрчлийн хэрэг, төрөл

##### 4.1.Прокурорын байгууллагын хяналт тавьсан зөрчлийн хэрэг

Прокурорын байгууллага нь 2020 онд нийт 2,237,541 зөрчлийн хэрэгт хяналт тавьж ажилласан байна. Үүнийг шийдвэрлэлтийн байдлаар нь авч үзвэл, газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан 2,107,482, бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан 100,138, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 29,921 байна.

Үүнийг өмнөх жил буюу 2019 оны прокурорын байгууллагын нийт хяналт тавьсан 2,227,533 зөрчлийн хэрэгтэй харьцуулбал, 10,008 хэргээр өссөн буюу 0.45%-иар өссөн үзүүлэлттэй байна. Харин тус хяналт тавьсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийг өмнөх жилтэй харьцуулбал, газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан шийдвэр 4585-аар буюу 0.22%-иар өссөн, бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан шийдвэр 5536-аар буюу 5.53%-иар өссөн, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн шийдвэр 113-аар буюу 0.38%-иар буурсан үзүүлэлтийг тус тус үзүүлж байна.

*Хүснэгт №30. Нийслэл дэх прокурорын байгууллагын хяналт тавьсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд*

	Прокурорын байгууллагын нийт хяналт тавьсан зөрчлийн хэрэг	Газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
2019	2227533	2102897	94602	30034
2020	2237541	2107482	100138	29921
Өөрчлөлтийн үзүүлэлт	+0.45%	+0.22%	+5.53%	-0.38%

*Хүснэгт №31. Нийслэл дэх прокурорын байгууллагын шийдвэрлэсэн зөрчил*

Нутаг дэвсгэр дэх прокурорын байгууллагын нэгж	Нийт хяналт тавьсан зөрчлийн хэрэг
УЕПГ	75
Нийслэл ПГ	3714
Баянгол ДПГ	256660
Баянзүрх ДПГ	216448
Сонгинохайрхан ДПГ	203342
Сүхбаатар дүүргийн ПГ	287216
Хан-Уул ДПГ	208617
Чингэлтэй ДПГ	382888
Багануур ДПГ	26316
Налайх,Багахангай ДПГ	51994
Тээврийн ПГ	1273
Нийт	1638543

Тухайн жилд нийслэл дэх прокурорын байгууллагууд нь нийт 1,638,543 зөрчлийн хэрэгт хяналт тавьсан. Үүнээс Чингэлтэй дүүргийн прокурорын газар нь хамгийн их буюу 382,888 хэрэгт хяналт тавьсан нь нийт зөрчлийн хяналт тавьсан хэргийн 23.4%-тай тэнцэж байна. Харин Улсын Ерөнхий прокурорын газар нь нийт 75 зөрчлийн хэргийн хэрэгт хяналт тавьсан нь хамгийн бага байх ба нийт хэргийн 0.004%-тай тэнцэж байна.

*Хүснэгт №32. Орон нутаг дахь прокурорын байгууллагын хяналт тавьсан зөрчлийн хэргийн үзүүлэлтүүд*

Нутаг дэвсгэр дэх прокурорын байгууллагын нэгж	Нийт хяналт тавьсан зөрчлийн хэрэг
Архангай АПГ	27619
Баян-Өлгий АПГ	12863
Баянхонгор АПГ	28190
Булган АПГ	27011
Говь-Алтай АПГ	19136
Говьсүмбэр АПГ	20715
Дархан-Уул АПГ	46308
Дорноговь АПГ	21918
Дорнод АПГ	20518
Дундговь АПГ	17946
Завхан АПГ	16840
Орхон АПГ	34317
Өвөрхангай АПГ	60316
Өмнөговь АПГ	41096
Сүхбаатар аймгийн ПГ	14999
Сэлэнгэ АПГ	20809
Төв АПГ	69274
Увс АПГ	17333
Ховд АПГ	21696
Хөвсгөл АПГ	24579
Хэнтий АПГ	35515
Нийт	598998

Тухайн жилд орон нутаг дахь прокурорын байгууллагууд нь нийт 598,998 зөрчлийн хэрэгт хяналт тавьсан. Үүнээс Төв аймгийн прокурорын газар нь хамгийн их буюу 69,274 хэрэгт хяналт тавьсан нь нийт зөрчлийн хяналт тавьсан хэргийн 11.6%-тай тэнцэж байна. Харин Баян-Өлгий аймгийн прокурорын газар нь нийт 12893 зөрчлийн хэргийн хэрэгт хяналт тавьсан нь нийт хэргийн 2.15%-тай тэнцэж байна.

*Хүснэгт №33. Зөрчлийн шийдвэрлэлт (нутаг дэвсгэрээр)*

Нутаг дэвсгэр дэх прокурорын байгууллагын нэгж	Газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
УЕПГ	0	27	48
Нийслэл ПГ	15	3093	606
Баянгол ДПГ	246854	7932	1874
Баянзүрх ДПГ	203214	9349	3885
Сонгинохайрхан ДПГ	193184	7486	2672
Сүхбаатар дүүргийн ПГ	278451	6652	2113
Хан-Уул ДПГ	199633	6923	2061
Чингэлтэй ДПГ	372497	8942	1449
Багануур ДПГ	24972	1006	338
Налайх, Багахангай ДПГ	48270	2960	764
Тээврийн ПГ	39	1114	120
Нийт	1567129	55484	15930

Нийслэлийн хувьд зөрчлийн хэргийг газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан нийт 1,567,129 хэрэг бүртгэсэн байна. Мөн зөрчлийн хэргийг бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан хэргийн тухайд 55484 бүртгэгдсэнээс хамгийн их үзүүлэлтийг Баянзүрх дүүргийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Улсын Ерөнхий прокурорын газар, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг нээсэн хэргийн тухайд 15930 бүртгэгдсэнээс хамгийн их үзүүлэлтийг Баянзүрх дүүргийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Улсын Ерөнхий прокурорын газар үзүүлсэн байна.

Хүснэгт №34. Орон нутгийн үзүүлэлт

Нутаг дэвсгэр дэх прокурорын байгууллагын нэгж	Газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
Архангай АПГ	26444	622	553
Баян-Өлгий АПГ	10653	1744	466
Баянхонгор АПГ	23674	3853	663
Булган АПГ	24622	1782	607
Говь-Алтай АПГ	17853	838	445
Говьсүмбэр АПГ	20055	443	217
Дархан-Уул АПГ	42507	3299	502
Дорноговь АПГ	20536	935	447
Дорнод АПГ	17720	2244	554
Дундговь АПГ	17219	560	167
Завхан АПГ	14954	1354	532
Орхон АПГ	27014	6029	1274
Өвөрхангай АПГ	55821	2596	1899
Өмнөговь АПГ	38137	2425	534
Сүхбаатар аймгийн ПГ	12963	1605	431
Сэлэнгэ АПГ	18518	1495	796
Төв АПГ	66315	2167	792
Увс АПГ	13846	2905	582
Ховд АПГ	17930	2914	852
Хөвсгөл АПГ	21394	2456	729
Хэнтий АПГ	32178	2388	949
Нийт	540353	44654	13991

Орон нутгийн хувьд зөрчлийн хэргийг газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан нийт 540,353 хэрэг бүртгэгдсэн ба үүнээс хамгийн их үзүүлэлтийг Төв аймгийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Баян-Өлгий аймгийн прокурорын газар, зөрчлийн хэргийг бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан нийт 44654 хэрэг бүртгэгдсэн ба үүнээс хамгийн их үзүүлэлтийг Баянхонгор аймгийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Говьсүмбэр аймгийн прокурорын газар, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг нээсэн нийт 13991 хэрэг бүртгэгдсэн ба үүнээс хамгийн их үзүүлэлтийг Өвөрхангай аймгийн прокурорын газар, хамгийн бага үзүүлэлтийг Говьсүмбэр аймгийн прокурорын газар тус тус үзүүлж байна.

#### 4.2.Зөрчлийн төрөл

*Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил.* Нийт 19 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 131557 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйл Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил хамгийн их буюу 91465, 5.17 дугаар зүйл Дайчилгааны тухай хууль зөрчих зөрчил хамгийн бага буюу 1 тус тус байна.

*Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчил.* Нийт 26 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 9841 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 6.20 дүгээр зүйл Хүүхдийн



эрхийг зөрчих зөрчил хамгийн их буюу 3215, 6.9, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.16, 6.19, 6.25 дугаар зүйлд зөрчлүүд бүртгэгдээгүй байна.

*Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчил.* Нийт 17 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 1803 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйл Ойн тухай хууль зөрчих зөрчил хамгийн их буюу 298, 7.13 дугаар зүйл Газрын тосны тухай хууль зөрчих зөрчил бүртгэгдээгүй байна.

*Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчил.* Нийт 9 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 4633 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 8.8 дүгээр зүйл Эд хөрөнгө устгах, гэмтээх зөрчил хамгийн их буюу 2274, 8.4 дүгээр зүйл Патентийн тухай хууль зөрчих зөрчил хамгийн бага буюу 10 тус тус байна.

*Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил.* Нийт 11 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 110 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйл Боловсролын тухай хууль зөрчих зөрчил хамгийн их буюу 102, 9.4, 9.5, 9.6, 9.9, 9.10 дугаар зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

*Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил.* Нийт 28 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 6213 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйл Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих зөрчил хамгийн их буюу 5375, 10.9, 10.10, 10.12, 10.14, 10.18, 10.22, 10.23 дугаар зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

*Үнэт цаас, банк санхүү, гааль, татвар, даатгалын журмын эсрэг зөрчил.* Нийт 32 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 20638 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 11.15 дүгээр зүйл Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих зөрчил хамгийн их буюу 16238, 11.4, 11.11, 11.14, 11.16, 11.17, 11.20, 11.23, 11.25, 11.26, 11.27, 11.28, 11.31 дугаар зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

*Барилга, үйлдвэрлэл, эрчим хүчний журмын эсрэг зөрчил.* Нийт 12 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 451 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 12.3 дугаар зүйл Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль зөрчих зөрчил хамгийн их буюу 132, 12.6, 12.7, 12.9, 12.10, 12.12 дугаар зүйлүүдэд заасан зөрчил хамгийн бага буюу 0 тус тус байна.

*Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар тогтоосон журмын эсрэг зөрчил.* Нийт 9 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 791 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 13.5 дугаар зүйл Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх журам зөрчих зөрчил хамгийн их буюу 763, 13.4, 13.7 дугаар зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

*Мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил.* Нийт 12 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 2035749 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйл Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил хамгийн их буюу 1992314, 14.9, 14.12 дугаар зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

*Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил.* Нийт 30 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 27309 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйл Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих зөрчил хамгийн их буюу 14450, 15.8, 15.12, 15.15, 15.28, 15.30 дугаар зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлын болон гадаад иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад зорчих журмын эсрэг зөрчил. Нийт 4 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд нийт тус төрлийн 960 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 16.2 дүгээр зүйл Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчих зөрчил хамгийн их буюу 792, 16.3, 16.4 дүгээр зүйлүүдэд заасан зөрчил бүртгэгдээгүй байна.

Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил. Нийт 1 төрлийн зөрчил хамаардаг ба 2020 онд тус зөрчил болох Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл буюу Сонгуулийн хууль зөрчих 463 зөрчлийн хэрэгт прокурорын байгууллага хяналт тавьсан байна.

## 5. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Хүснэгт №35. Прокурорын гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажлын хүрээнд гаргасан мэдэгдэл, шаардлага, даалгаврын үзүүлэлт

Он	Прокурорын шаардлага	Прокурорын даалгавар	Прокурорын мэдэгдэл
2019	606	56556	2478
2020	440	27132	1627
Өөрчлөлтийн үзүүлэлт	-27,4%	-53%	-34,35%

Дээрх үзүүлэлтээс үзвэл, прокурорын байгууллагын шаардлага, даалгавар, мэдэгдэл 27%-53%-иар багассан байгаа нь харагдаж байна. 2020 оны прокурорын байгууллагын шаардлага, даалгавар, мэдэгдлийг төрлөөр нь авч үзвэл дараах үзүүлэлттэй байна.

Хүснэгт №36. Прокурорын байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажлын хүрээнд гаргасан эрх зүйн хэлбэрүүдийн төрлөөр харуулсан үзүүлэлт

Шаардлага			Даалгавар			Мэдэгдэл		
Зөрчлийн хэрэг бүртгэлтийн чиглэлээр	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээр	Ял эдлүүлэх чиглэлээр	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн чиглэлээр	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээр	Ял эдлүүлэх чиглэлээр	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн чиглэлээр	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээр	Ял эдлүүлэх чиглэлээр
165	118	154	3131	23980	3	357	1068	15

Прокурорын байгууллагын тухайн онд хамаарах шаардлагын хувьд зөрчлийн хэрэг бүртгэлтийн чиглэлээр шаардлага хамгийн их гарсан байгаа хэдий ч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээр, ял эдлүүлэх чиглэлээр шаардлага ойролцоо тоотой бичигдсэн байна. Харин прокурорын байгууллагын даалгаврын тухайд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээрх даалгавар нь нийт даалгаврын 90 орчим хувийг эзэлж байх ял эдлүүлэх чиглэлээр бичигдсэн даалгавар маш бага буюу 3 удаа л бичигдсэн байна. Прокурорын мэдэгдлийн тухайд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээр мэдэгдэл хамгийн их бичигдсэн ба ял эдлүүлэх чиглэлээр мэдэгдэл бага буюу 15 удаа бичигдсэн байна.

Хүснэгт №37. Прокурорын байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил, соён эгээрүүлэх ажил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд

Арга хэмжээ	Огноо
“Мансуурах” зөрчлийг шалган шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаар сургалт	2020.01.09
Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн иргэдэд “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээрх сургалт	2020.01.10
Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний биелэлтийн талаар хамтарсан уулзалт	2020.01.17
Тээврийн прокурорын газраас хамтарсан зөвлөгөөн	2020.01.23
“Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь” сэдэвт илтгэлийн уралдаан	2020.01.24


Чингэлтэй дүүргийн зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн	2020.01.20
“Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бүсчилсэн сургалт	2020.01.18
Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлэлтийн байдалтай гэнэтийн байдлаар танилцсан уулзалт	2020.01.24
“Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудлууд” гарын авлага	2020.01.28
“Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт, анхаарах асуудал” сэдэвт сургалт	2020.01.17
Прокурор, ажилтнууд нэгдэн “pro line” клуб	2020.01.10
“Залилах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл	2020.02.09
Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар сургалт	2020.02.17
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт	2020.03.05
Зөрчлийн хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаар зөвлөгөөн	2020.03.30
Зөрчил гаргасан цэвэр усны үйлдвэрүүдэд хүргүүлсэн прокурорын мэдэгдэл	2020.03.30
Төрийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг/Төрийн аудитын газартай/	2020.04.24
Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлэлтийн байдалтай танилцсан.	2020.04.17
Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль зөрчсөн иргэдийн сургалт	2020.04.20
“Прокурорын хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт шилдэг илтгэлийн уралдаан	2020.04.30
“Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд” сэдэвт гарын авлага	2020.04.25
Авлигын гэмт хэргийн талаар сургалт, яриа таниулга	2020.05.10
“Хорих ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь” сэдвээр сургалт	2020.06.30
Шинэ, залуу мөрдөгчдөд зориулсан сургалт	2020.06.30
“Эрүүдэн шүүхээс ангид байх нь” сэдэвт сургалт	2020.07.06
Сургуулиудын теле камерыг шалгах үйл ажиллагаа	2020.08.24
Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааг явуулахад тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт хамтарсан зөвлөгөөн	2020.09.24
“Монгол Улсад Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” санамж бичиг	2020.09.29
Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2020.09.28
“Эрүүл мэндийн тухай хууль зөрчих”, “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль зөрчих” гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт	2020.09.23
“Зам тээврийн осол, хэрэг гарахад нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, түүнийг арилгах арга зам, цаашид анхаарах асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг	2020.09.30
Тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүмүүст соён гэгээрүүлэх, нийгэмшүүлэх сургалт	2020.10.02
“Эрүү шүүлтээс ангид байх эрх” сэдэвт семинар, хэлэлцүүлэг	2020.10.09
“Хариуцлага дээшлүүлж хамтдаа хөгжье” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг	2020.10.03
Хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх нэгдсэн арга хэмжээ	2020.08.25- 2020.10.15
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг шалгасан.	2020.11.04
Зам тээврийн ослыг бууруулах чиглэлээр үүрэг өгсөн.	2020.11.09
Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар цахим сургалт	2020.11.30
Про подкаст: цахим орчин дахь залилангийн хэргээс сэргийлэх талаар	2020.12.04
Тээврийн хэрэгсэлд мөргөгдсөн осол, хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсан.	2020.12.09

Дээрх үйл ажиллагаануудаас гадна тухайн онд прокурорын байгууллага нь Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Мэргэжлийн хяналтын зэрэг байгууллагатай хамтарсан зөвлөгөөн, сургалт болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, шаардлага, мэдэгдлийг хүргүүлж ажилласан.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

## ШҮҮХ – COURT

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ
3. ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ





## ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ

### 1.Товч танилцуулга

Үндэсний эрх чөлөөний хувьсгал ялсан 1911 оноос Олноо өргөгдсөн Монгол Улсад хууль цаазын 63 бичиг баримт батлагдсанаар бие даасан ариусган шүүн гэсгээх газар байгуулагдаж байсан бол Ардын хувьсгалын үед буюу 1921 оны 3 дугаар сард Дотоод яаманд “Шүүн таслах хэлтэс”, мөн оны 7 дугаар сард Шүүх явдлын яам, орон нутагт “Зарга шийтгэх түр хэлтэс”, Засгийн газрын дэргэд “Түр цагийн шүүх” тус тус байгуулагдсан явдал нь Монголын орчин цагийн шүүх бүрэлдэн тогтох эхлэл болсон.

Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд найрамдах улс тунхагласны дараа 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын гишүүдийн 15 дугаар хурал, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаар “Аливаа шүүн таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай дүрэм”-ийг батлан гаргаж, анхны шүүх гэр контортой, морин өртөөгөөр явж шүүн таслах үүргээ гүйцэтгэдэг, цөөн орон тоотойгоор үүд хаалгаа нээж байсан өдрийг өдгөө орчин цагийн шүүх байгуулагдсан өдөр хэмээн тэмдэглэдэг.


1990 оны ардчилсан хувьсгалаас хойш Монголын улс төр, нийгэм, эдийн засгийн бүтэц, зохион байгуулалтад үндсэн өөрчлөлт гарсны дагуу шүүх мөн эрс шинэчлэгдсэн юм. Ялангуяа 1992 онд шинэ Үндсэн хуулийг тунхаглаж, түүнд шүүх эрх мэдэл гэсэн бүлэг оруулсан ба 1993 онд Шүүхийн тухай хууль батлагдсанаар өнөөгийн шүүхийн бүтэц, зохион байгуулалт бүрэлдэн тогтсон. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал ингэж Үндсэн хуулиар баталгаажсан явдал нь шинэ ардчилсан шүүх оршин тогтнох, хөгжин дэвших суурь болж өгчээ.

Шүүх эрх мэдлийг хуулийн дагуу байгуулагдсан шүүх төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлнэ. Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд шүүх ямар зохион байгуулалтын бүтэц, тогтолцоотой байхыг тодорхой хуульчлан заасан нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хууль зүйн баталгаа болдог.

Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-т “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” хэмээн заасан нь Монгол Улсад шүүх эрх мэдлийг шүүхээс өөр ямар ч төрийн байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх ёсгүйг хуульчлан тунхагласан.

Зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүх хянаж үздэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж хуульчилсан байдаг. Монгол Улсад нийт 117 шүүх байдаг ба дараах байдлаар зохион байгуулагддаг.

Схем №1. Монгол Улсын шүүхийн байгууллагын тогтолцоо





### Анхан шатны шүүх

2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу 2016 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дараах байдлаар Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд болон Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийг байгуулсан байна.

#### Хүснэгт №1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх дүүрэг
2	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг
3	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг
4	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол дүүрэг
5	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Хан-Уул дүүрэг
6	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг
7	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багануур дүүрэг
8	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Налайх дүүрэг
9	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багахангай дүүрэг

#### Хүснэгт №2. Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Иххэт, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд сумд
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн Улиастай, Алдархаан, Дөрвөлжин, Завхан-Мандал, Идэр, Отгон, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Сантмаргац, Сонгино, Шилүүстэй, Яруу, Эрдэнэхайрхан сумд
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн Баяндалай, Булган, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Номгон, Ноён, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумд
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Богд, Уянга, Тарагт, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийн тээл, Хайрхандулаан, Сант, Төгрөг, Баянгол, Арвайхээр сумд
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Зүүнбүрэн, Ерөө, Түшиг, Шаамар, Хүдэр, Жавхлант, Цагааннуур, Хушаат, Сүхбаатар сумд
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн Дөргөн, Буянт, Дарви, Дуут, Жаргалант, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн, Ховд сумд
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн Цэнхэрмандал сумд

### Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд батлагдсан Шүүх байгуулах тухай 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар Аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийг иргэний, эрүүгийн болон захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосны дагуу Нийслэлийн шүүх нь Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх болон зохион байгуулагдаж Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж болон Төв аймгийн Зуунмод, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Заамар, Лүн зэрэг 22 сум, Хэнтий аймгийн Цэнхэр-Мандал сумын нутаг дэвсгэрийг харьяалан шүүн таслах ажлыг хэрэгжүүлсэн байна.

Шүүх байгуулах тухай Монгол Улсын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар давж заалдах шатны шүүхийг байгуулж тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосны дагуу Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх болон өөрчлөгдөж, нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг харьяалан шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Орон нутгийн шүүхийн хувьд 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан “Монгол Улсын Шүүхийн тухай” хуульд “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ,

хүн амын нягтаршил, шийдвэрлэсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна“ гэж заасны дагуу орон нутгийн хувьд давж заалдах шатны 9 шүүхийг байгуулахаар 2013 оны 1 дүгээр сарын 24-нд батлагдсан Шүүх байгуулах тухай хуульд заасан. 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн Шүүх байгуулах тухай хуулийн дагуу орон нутагт давж заалдах шатны 8 шүүх ажиллаж байсан. 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны нийт 25 шүүх ажиллахаар өөрчлөлт оруулсан.

Хүснэгт 3. Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
12	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

15	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
17	Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
20	Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
22	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

### Улсын Дээд Шүүхийн эрүүгийн хэргийн танхим

2012 онд батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар “Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ. Улсын Дээд шүүхийн шүүгч эрүү, иргэн, захиргааны хэргийн дагнасан танхимын аль нэгд харьяалагдах бөгөөд түүнийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх өөр танхимын шүүн таслах ажиллагаанд оролцуулахыг хориглоно.” гэж Улсын Дээд шүүхийн бүрэлдэхүүнийг хуульчлан тогтоож, улмаар хууль батлагдахаас өмнө уг танхимд ажиллаж байсан бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Танхимын тэргүүн болон 7 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн юм.

2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Монгол Улсын бүх шатны 117 шүүхэд нийт 518 шүүгчийн орон тоо байгаагаас анхан шатны шүүхэд 388, давж заалдах шатны шүүхэд 107, хяналтын шатны шүүхэд 23 шүүгч тус тус ажиллаж байна.

## 2. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

### 2.1. Анхан шатны шүүх

Анхан шатны шүүхүүд 2020 онд нийт 19787 хүн, 10 хуулийн этгээдэд холбогдох 15583 эрүүгийн хэрэг хүлээн авснаас 3 хуулийн этгээд, 1214 хүнд холбогдох 662 хэргийг прокурорт буцааж, 218 хүнд холбогдох 150 хэргийг түдгэлзүүлж, 372 хүнд холбогдох 162 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 1 хуулийн этгээд, 134 хүнд холбогдох 62 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хуулийн этгээд, 133 хүнд холбогдох 76 хэргийг цагаатгаж, нийт 13470 хэргийг шийдвэрлэж 5 хуулийн этгээд, 15964 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, үүнээс 2333 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 34 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 13391 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан бөгөөд тайлант хугацааны эцэст 1139 хэргийн үлдэгдэлтэй байна.

2019 онтой дээрх тоон үзүүлэлтийг харьцуулан үзвэл хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 0.3 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо мөн 2.9 хувиар тус тус өсжээ.

*Хүснэгт №5. Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, ял шийтгүүлэгчдийн тоо*

№	Шүүх	Хэргийн тоо		Өсөлт, бууралт		Ял шийтгүүлэгчдийн тоо		Өсөлт, бууралт	
		2019 он	2020 он	Тоо	Хувь	2019 он	2020 он	Тоо	Хувь
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	275	306	31	11.3	261	297	36	13.8
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	196	232	36	18.4	192	246	54	28.1
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	314	400	86	27.4	294	395	101	34.4
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	230	225	-5	-2.2	203	200	-3	-1.5
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	126	106	-20	-15.9	119	94	-25	-21.0
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	106	98	-8	-7.5	104	102	-2	-1.9
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	540	428	-112	-20.7	532	404	-128	-24.1
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	202	138	-64	-31.7	185	116	-69	-37.3
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	343	400	57	16.6	319	380	61	19.1
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	113	114	1	0.9	87	100	13	14.9
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	118	134	16	13.6	103	122	19	18.4
12	Орхон аймаг дахь сум дундын	370	371	1	0.3	340	356	16	4.7

	эрүүгийн хэргийн анхан шатны шүүх								
13	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	217	209	-8	-3.7	174	192	18	10.3
14	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	158	155	-3	-1.9	141	145	4	2.8
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	221	234	13	5.9	194	195	1	0.5
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	205	206	1	0.5	182	170	-12	-6.6
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	393	487	94	23.9	364	462	98	26.9
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	209	187	-22	-10.5	183	184	1	0.5
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	194	201	7	3.6	185	176	-9	-4.9
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	392	387	-5	-1.3	332	348	16	4.8
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	270	211	-59	-21.9	252	216	-36	-14.3
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	156	107	-49	-31.4	147	85	-62	-42.2
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	51	63	12	23.5	46	44	-2	-4.3
24	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	101	108	7	6.9	108	116	8	7.4



25	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	147	163	16	10.9	134	150	16	11.9
26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	177	138	-39	-22.6	165	131	-34	-21.2
27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	83	51	-32	-38.6	81	48	-33	-40.7
28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	83	99	16	19.3	57	62	5	8.8
29	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	75	63	-12	-16.0	84	60	-24	-28.6
30	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1882	2064	182	9.7	1903	2219	316	16.6
31	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1094	1028	-66	-6.0	1113	1091	-22	-1.9
32	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	985	909	-76	-7.7	1005	909	-96	-9.6
33	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1038	1046	8	0.8	1033	1176	143	13.8
34	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	741	794	53	7.2	747	754	7	0.9
35	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1342	1245	-97	-7.2	1368	1297	-71	-5.2
36	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	118	132	14	11.9	115	121	6	5.2
37	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	11	21	10	90.9	8	21	13	162.5
38	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	151	210	59	39.1	151	207	56	37.1
<b>Нийт</b>		<b>13427</b>	<b>13469</b>	<b>38</b>	<b>0.3</b>	<b>13011</b>	<b>13391</b>	<b>380</b>	<b>2.9</b>

**2.1.1. Шийдвэрлэсэн гэмт хэргийн төрөл**

Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хүнийг алах гэмт хэрэг 23 хэргээр буюу 12.3 хувиар, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 41 хэргээр буюу 12.7 хувиар, хүн худалдаалах гэмт хэрэг 6 хэргээр буюу 4 дахин, залилах гэмт хэрэг 110 хэргээр буюу 18.2 хувиар, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 11 хэргээр буюу 6.5 хувиар, бусад төрлийн гэмт хэрэг 375 хэргээр буюу 14.5 хувиар тус тус өссөн бол хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг 139 хэргээр буюу 2.4 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 109 хэргээр буюу 51.9 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 21 хэргээр буюу 6.4 хувиар, хулгайлах гэмт хэрэг 57 хэргээр буюу 3.4 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 47 хэргээр буюу 14.9 хувиар, улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 42 хэргээр буюу 70 хувиар, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 108 хэргээр буюу 9.5 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Ийнхүү 2020 онд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг тус тус буурсан байгаа нь эерэг үзүүлэлт юм.

Хүснэгт №6. Хянан шийдвэрлэсэн зарим хэрэг

№	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо				
		Өсөлт, бууралт				Өсөлт, бууралт				Хорих ял оногдуулах гүйгээр тэнссэн
		2019 он	2020 он	Тоо	Хувь	2019 он	2020 он	Тоо	Хувь	
1.	Хүнийг алах	187	210	23	12.3	190	209	19	10.0	
2.	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	324	365	41	12.7	331	375	44	13.3	0
3.	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	5828	5689	-139	-2.4	6242	6194	-48	-0.8	54
4.	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	210	101	-109	-51.9	176	67	-109	-61.9	31
5.	Хүчиндэх	328	307	-21	-6.4	313	295	-18	-5.8	43
6.	Хүн худалдаалах	2	8	6	4 дахин	7	19	12	2.7 дахин	0
7.	Хулгайлах	1671	1614	-57	-3.4	1691	1637	-54	-3.2	365
8.	Дээрэмдэх	316	269	-47	-14.9	393	303	-90	-22.9	102
9.	Залилах	604	714	110	18.2	522	719	197	37.7	84

10.	Улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх	60	18	-42	-70.0	73	18	-55	-75.3	13
11.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	170	181	11	6.5	154	211	57	37.0	85
12.	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1138	1030	-108	-9.5	650	526	-124	-19.1	501
13.	Бусад	2589	2964	375	14.5	2269	2818	538	24.2	1055
Нийт		13427	13470	38	0.3	13011	13391	380	2.9	2333

Хянан шийдвэрлэсэн зарим хэргийг ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл, хүнийг алах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 10%-иар, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 13.3%-иар, хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 2.7 дахин, залилах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 37.7%-иар, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 37 хувиар, бусад төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 24.2%-иар тус тус өссөн бол, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 0.8%-иар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 61.9%-иар, хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 5.8%-иар, хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 3.2%-иар, дээрэмдэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 22.9%-иар, улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 75.3%-иар, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 19.1%-иар тус тус буурчээ.

### 2.1.2. Оногдуулсан ял, хариуцлагын төрөл

Анхан шатны шүүхээр 2020 онд 7650 хүн, 5 хуулийн этгээдийг торгох ялаар, 2066 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар, 3670 хүнийг хорих ялаар тус тус шийтгэж, 124 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг, 20 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тус тус хэрэглэсэн байна. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсээс биечлэн эдлүүлсэн 3535, өсвөр насны хүн 105, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 30 хүний шийтгэх тогтоолыг хойшлуулсан байна.

2019 онтой харьцуулахад 2020 онд хорих ял шийтгүүлсэн хүний тоо 4.1 хувиар, нийтэд тустай ажил хийлгэх ялаар ял шийтгүүлсэн хүний тоо 5.1 хувиар, торгох ялаар ял шийтгүүлсэн хүний тоо 1.5 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт №7. Шүүхээс оногдуулсан ял, хариуцлагын төрөл

№	Хэргийн төрөл	Өсөлт, бууралт				Нийт гэм буруутайд тооцогдсоноос эзлэх хувь		Зөрүү /+/,-/
		2019 он	2020 он	Тоо	Хувь	2019 он	2020 он	
1.	Торгох	7533	7655	115	1.5	49	48.0	-1.0
2.	Баривчлах	1	0	-1	-100.0	-	0.0	
3.	Хорих	3520	3670	150	4.2	22.9	23.0	0.1
4.	Нийтэд тустай ажил хийлгэх	1965	2066	101	5.1	12.8	13.0	0.2
5.	Зорчих эрхийг хязгаарлах	0	0	0		-	0.0	
6.	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	124	124	0	0.0	0.8	0.8	0.0
7.	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ	28	20	-8	-28.6	0.2	0.1	-0.1
8.	Хорих ял оногдуулахгүйг эр тэнсэх	2167	2333	166	7.7	14.1	14.6	0.5
9.	Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн	36	96	60	2.7	0.2	0.6	0.4

Эрүүгийн хуульд заасан торгох ялаар 7650 хүн, 5 хуулийн этгээдэд 9 тэрбум 181 сая 140 мянган төгрөгийн торгох ял, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж 227 хүнээс 7 тэрбум 913 сая 356 мянга 752 төгрөг, 3 хуулийн этгээдээс 549 сая 123 мянга 590 төгрөгийг тус тус гаргуулан улсын орлого болгосон байна. Шүүхээс 687 хүнд эрх хасах нэмэгдэл ял хэрэглэж, 1130 хүнд үүрэг хүлээлгэж, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг тус тус хэрэглэсэн байна.

### 2.1.3.Сэжигтнийг баривчлах арга хэмжээ

Монгол Улсын хэмжээнд 2020 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017 он/-ийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 178 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 148 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 30 сэжигтэнд баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ. Баривчлах зөвшөөрөл олгосон нийт хүмүүсийн 0.6%-ийг өсвөр насны хүн, 4.0%-ийг эмэгтэйчүүд тус тус эзэлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтнийг баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоог 2019 онтой харьцуулахад 54 хүнээр буюу 23.3%-иар, баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо 39 хүнээр буюу 20.9%-иар, баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний 15 хүнээр буюу 33.3%-иар тус тус буурсан дүнтэй байна.

Хүснэгт №8. Баривчлагдсан сэжигтний тоо

№	Утга	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоо	232	178	-54	-23.3
2.	Баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо	187	148	-39	-20.9

3.	Баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо	45	30	-15	-33.3
----	---	----	----	-----	-------

#### 2.1.4.Таслан сэргийлэх арга хэмжээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар 2020 онд шүүхээс 3672 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар, 451 хүнд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар, 432 хүн, хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх арга хэмжээг авахуулахаар тус тус ирүүлжээ.


Шүүхээс нийт цагдан хорих зөвшөөрөл олгосон хүмүүсийн 113 буюу 3.8% нь эмэгтэйчүүд, 44 буюу 1.5% нь өсвөр насны хүн байна.

Хүснэгт 9. Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүний тоо

№	Утга	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн хүний тоо	3955	3672	-283	-7.2
2.	Хязгаарлалт тогтох таслан сэргийлэх арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн хүний тоо	680	451	-229	-33.7
3.	Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх	448	432	-16	-33.3
	Үүнээс: хуулийн этгээд	0	11	11	-

2020 онд шүүхээс олгогдсон нийт цагдан хорих зөвшөөрлийн 9.7%-ийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан”, 21.1%-ийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлсан”, 1.1%-ийг “хоширогчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.5%-ийг “гэрчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.8%-ийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн”, 1.9%-ийг өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.3%-ийг “хоширогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.1%-ийг “гэрчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.1%-ийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 17.8%-ийг “гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 11.5%-ийг урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн”, 0.1%-ийг “шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 15.4%-ийг “прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 19.6%-ийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан” үндэслэлээр олгосон байна.

График №2. Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар шүүгчийн гаргасан захирамжийн төрөл



Шүүхээс 2020 онд баривчлах, цагдан хорих талаар нийт 9103 шүүгчийн захирамж гарсан байна. Үүнээс яллагдагчаар цагдан хорих тухай 1623 захирамж, цагдан хорих хугацааг сунгах тухай 5515 захирамж, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай 308 болон Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай 399 захирамж, яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай 294 захирамж гарсан нь нийт захирамжийн 89.4%-ийг эзэлж байна.

Хүснэгт №10. Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар гаргасан шүүгчийн захирамжийн тоо

№	Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар гаргасан нийт шүүгчийн захирамж	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Сэжигтнийг баривчлах тухай	188	166	-22	-11.7
2.	Сэжигтнийг баривчлахаас татгалзах тухай	12	18	6	50.0
3.	Сэжигтнийг суллах тухай	34	12	-22	-64.7
4.	Яллагдагчаар цагдан хорих тухай	1878	1623	-255	-13.6
5.	Яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай	158	294	136	86.1



6.	Шилжүүлэн цагдан хорих тухай	105	166	61	58.1
7.	Шилжүүлэн цагдан хорихоос татгалзах тухай	5	8	3	60.0
8.	Цагдан хорих хугацааг сунгах тухай	3598	5515	1917	53.3
9.	Цагдан хорих хугацааг сунгахаас татгалзах тухай	220	167	53	-24.1
10.	Шүүхэд хянагдаж буй яллагдагчийн хорьж мөрдөх хугацааг сунгах тухай	722	48	-674	-93.4
11.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	181	70	-111	-61.3
12.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	342	308	-34	-9.9
13.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай	246	175	-71	-28.9
14.	Тогтоосон газраас гарч явах тухай	10	0	-10	-
15.	Тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явах тухай	33	32	-1	-3.0
16.	Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай	598	399	199	33.3
17.	Тодорхой газар очихыг хязгаарлах тухай	8	4	-4	-50.0
18.	Тодорхой хүнтэй уулзахыг хориглох тухай	63	61	-2	-3.2
19.	Тогтоосон замаар зорчихыг даалгах тухай	2	0	-2	-
20.	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	53	20	-33	-62.3
21.	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	67	3	-64	-95.5
22.	Төрийн албанд ажиллахыг түдгэлзүүлэх тухай	12	0	-12	-
23.	Тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг түдгэлзүүлэх тухай дахин	2	7	5	3.5
24.	Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх тухай	0	2	2	-
25.	Тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх тухай	2	1	-1	-50.0

26.	Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэхийг сэргээх тухай	4	4	0	0.0
Нийт		8543	9103	560	6.6

**2.1.5.Хорих ял эдлэхээс хугацааны өмнө сулласан, ялаас чөлөөлсөн байдал**

Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.5, 37.6, 37.7, 37.8, 37.9, 37.10-т тус тус заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн нийт 2580 хүний материалыг хянан хэлэлцсэнээс 26 ялтныг өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлж, 1386 ялтныг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, хяналт тогтоон, 129 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулсан бол 21 ялтны хорих ялын дэглэмийг хүндрүүлж шийдвэрлэсэн байна.

*Хүснэгт №10. Хорих ял эдлэхээс хугацааны өмнө сулласан, ялаас чөлөөлсөн тухай мэдээллийг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт*

№		2019 он	2020 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.5, 37.6, 37.7, 37.8, 37.9, 37.10-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоо	2380	2580	200	8.4
2.	Өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлсөн	17	26	9	52.9
3.	Хорих ял эдлэхээс хугацааны өмнө сулласан	1302	1386	84	6.5
4.	Хорих ял эдлэхээс хугацааны өмнө үлдсэн хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай санал, дүгнэлтийг хэрэгсэхгүй болгосон хүний тоо	6	3	-3	-50.0
5.	Хорих ял эдлэх дэглэмийг нээлттэйгээс хаалттай дэглэм рүү шилжүүлсэн бүгд	38	21	-17	-44.7
6.	Хорих ял эдлэх дэглэмийг хаалттайгаас нээлттэй рүү шилжүүлсэн бүгд	174	129	-45	-25.9

2020 онд улсын хэмжээнд нийт 129 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулж, хаалттайгаас нээлттэй дэглэмд шилжүүлсэн нь өнгөрсөн 2019 оны дүнгээс 45 хүн буюу 25.9%-иар, хорих ял эдлэх дэглэмийг хүндрүүлж, нээлттэйгээс хаалттай дэглэмд шилжүүлсэн хүний тоо 17 хүнээр буюу 44.7%-иар тус тус буурсан байна.

**2.2.Давж заалдах шатны шүүх**

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд 2020 онд нийт 2936 хэрэг хүлээн авч, 2702 хэргийг хянан шийдвэрлэж, 169 хэргийн үлдэгдэлтэй, 14 хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах прокурорын дүгнэлтийг хүлээн авч, 65 хэрэгт давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гарсан байна.

Дээрхээс үзвэл, 2020 оны давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо 2019 оноос 416 хэргээр буюу 18.2%-иар, үлдэгдэл хэргийн тоо 65 хэргээр буюу 62.5%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 12. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг

№	Утга	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1.	Хянан шийдвэрлэсэн бүх хэрэг	2286	2702	416	18.2
2.	Тогтоолыг хэвээр үлдээсэн	948	1109	161	17.0
3.	Тогтоолд өөрчлөлт оруулсан бүгд	656	760	104	15.9
4.	Тогтоолыг хүчингүй болгосон бүгд	682	833	151	22.1
5.	Давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гаргасан	67	65	-2	-3.0
6.	Үлдэгдэл хэрэг	104	169	65	62.5
Тогтоолд өөрчлөлт оруулсан					
110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 үйл ажиллагааны салбарыг харвал нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах салбарын асуудлаар 64, бага, дунд боловсролын салбартай холбоотой 26, эрүүл мэндийн салбартай холбоотой 25, зам, тээвэр, төмөр замын салбартай холбоотой 17, цагдаагийн байгууллагатай холбоотой 17, газар зохион байгуулалт, газар олголттой холбоотой 16, гаалийн байгууллагатай холбоотой 13, барилгын салбартай холбоотой 12, сургуулийн өмнөх боловсролын салбартай холбоотой 12, цахилгаан, дулаан, ус хангамжтай холбоотой 12 гомдол, мэдээлэл тус тус хүлээн авсан байна.

### 3.Мөрдөн шалгах ажиллагаа

Авлигатай тэмцэх газар 2020 онд хуульд заасан харьяаллын 1535 үйлдэлтэй, 696 холбогдогчтой, 1331 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь өмнөх онтой харьцуулбал, 2.4%-иар өссөн байна.

Хүснэгт №4. Шалгасан хэрэг

Он	Хэргийн тоо	өссөн, буурсан хувь	Холбогдогчийн тоо	өссөн, буурсан хувь
2018	1138	-	1224	-
2019	1300	+14.2	481	-61
2020	1331	+2.4	696	+44.6

2020 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах хэрэг 799 буюу 52.1%, хахууль авах хэрэг 207 буюу 13.5%, хахууль өгөх хэрэг 108 буюу 7%, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах хэрэг 23 буюу 1.5%, үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэрэг 41 буюу 2.7%, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах хэрэг 21 буюу 1.4%, мөнгө угаах хэрэг 30 буюу 1.9%, эрүү шүүлт тулгах хэрэг 48 буюу 3.1%, бусад хэрэг 258 буюу 16.8%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт №5. Шалгасан хэрэг /төрлөөр/


д/д	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Тоо	Хувь
1	22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	799	52.1
2	22.4 дүгээр зүйл. Хахууль авах	207	13.5
3	22.5 дугаар зүйл. Хахууль авах	108	7
4	22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх	1	0.07
5	22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	23	1.5
6	22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	41	2.7
7	22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах	3	0.2
8	22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	21	1.4
9	18.6 дугаар зүйл. Мөнгө угаах	30	1.9
10	21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах	48	3.1
11	Бусад	50	3.7

12	Нийт	1331	100
----	------	------	-----

Хүснэгт №6. Авлигын гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээд (албан тушаалын байдлаар)

д/д	Албан тушаалын байдал	2018	2019	2020
1	Төрийн тусгай албан тушаалтан	434	101	116
2	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан	193	143	231
3	Улс төрийн албан тушаалтан	166	48	81
4	Төрийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтан	82	38	55
5	Төрийн үйлчилгээний албан тушаалтан	145	48	116
6	Төрийн захиргааны албан тушаалтан	204	103	97

График №2. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн албан тушаалын байдал



2020 онд 1331 хэргээс 236 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 17.7%-ийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 5.7%-иар өссөн байна.

Хүснэгт №7. Шалгасан хэргийн шийдвэрлэлт.

он	Шүүхэд шилжүүлэх саналтай	Хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай	Харьяаллын дагуу шилжүүлсэн	түдгэлзүүлсэн	Бусад хэрэгт нэгтгэсэн
2018	224	467	125	1	9
2019	156	556	80	1	22
2020	236	509	48	6	46

2020 онд Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах ажиллагаа явуулан шүүхэд шилжүүлсэн хэргээс 114 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад, 67.6%-иар өссөн байна.

Хүснэгт №8. Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Он	Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	өмнөх онтой харьцуулахад өссөн, буурсан хувь
2018	84	-
2019	68	- 20 хувь
2020	114	+ 67.6 хувь

2020 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 12.1 их наяд төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 35.6 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх 10.1 их наяд төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх онтой харьцуулбал гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 3.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт №9. Хохирол*

Он	Учирсан хохирол	Мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн	Битүүмжлэн хамгаалсан
2018	663.2 тэрбум	17.4 тэрбум	180.6 тэрбум
2019	12.1 их наяд	11.3 тэрбум	9.7 тэрбум
2020	12.1 их наяд	35.6 тэрбум	10.1 их наяд

**4. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил**

Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг нийгмийн салбар, бүлэг тус бүрээр ангилан авч үзэж, тухайн салбар, бүлгийн онцлогт тохирсон агуулга, хэлбэрээр зохион байгууллаа. Авлигын эсрэг сурталчилгааг видео болон радио контент, зурагт хуудас, нугалбар, подкаст, үзүүлэн таниулах хуудас, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн самбар, видео болон цахим хичээл, орон нутаг дахь сурталчилгаа, нийтийн тээвэр, сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэцийн, цахилгаан шатны сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлэг зэрэг хэд хэдэн төрөл хэлбэрээр бэлтгэн, түгээсэн. Тухайлбал, илтгэх ур чадварын нээлттэй тэмцээн, орон нутгийн төсвийн ил тод байдал хакатон, багачуудад зориулсан авлигаас ангид байх контент, хүүхдийн кино зохиолын уралдаан, авлигын эсрэг сурталчилгаанд урлаг, спортын төлөөллийг оролцуулж, “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяныг зохион байгуулж байна. Мөн “Шударга тоглоцгооё” бүжгийн челленж өрнүүлж, “Good Habits 20” буюу “Зөв дадал 20” дижитал чуулган, зөв зөвд шударга зөв соён гэгээрүүлэх аяныг тус тус зохион байгуулж, эрэн сурвалжлах сэтгүүлчдэд болон шинээр томилогдсон албан хаагчдад, маркетеруудад, дүүргийн хорооны албан хаагчид тус тус сургалт зохион байгуулсан.

**5. Монгол Улсын Авлигын индекс**

Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагаас жил бүр боловсруулдаг Авлигын төсөөллийн индексийн дүнгээр Монгол Улс 2020 онд 35 оноо авч 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад, таван байраар ухарсан үзүүлэлт болж байна.<sup>1</sup>

*Хүснэгт №10. Авлигын талаарх судалгаа хийдэг байгууллагуудын Монгол Улс дахь авлигын индекс төгсөн үнэлгээ*

д/д	Байгууллага-судалгаа	2018	2019	2020
1	Пи Ар Эс групп – Эрсдэлийн үнэлгээ 2020	32	35	41
2	Ай Эм Ди – Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл, Үзэл бодлын судалгаа 2020	30	28	32
3	Ардчилалын олон талт байдлын төсөл 2020	33	31	34
4	Дэлхийн эдийн засгийн форум – Үзэл бодлын судалгаа 2019	31	28	28
5	Бертелсман сан – Шилжилтийн индекс 2020	41	37	37

<sup>1</sup> Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020. Улаанбаатар хот, 2021 он. 63 дахь тал.

6	Дэлхийн банк – Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2019	43	35	35
7	Эдийн засгийн мэдээллийн нэгж – Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2020	37	37	37
8	Дэлхийн эрх зүйн төсөл – Хууль дээдлэх ёсны индекс 2019	36	36	33
9	Глобал инсайт байгууллага – Улс орнуудын эрсдэлийн түвшин 2019	47	47	35
Дундаж оноо		37	35	35

2020 оны авлигын хэмжүүр судалгаанд хамрагдсан Монгол Улсын иргэдийн 22% нь сүүлийн 12 сард хахууль өгсөн хэмээн хариулжээ.

*Хүснэгт №11. Судалгаанд хамрагдсан иргэдийн хахууль өгсөн төрийн байгууллага*

д/д	Төрийн үйлчилгээ	Хувь
1	Улсын сургууль	27
2	Улсын эмнэлэг, эрүүл мэндийн төв	17
3	Дэд бүтэц	10
4	Цагдаагийн байгууллага	9

Монгол Улсыг төлөөлөн судалгаанд хамрагдсан иргэдээс авлигад хамгийн их автсан гэж хариулсан төрийн байгууллага, албан хаагчдийг харуулав.

*Хүснэгт №12. Авлигад хамгийн их автсан төрийн байгууллага*

д/д	Төрийн байгууллага, албан хаагч	Хувь
1	Парламентын гишүүн	56
2	Шүүгч	42
3	Төрийн бусад албан хаагч	30
4	Орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагч	29
5	Цагдаа	27

## 6. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Авлигад нөлөөлж байгаа хүчин зүйлс, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн албаны тогтвортой байдал, иргэдийн орлого, шүүхийн хараат бус байдал, сонгууль, улс төрийн намын санхүүжилтэд дүн шинжилгээ хийв.

УИХ-д авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн авлигын эсрэг дагнасан шүүх байгуулах, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, УИХ-ын гишүүдийн тангарагт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг тусгах, авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх, иргэд, олон нийтийн анхаарал татсан зарим хэргүүдийг тодорхой хэмжээгээр мэдээлдэг байх, мэдээлэгчийг хамгаалах, олон нийтийн зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох, шүүгчийн сонгон шалгаруулалтыг ил тод болгох, Авлигатай тэмцэх газрын салбар, нэгжийг орон нутагт байгуулах, хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх санал хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, УИХ-ын даргын өгсөн чиглэлийн дагуу Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч/илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, даган гарах хуулиуд болох Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулж, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газраас санал авч, тусган Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын

тогтолцоог бий болгож, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батлахаар тусгасан ба Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэв.

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх” -өөр заасан.

Салбар зөвлөлүүд авлигын эсрэг аян зохион байгуулах, сургалт хийх, сурталчилгааны материал түгээх, иргэний нийгмийн байгууллагууд, орон нутгийн өмчит компаниудын дунд зөвлөгөөн зохион байгуулах, зөвлөмж хүргүүлэх, судалгаа авч дүн шинжилгээ хийх, хууль хяналтын байгууллагууд “Санамж бичиг” байгуулан төр, нийтийн эрх ашиг зөрчигдсөн, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, гэмт хэргийн болон захиргааны зөрчлийн шинжтэй санхүүгийн зөрчлийн талаар мэдээлэл солилцох, хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.





## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

## ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭ – FORENSIC

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2. ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ

ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ

ТУСГАЙ ШИНЖИЛГЭЭ

3. ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН  
БАЙДАЛ



## ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

### 1.Товч танилцуулга

Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төрийн эрх бүхий байгууллага /цагдаа, шүүх, прокурор, тагнуул, гааль, татвар/, албан тушаалтны тогтоол, захирамжаар тусгай мэдлэг шаардсан асуудлыг шийдвэрлэхийн тулд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, гэмт хэрэг илрүүлэх, гэмт этгээдийн үйлдлийг шинжлэх ухааны үндэслэлтэй нотлон тогтооход мэргэжилтнээр хэргийн газрын үзлэгт оролцож, ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, магадлагаа гаргах үндсэн чиг үүрэгтэй мэргэжлийн байгууллага юм.


Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Шүүхийн шинжилгээний тухай хуулийг баталснаар шүүхийн шинжилгээ хийх үндэслэл, журам, зарим төрлийн шинжилгээний онцлог болон шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, шинжээчийн эрх зүйн байдлыг тогтоон өгчээ.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь одоогийн тогтолцоогоор шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэж, криминалистикийн, шүүх эмнэлгийн болон тусгай шинжилгээ, эдийн засгийн шинжилгээний чиглэлээр шинжилгээ хийхийн зэрэгцээ гарын хээний сан, галт зэвсгийн хонгио, хошууны сан, хариуцах эзэнгүй хэн болох нь тогтоогдохгүй цогцосны сан, Генетик мэдээллийн нэгдсэн сан /ДНХ/ болон бусад төрлийн санг бүрдүүлэн лавлагаа мэдээллийн үйл ажиллагаа явуулж байна.

Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба нь тухайн орон нутагт гарсан хэргийн газрын үзлэгт оролцож ул мөр эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх үйл ажиллагаанд мэргэжилтнээр оролцох, орон нутагт ажиллаж буй шинжээчдийн тусгай мэдлэгийн хүрээнд шүүх эмнэлэг, криминалистикийн шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь нийт 13 лабораторитой эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийдэг.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



**Гарын мөрийн шинжилгээний лаборатори.** Тус лабораторид 1995 онд “Папилон-5” системийг суурилуулж, хэргийн газраас илрүүлж бэхжүүлсэн гарын мөрүүдийг гарын дардасуудтай автомат харьцуулалт хийж эхэлсэн ба 1999 онд Засгийн газраас “Гарын хээний нэгдсэн сан” байгуулах шийдвэр гарч, ОХУ-ын мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулан “Папилон-7 АДИС” шинэ системийг нэвтрүүлсэн.

Өнөөдрийн байдлаар гарын мөрийн шинжилгээний лабораторид 2008 онд “Папилон-7.7.4” системийг суурилуулсан бөгөөд аймаг, нийслэлийн шинжилгээний байгууллагад 2012 оноос нэгдсэн систем байдлаар ашиглаж байна.

**Мөр судлалын шинжилгээний лаборатори.** Мөр судлалын шинжилгээнд дараах техник хэрэгслийг ашиглаж байна:

д/д	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгдсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	AmScope	Хятад	2010, 2013	2010, 2013	Өсгөгч
2	XTL	Хятад	2006	2006	Өсгөгч
3	XZB	Хятад	2007	2007	Дижитал камертай өсгөгч

**Бичиг баримтын шинжилгээний лаборатори.** Бичиг баримт болон гар бичмэл, тамга тэмдэгт дараах техник хэрэгслийг ашиглаж шинжилгээ хийж байна:

д/д	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгдсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	AmScope суурин болон зөөврийн	Хятад	2010, 2013	2010, 2013	Өсгөгч
2	“ProjectinaDocucenter Expert”-PIA6000	Хятад	2008	2008	Тусгай төхөөрөмж
3	Nikon SM2800	Хятад	2007	2007	Өсгөгч

**Галт зэвсгийн шинжилгээний лаборатори.** Тус лаборатори нь мөн 1998 оноос эхлэн лабораторийн системд орсон бөгөөд 2001 онд УИХ-аас баталсан “Галт зэвсгийн тухай хууль”-д заасны дагуу Улсын галт зэвсгийн хонгио, хошууны нэгдсэн санг байгуулан, автомат харьцуулалтын “CCS-1.0” системийг суурилуулан галт зэвсгийн бүртгэл, хонгионы мөрийг сан хэлбэрээр бүртгэж, бүх төрлийн галт зэвсэг, сум хэрэгсэл, буудлагын мөр, тэсэрч, дэлбэрэх бодисын шинжилгээг хийж байна. Уг шинжилгээнүүдийг дараах техник хэрэгсэл ашиглан хийж байна:

д/д	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгдсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Арсенал	ОХУ	2008	2008	Автомат систем
2	Motic SMZ-140	Хятад	2006	2007	Өсгөгч

**Авто техникийн шинжилгээний лаборатори.** Тус лаборатори нь зам тээврийн ослын хэргийн газрын нөхцөл байдлын шинжилгээ, автотехникийн эвдрэл гэмтлийг тогтоох шинжилгээ, автотехникийн мөр судлалын шинжилгээг тус тус хийдэг бөгөөд дараах техник хэрэгслийг ашиглаж байна:

д/д	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгдсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Launch	Хятад	2013	2013	Тэнхлэг тохирогооны багаж
2	Launch	Хятад	2013	2013	Дугуй задалж угсрах төхөөрөмж
3	Fox well GT30 mini	Хятад	2015	2015	Цахилгааны гэмтэл оношлох багаж
4	Bow monk series-2	Англи	2014	2014	Тормосын идэвхижилт хазайлт хэмжигч

**Гэрэл зураг, дүр зураг-дүрс бичлэгийн шинжилгээний лаборатори.** Гэрэл зураг, гавлын ясаар хүнийг адилтгахаас гадна хохирогч, гэрчийн тодорхойлсон, мэдүүлсний дагуу сэжигтний ам зураг гаргах компьютерийн “Mon face” харьцуулах систем суурилуулан ажиллаж байна. Гэрэл зургийн лаборатори нь шинжилгээний болон хэргийн газрын үзлэгийн гэрэл зургийн ажил гүйцэтгэдэг. Өнөөдрийн байдлаар тус лабораторид 2016 онд Япон улсад үйлдвэрлэсэн гэрэл зургийг чанарын өндөр түвшинд боловсруулах “Fujifilm Frontier LP7700” маркийн шинэ дэвшилтэт тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаагийн зэрэгцээ дүр зураг, дүрс бичлэг, дуу авианы шинжилгээнд дуу авиа, дүрс бичлэг, компьютер техникийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ОХУ, АНУ болон Европын зарим улс орны программ хангамжийг хэрэглэдэг.

**Химийн шинжилгээний лаборатори.** Уг лабораторид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис шинжлэх “Хийн хроматограф”-ын аппаратыг, хүний биеийн биоматериалд буюу цус, шээс, үс, хумсанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тодорхойлох 3 төрлийн “6530 QTOF шингэний хроматограф-масс спектрометр, 1290 HPLC өндөр мэдрэмжит шингэний хроматограф, 5977 загварын хийн хроматограф масс спектрометрийн аппарат суурилуулан үйл ажиллагаандаа ашигладаг.

д/д	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгдсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	HBS-Q-TOF-LC/MS-650	АНУ	2017	2018	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох
2	7820AGC-5977B MSD	АНУ	2017	2018	
3	ELISA RT-2100C	Хятад	2019	2019	
4	UNICO7200	Хятад	2008	2008	Спиртийн зүйл тодорхойлох

**Биологийн шинжилгээний лаборатори.** Тус лаборатори нь 1976 онд ЦЕГ-ын Шинжилгээний хүрээлэнд БНАГУ-ын тоног төхөөрөмж, техникийн тусламжтайгаар байгуулагдсан бөгөөд дараах техник хэрэгслийг ашиглан биологийн шинжилгээг хийж байна.

д/д	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгдсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Nikon-ECLIPSE E200	Хятад	2018	2018	Өсгөгч
2	Micros MC-50	Австри			Өсгөгч
3	Biobase	Хятад			Дээж бэлтгэгч сэгсрэгч

**Физикийн шинжилгээний лаборатори:** 1974 онд тус лаборатори нь УЦСЕГ-ын Шинжлэх ухаан, техникийн хэлтэст БНАГУ-ын тоног төхөөрөмж, техникийн тусламжтайгаар байгуулагдсан.

д/д	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгдсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Himedia Prima-96	Энэтхэг	2019	2019	PCR машин
2	PCRsystem 9700	АНУ	2012	2012	Тусгай төхөөрөмж
3	Genetic Analyzer 3130	АНУ	2012	2012	Тусгай төхөөрөмж
4	Thermostat JISICO J-100S	Солонгос	2001	2001	Тусгай төхөөрөмж
5	HANIL HM-150-IV	Солонгос	2001	2001	Центрфуг

**Бактериологийн шинжилгээний лаборатори:** Тусгай шинжилгээний лабораторид хандах бактериологийн шинжилгээний тоо, объектын тоо жил ирэх тусам ихсэж байгаагаас хамаарч тус лабораторийг биологийн шинжилгээний лабораториос тусад нь байгуулан ажиллуулж байна. Уг лабораторид хохирогч болон сэжигтнээс цус, шээс, мазокын



шинжилгээний дээж авч сүүлийн үеийн мэдрэг оношлуур тест, микроскоп, PCR-ын аргуудыг ашиглан бэлгийн замын халдварт өвчин үүсгэгчийг илрүүлэх бактериологийн шинжилгээ хийдэг.

д/д	Техник хэрэгслийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгдсэн он	Ашиглаж эхэлсэн он	Тайлбар
1	Elisa reader ADX-110	АНУ	2018	2018	Тусгай төхөөрөмж
2	CYAN CL002	Белги	2019	2019	Тусгай төхөөрөмж
3	Thermostatic DH4000AB	Хятад	2007	2007	Тусгай төхөөрөмж
4	Thermostatic DH5000-II	Хятад	2011	2014	Тусгай төхөөрөмж
5	CYAN CL007N	Белги	2019	2019	Тусгай төхөөрөмж

## 2. Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллага 2020 онд нийт 64369 шинжилгээ хийсэн бөгөөд 57.4%-ийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 25.5%-ийг тусгай шинжилгээ, 16.6%-ийг криминалистикийн шинжилгээ, 0.5%-ийг эдийн засгийн шинжилгээ эзэлсэн нь өмнөх оноос 7.6%-иар буурсан байна.

График №1 2020 онд хийгдсэн нийт шинжилгээний тоо (шинжилгээний төрлөөр)



Хүснэгт №1. Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээ (сүүлийн 5 жилээр)

Шинжилгээний чиглэл, төрөл		2016	2017	2018	2019	2020
Криминалист икийн шинжилгээ	Гарын мөр	10319	9541	9550	7499	6660
	Мөр судлал	2012	1545	1553	1740	1556
	Бичиг судлал, бичиг техник	1207	1066	906	1147	915
	Дүр зураг	133	98	72	53	37
	Галт зэвсэг	249	222	604	937	877
	Тэсрэх төхөөрөмж	7	7	2	6	13
	Дүрс бичлэг	229	265	251	237	244
	Автотехник	218	235	165	164	215
	Компьютер судлал	132	131	111	85	119
	Дуу авиа	-	-	28	24	23
	Материал судлал	-	-	32	52	5
Бусад	116	92	19	17	29	

	<b>Бүгд</b>	<b>14622</b>	<b>13202</b>	<b>13293</b>	<b>11961</b>	<b>10693</b>
Тусгай шинжилгээ	Хими	5348	5894	6814	7524	6976
	Физик	179	170	210	238	249
	Биологи	5734	5679	6056	6560	6125
	ДНХ	1070	1265	1685	2046	2030
	Бактерлоги	893	994	1049	989	1062
	<b>Бүгд</b>	<b>13224</b>	<b>14002</b>	<b>15814</b>	<b>17357</b>	<b>16442</b>
Шүүх эмнэлгийн шинжилгээ	Цогцосны задлан шинжилгээ	3685	4016	4492	4659	4455
	Гэмтлийн зэрэг тогтоох	30168	27934	27493	27138	25919
	Хэргийн материалаар хийх	1716	1409	1430	1649	1504
	Хүний биед хийсэн бусад шинжилгээ / нас тогтоох/	1209	1220	1425	1575	1734
	Шарилд хийсэн шинжилгээ	24	19	26	24	17
	Гистологийн шинжилгээ	3621	3492	4913	5110	3345
	<b>Бүгд</b>	<b>40423</b>	<b>38090</b>	<b>39779</b>	<b>40155</b>	<b>36974</b>
Шүүх эдийн засгийн шинжилгээ	Татвартай холбоотой	11	18	20	9	11
	НД-ын шимтгэлтэй холбоотой	21	24	21	3	14
	Бэлэн мөнгөтэй холбоотой	70	48	53	64	75
	Эд хогшил, бараа	57	46	36	46	46
	Бусад зөрчил	5	95	13	30	20
	Буцсан	-	-	90	85	0
	<b>Бүгд</b>	<b>256</b>	<b>231</b>	<b>233</b>	<b>237</b>	<b>260</b>
<b>Нийт</b>	<b>68525</b>	<b>65525</b>	<b>69119</b>	<b>69710</b>	<b>64369</b>	

График №2. Шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээ (сүүлийн 5 жилээр)





График №3. Шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 5 жилээр)





Хүснэгт №2. 2020 онд хийсэн шүүхийн шинжилгээ (аймаг, шинжилгээний төрлөөр)

№	Шинжилгээний газар, хэлтэс, алба	Нийт шинжилгээ	Шүүх эмнэлгийн шинжилгээ	Криминалистикийн шинжилгээ	Тусгай шинжилгээ	Эдийн засгийн шинжилгээ
1	Архангай	1144	762	55	327	-
2	Баян-Өлгий	746	583	53	110	-
3	Баянхонгор	870	770	100	-	-
4	Булган	633	427	59	147	-
5	Говь-Алтай	658	473	45	140	-
6	Говьсүмбэр	407	398	9	-	-
7	Дархан-Уул	1700	1374	95	231	-
8	Дорноговь	705	599	106	-	-
9	Дорнод	1633	1204	175	254	-
10	Дундговь	423	358	65	-	-
11	Завхан	658	442	59	157	-
12	Орхон	1847	1334	257	256	-
13	Өвөрхангай	741	631	110	-	-
14	Өмнөговь	814	798	16	-	-
15	Сүхбаатар	903	699	71	133	-
16	Сэлэнгэ	1053	739	157	157	-
17	Төв	1402	1224	178	-	-
18	Увс	1151	890	101	160	-
19	Ховд	1374	1079	89	206	-
20	Хөвсгөл	1018	766	129	123	-
21	Хэнтий	1237	1031	170	36	-
22	Хүрээлэн	37976	19028	4683	14005	260
23	НШШГазар	5276	1365	3911	-	-
<b>Бүгд</b>		<b>64369</b>	<b>36974</b>	<b>10693</b>	<b>16442</b>	<b>260</b>

### 2.1.Криминалистикийн шинжилгээ


Шүүхийн шинжилгээний байгууллага 2020 онд криминалистикийн 10693 шинжилгээ хийсэн бөгөөд 43.8%-ийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газарт, 36.5%-ийг Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын криминалистикийн лабораторид, 19.6%-ийг аймгуудын шүүхийн шинжилгээний албаны лабораторид хийжээ.

Хүснэгт №3. 2020 оны криминалистикийн шинжилгээ (шинжилгээний төрөл, аймаар)

№	Аймаг	Нийт шинжилгээ	Шинжилгээний төрөл											
			Гарын мөр	Мөр судлал	Баримт бичиг	Галт зэвсэг	Тэсрэх төхөөрөмж	Дүр зураг	Дүрс бичлэг	Автотехник	Компьютер	Дуу авиа	Материал	Бусад
1	Архангай	55	36	8	10	1	-	-	-	-	-	-	-	-
2	Баян-Өлгий	53	19	22	12	-	-	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	100	47	38	12	3	-	-	-	-	-	-	-	-
4	Булган	59	48	7	4	-	-	-	-	-	-	-	-	-
5	Говь-Алтай	45	23	20	1	1	-	-	-	-	-	-	-	-
6	Говьсүмбэр	9	2	5	2	-	-	-	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул	95	48	31	16	-	-	-	-	-	-	-	-	-
8	Дорноговь	106	77	19	6	4	-	-	-	-	-	-	-	-
9	Дорнод	175	152	21	1	1	-	-	-	-	-	-	-	-
10	Дундговь	65	62	3	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Завхан	69	33	20	6	-	-	-	-	-	-	-	-	-
12	Орхон	257	169	59	28	1	-	-	-	-	-	-	-	-

13	Өвөрхангай	110	53	47	7	2									1
14	Өмнөговь	16	12	4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
15	Сүхбаатар	71	20	50	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
16	Сэлэнгэ	157	119	25	12	-		1							
17	Төв	178	148	24	6	-	-	-	-	-	-	-	-	-	-
18	Увс	101	33	30	36	2	-	-	-	-	-	-	-	-	-
19	Ховд	89	56	21	11	-									1
20	Хөвсгөл	129	73	36	11	9	-	-	-	-	-	-	-	-	-
21	Хэнтий	170	137	26	5	2	-	-	-	-	-	-	-	-	-
22	Хүрээлэн	3911	3891	8	12	-	-	-	-	-	-	-	-	-	-
23	НШШГазар	4683	1402	1032	716	851	13	36	244	215	119	23	5	27	
<b>Бүгд</b>		<b>10693</b>	<b>6660</b>	<b>1556</b>	<b>915</b>	<b>877</b>	<b>13</b>	<b>37</b>	<b>244</b>	<b>215</b>	<b>119</b>	<b>23</b>	<b>5</b>	<b>29</b>	

График №4. Криминалистикийн шинжилгээ



## 2.2. Шүүх эмнэлгийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2020 онд шүүх эмнэлгийн **36974** шинжилгээ хийсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 7.9 хувиар буурсан байна. Эдгээрийн 74.8% нь хүний биед, 21% нь цогцост /үүний 9 хувь нь эд, эсийн шинжилгээ/, 4 хувь нь хэргийн материалаар хийсэн шинжилгээ эзэлж байна. Нийт шинжилгээний 51.5%-ийг ШШҮХ-ийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт, 3.7%-ийг Нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт, 44.9%-ийг аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийжээ.

Хүснэгт №4. Шүүх эмнэлгийн шинжилгээ

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцост хийх шинжилгээ	4455
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	25919
Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	1734
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1504
Эксгумац	17
Гистологийн шинжилгээ	3345
<b>НИЙТ</b>	<b>36974</b>

Хүснэгт №5. Шүүх эмнэлгийн шинжилгээ /шинжилгээний төрөл, аймгаар/

№	Шинжилгээний алба	Нийт шинжилгээ	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	Хүний биед хийсэн бусад шинжилгээ	Цогцост хийсэн шинжилгээ	эксгумац	Хэргийн материалаар хийсэн шинжилгээний	Гистологи
1	Архангай	762	616	13	133	-	-	-
2	Баян-Өлгий	583	506	28	46	3	-	-

3	Баянхонгор	770	573	88	108	-	1	-
4	Булган	427	320	37	70	-	-	-
5	Говь-Алтай	473	390	24	57	-	2	-
6	Говьсүмбэр	398	356	6	36	-	-	-
7	Дархан-Уул	1374	897	43	94	-	7	333
8	Дорноговь	599	470	30	99	-	-	-
9	Дорнод	1204	841	44	153	-	13	153
10	Дундговь	358	245	16	69	-	28	-
11	Завхан	442	351	9	61	-	-	21
12	Орхон	1334	764	61	91	-	5	413
13	Өвөрхангай	631	499	22	110	-	-	-
14	Өмнөговь	798	616	39	127	-	10	6
15	Сүхбаатар	699	582	42	75	-	-	-
16	Сэлэнгэ	739	550	32	157	-	-	-
17	Төв	1224	825	12	187	-	33	167
18	Увс	890	720	21	61	1	13	74
19	Ховд	1079	886	24	74	1	21	73
20	Хөвсгөл	766	543	44	179	-	-	-
21	Хэнтий	1031	837	27	129	-	18	20
22	ШЭШГ	19028	12322	1041	2224	11	1345	2085
23	НШШГ	1365	1210	31	115	1	8	-
24	Бүгд	<b>36974</b>	<b>25919</b>	<b>1734</b>	<b>4455</b>	<b>17</b>	<b>1504</b>	<b>3345</b>

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд сүүлийн 6 жилд хийсэн нийт шинжилгээний 59%-ийг шүүх эмнэлгийн шинжилгээ эзэлж байна.

Хүснэгт №6. Нийт шинжилгээ

Он	Нийт хийсэн шинжилгээ	Шүүх эмнэлгийн шинжилгээ	Эзлэх хувь
2015	68237	41411	61,1%
2016	68525	40423	59%
2017	65525	38090	58,1%
2018	68424	39084	57,1%
2019	69710	40155	57,6 %
2020	64369	36974	57,4%


2020 онд хийгдсэн шүүх эмнэлгийн шинжилгээний тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал:

- хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 4.4% бууралттай;
- бэлгийн маргаантай асуудалд болон нас тогтоох шинжилгээ 10% өсөлттэй;
- шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ 5.1% бууралттай;
- хэргийн материалаар хийсэн шинжилгээ 8.7% бууралттай;
- шарилд хийсэн шинжилгээ 29% бууралттай байна.

### 2.3.Эдийн засгийн шинжилгээ

2020 онд эдийн засгийн 260 шинжилгээ хийснээс 166-д нь шинжээчийн дүгнэлт гаргасан, 84-д нь шинжээч томилох эрх бүхий этгээдийн хүсэлтээр, санхүүгийн баримт ирүүлээгүй, эрх бүхий байгууллагын акт дүгнэлт гараагүй зэрэг шалтгаанаар буцаажээ. Шинжилгээгээр 3,199,934,464.2 мянган төгрөгийн, 3,575,993.4 ам долларын зөрчил, хохирол тогтоосон байна.


График №5. Эдийн засгийн шинжилгээ.



### 2.4.Тусгай шинжилгээ

2020 онд тусгай шинжилгээний чиглэлээр нийт 16442 шинжилгээ хийснийг өмнөх онтой харьцуулахад 5.2%-аар буурсан байна. Тусгай шинжилгээний чиглэлээр хийсэн нийт шинжилгээний 42%-ийг химийн шинжилгээ, 37%-ийг биологийн шинжилгээ, 12%-ийг ДНХ-ийн шинжилгээ, 6.4%-ийг бактериологийн шинжилгээ, 1.5%-ийг физикийн шинжилгээ эзэлж байна.

График № 6. Хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ /тоогоор/



Хүснэгт №7. Тусгай шинжилгээ (шинжилгээний төрөл, аймгаар)

№	Аймаг	Нийт шинжилгээ	Шинжилгээний төрөл				
			Хими	Физик	Биологи	ДНХ	Бактериологи
1	Архангай	327	185		136		6
2	Баян-Өлгий	110	110				
3	Баянхонгор	-					
4	Булган	147	147				
5	Говь-Алтай	140	94		46		
6	Говьсүмбэр	-					
7	Дархан-Уул	231	122		109		
8	Дорноговь						
9	Дорнод	254	199		55		
10	Дундговь						

11	Завхан	157	148		9		
12	Орхон	256	191		65		
13	Өвөрхангай						
14	Өмнөговь						
15	Сүхбаатар	133	133				
16	Сэлэнгэ	157	115		42		
17	Төв						
18	Увс	160	90		70		
19	Ховд	206	154		52		
20	Хөвсгөл	123	123				
21	Хэнтий	36	26		7	3	
22	ТШГ	14005	5139	249	5534	2027	1056
<b>Бүгд</b>		<b>16442</b>	<b>6976</b>	<b>249</b>	<b>6125</b>	<b>2030</b>	<b>1062</b>

### 3.Хэргийн газрын үзлэгт оролцсон байдал

Криминалистикийн шинжээчид 27539 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бол, шинжээч эмч нар 4468 хэргийн газрын үзлэгт оролцсон байна. Шинжээчдийн оролцсон хэргийн газрын үзлэгийн 17.3% нь хүнийг алах гэмт хэрэг, 31% нь хулгайлах гэмт хэрэг, 18% нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 1% нь дээрэмдэх гэмт хэрэг, 32% нь бусад хэрэг байна.

2020 онд 27539 хэргийн газрын үзлэгт оролцож, биет нотлох баримт илрүүлж, бэхжүүлсэн. Үүнээс ШШҮХ-ийн Криминалистикийн шинжилгээний газрын шинжээч 83 удаа, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын криминалистикийн шинжээч 19541 удаа, аймгуудын шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн шинжээч 7915 удаа хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцжээ.



# ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ (2020)

НИЙТ ХОХИРОГЧ

**23050** -25.1%

НИЙСЛЭЛД **14464** -26.3%

ОРОН НУТАГТ **8586** -22.7%



59.1%

**13629**

-22.4%

ЭРЭГТЭЙ

ЭМЭГТЭЙ

НАС

70+

65-69

60-64 - 3867

55-59

50-54

45-49

7937 -

40-44

35-39

30-34

25-29 - 10065

18-24

1181 -

-17

40.9%



**9421**

-28.7%

ХОХИРСОН  
ХУУЛИЙН ЭТГЭЭД

**66** -22.4%



НАС БАРСАН

**670** -28.0%



ГЭМТСЭН

**8175** -6.3%

УЧИРСАН ХОХИРОЛ



**254.9** +57.0%  
ТЭРБУМ

НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН

**82.0** +87.6%  
ТЭРБУМ

ХУВЬ



**32.1%** +5.1%



## ДОЛООДУГААР БҮЛЭГ

## ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIME VICTIM

1. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ, ТҮҮНИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
2. ЦАГДААГИЙН СТАТИСТИК
3. ПРОКУРОРЫН СТАТИСТИК
4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ДҮН МЭДЭЭ



## ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ

### 1. Гэмт хэргийн хохирол, түүнийг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт

НҮБ-аас баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Монгол Улсын Үндсэн хууль” болон бусад хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хуулиар хүлээсэн байдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал” (Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power) баталсан нь дэлхийн улсуудад өөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогч судлалын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн гол үндэслэл болсон байна<sup>1</sup>.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заасан бөгөөд бусдын хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалтуудаар зохицуулсан байдаг. Үндэсний хууль тогтоомжуудад хохирогчийн эрхийн байдлыг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”,

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэж тодорхойлоод мөн хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.9 дэх хэсэгт “гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах” эрхтэй<sup>2</sup>,

3. Мөн хуулийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ”, 8.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ”,

4. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй” гэж тус тус хуульчилсан<sup>3</sup>.

5. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.8-т “Төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогын баримт бичгийг баталж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй дээрх эрх зүйн актуудаар нэр төр, алдар

<sup>1</sup> <https://legal.un.org/avl/ha/dbpjvcap/dbpjvcap.html>

<sup>2</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017. №23.

<sup>3</sup> Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002. №8.

хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээдийг хохирогч, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэж тодорхойлсон нь үндсэндээ эд хөрөнгийн хохирлоос гадна эд хөрөнгийн бус хохирол нөхөн төлүүлэх эрхийг бататган хуульчилсан бөгөөд ийнхүү гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг бататгасан нь эрх зүйн орчин бүрдсэн.

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх учиртай.

Гэмт хэрэг бол өөрөө нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд улс орны эдийн засаг доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, үнэ, инфляци өсөхийн хирээр гэмт хэргийн гаралт ч бас нэмэгдэж байдаг зүй тогтолтой. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг өсөхийн хирээр гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн тоо ч нэмэгдсээр байна.

Монгол Улсын хувьд, “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-г бүрдүүлэхийг хуульчилсан байна<sup>4</sup>. Монгол Улсын Их Хурлаас “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийг 2006 оны 06 дугаар сарын 29-ний өдөр батлан, 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр шинэчлэн найруулсан байдаг.


Гэхдээ уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл (Хүнийг алах), 11.1 дүгээр зүйл (Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах), 11.4 дүгээр зүйл (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах), 12.1 дүгээр зүйл (Хүчиндэх), 12.3 дугаар зүйл (Бэлгийн мөлжлөг), 13.1 дүгээр зүйл (Хүн худалдаалах), 13.2 дугаар зүйл (Хүн хулгайлах), 13.3 дугаар зүйл (Хүн барьцаалах), 13.4 дүгээр зүйл (Хүнийг хүчээр алга болгох), 15.3 дугаар зүйл (Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах), 15.5 дугаар зүйл (Хууль бусаар үр хөндөх), 16.1 дүгээр зүйл (Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах), 16.3 дугаар зүйл (Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх), 16.6 дугаар зүйл (Хүүхэд худалдах), 16.7 дугаар зүйл (Хүүхэдтэй хэрцгий харьцах), 16.11 дүгээр зүйл (Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх), 17.2 дугаар зүйл (Дээрэмдэх), 19.3 дугаар зүйл (Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах), 21.12 дугаар зүйл (Эрүү шүүлт тулгах), 29.1 дүгээр зүйл (Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх), 29.8 дугаар зүйл (Террорист үйлдэл хийх)-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна” гэж ялгамжтай байхаар хуульчилжээ. Дээрх хуулийн заалтуудыг судалж үзвэл, хүний амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэж үйлдсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгож байхаар хуульчилсан ч процессийн нарийн зохицуулалт тодорхой бус байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах гол үзэл баримтлал болохыг дээр дурьдсан. Үүнд гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд шууд учирсан хохирлыг хамааруулан ойлгох шаардлагатай.

<sup>4</sup> “Засгийн газрын нөөц сангийн тухай хууль” шинэчилсэн найруулга, 2019 <https://www.legalinfo.mn/law/details/14848?lawid=14848>




График № 1. Улсын хэмжээнд тухайн жилд бүртгэгдсэн гэмт хэргийн дүн



Мөн онуудад бүртгэгдсэн болон шүүхээр таслан шийдвэрлэгдсэн хэргийн тоонд хамаарах улсад болон хувийн өмч буюу иргэнд учирсан хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлснийг харьцуулан үзэх шаардлагатай.

2018 оны байдлаар улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас 198.073.2 сая төгрөгийн хохирол учирсан бол 2019 онд гэмт хэргийн улмаас 162.346.6 сая төгрөг, 2020 онд 254.937.3 сая төгрөгийн хохирол учирсан байна.

График №2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын дүн хэмжих нэгж /сая.төг/




Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд 2018 онд 169.965 сая төгрөг, 2019 онд 155.067.7 сая төгрөг, 2020 онд 246,004.7 сая төгрөгийн

хохирол учирсан тухай статистик мэдээ бий<sup>5</sup>.

Эдгээр нь улсын хэмжээнд учирсан хохирлын дийлэнх хувийг эзэлж байгаа ба гэмт хэргийн улмаас иргэд олон зуун тэрбум төгрөгийн хохирол хүлээж байгаад төр анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор тулгарсныг харуулж байна.

График №3. Гэмт хэргийн улмаас нийт хохирсон иргэний тоо



Сүүлийн 3 жилийн байдлаар гэмт хэргийн хохирол буурч буй нь эерэг хэдий ч төр чиг үүргийнхээ хүрээнд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг барагдуулах явдал төдийлөн хангалтгүй байна.

## 2.Цагдаагийн статистик

Монгол Улсын хэмжээнд 2020 онд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 670 хүн нас барсан бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүний тоо 260 буюу 28%-иар буурсан дүнтэй байна.

Хүснэгт №1. Гэмт хэргийн улмаас нас барсан хохирогч

Бус	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Нас барсан хүн		Үүнээс: Гэмт хэргийн төрлөөр													
				10.1 /91/		10.2, 10.3, 10.5 /92-93/		10.4 /95/		10.6 /94/		27.1-27.11 /215-225/		Үүнээс		бусад	
				2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16		
Баруун бус	Баян-Өлгий	11	15	3	5					1	1	6	6	6	6	1	3
	Говь-Алтай	7	6	2	2			4	1				2		2	1	1
	Завхан	13	23	3	1			1	2	1	2	6	17	6	17	2	1
	Үүнээс: Тосонцэнгэл	9	13	1				1	1	1		6	12	6	12		
	Увс	12	5	4				1	1	1		6	4	6	4		
	Ховд	15	14		2			5			1	10	11	10	11		
	Үүнээс: Булган	4						1				3		3			
Хангайн бус	Архангай	27	22	5	6		1	4	2			17	12	17	12	1	1
	Баянхонгор	28	14	7	2			6	2	3	2	12	8	12	8		

<sup>5</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 1212.mn

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2020

	Булган	26	16	4	5			8	6			14	5	14	5		
	Орхон	27	9	3	3			14	2	4	1	6	2	6	2		1
	Өвөрхангай	21	16	3	4			6	1	1	1	9	9	9	9	2	1
	Үүнээс: Хархорин	2	4		1							2	3	2	3		
	Хөвсгөл	36	21	8	4			6		5	4	17	10	17	10		3
Төвийн бүс	Говьсүмбэр	6	7	1	2			2		1	3	2	2	2	2		
	Дархан-Уул	25	11	7	2	2	1	7	2	1	2	7	3	7	3	1	1
	Дорноговь	24	10	3	5			6		1	1	13	4	13	4	1	
	Үүнээс: Замын-Үүд	5	6		4			1				4	2	4	2		
	Дундговь	4	7		1			1	1		1	2	4	2	4	1	
	Өмнөговь	34	30	4	7			5	1	4	3	20	17	20	17	1	2
	Үүнээс:Цогтцэций сум	15	11	2	2			2	1		2	11	5	11	5		1
	Сэлэнгэ	37	34	9	11		1	8	5	4	3	16	11	16	11		3
	Үүнээс: Мандал	19	10	3	2		1	5	1	2	2	9	3	9	3		1
	Төв	72	41	7	7			29	3	2	5	34	24	34	24		2
Үүнээс: Заамар	12	12					5	1	1	3	6	8	6	8			
Зүүн бүс	Дорнод	31	25	10	4					1	1	18	17	18	17	2	3
	Сүхбаатар	17	32	1	7			3	17	2	1	10	7	10	7	1	
	Хэнтий	19	27	4	10			4	4		1	9	12	9	12	2	
	Үүнээс: Бор- Өндөр		3		3												
		493	386	104	100	1	2	201	67	27	25	85	77	85	77	19	13

Хүний эрүүл мэндэд учруулсан хохирлын хувьд 2020 оны байдлаар нийт 8175 хүнд хохирол учруулсан бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, 552 буюу 6.3%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Эд хөрөнгийн хохирлын хувьд 2020 оны байдлаар 254937.3 сая төгрөгийн хохирол учирснаас 219962.0 сая төгрөгийн хохирол хөнгөн хэрэгт, 34975.3 сая төгрөгийн хохирол хүнд хэрэгт учирсан нь урьд оны мөн үетэй харьцуулбал, нийт 92590.7 сая төгрөг буюу 57%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хөнгөн хэргийн улмаас учирсан хохирол 128643.2 сая төгрөг буюу 2.4 дахин өссөн бол хүнд хэргийн улмаас учирсан хохирол 35952.5 сая төгрөг буюу 50.7%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №2. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол нийслэлд /2019-2020/

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Учирсан хохирол (сая.төг)					
			Нийт		Гэмт хэргийн ангилал			
					Хөнгөн		Хүнд	
			2019	2020	2019	2020	2019	2020
А			1	2	3	4	5	6
Нийслэл			121709.3	222257.5	67344.3	197239.4	54365.1	25018.1
1	Баянгол		21185.4	15590.0	18897.7	12849.9	2287.7	2740.1
2	I хэлтэс		12700.4	9984.4	11779.8	8069.3	920.6	1915.1
3	II хэлтэс		8485.0	5605.6	7118.0	4780.6	1367.0	825.0
4	Баянзүрх		26095.1	23473.7	15074.2	18334.8	11020.9	5138.9
5	I хэлтэс		10484.2	7911.1	7638.7	7148.5	2845.5	762.6
6	II хэлтэс		9795.0	7730.7	4351.2	6282.1	5443.8	1448.7
7	III хэлтэс		5815.9	7831.9	3084.3	4904.3	2731.6	2927.6
8	Сүхбаатар		23205.0	25929.4	10517.4	18436.7	12687.6	7492.8
9	I хэлтэс		20354.1	21174.3	8588.2	13955.5	11765.9	7218.8
10	II хэлтэс		2850.9	4755.1	1929.2	4481.2	921.7	273.9



ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIME VICTIM

11	Сонгинохайрхан	9033.5	11706.5	6718.9	8974.8	2314.6	2731.7	
12	I хэлтэс	5706.6	6646.7	4088.6	5072.5	1618.0	1574.2	
13	II хэлтэс	2002.2	2886.8	1617.7	2541.1	384.4	345.6	
14	III хэлтэс	1324.7	2173.0	1012.6	1361.2	312.1	811.9	
15	Хан-Уул	28157.8	107074.7	5688.2	105606.8	22469.6	1467.9	
16	I хэлтэс	26188.8	104941.7	4310.1	104036.6	21878.6	905.2	
17	II хэлтэс	1969.0	2133.0	1378.0	1570.2	591.0	562.7	
18	Чингэлтэй	12956.8	37581.8	9625.3	32345.4	3331.5	5236.4	
19	I хэлтэс	11577.5	36260.0	8534.8	31174.3	3042.6	5085.6	
20	II хэлтэс	1379.3	1321.8	1090.5	1171.1	288.8	150.7	
21	Багануур	173.3	155.5	146.8	111.5	26.5	44.1	
22	Багахангай	45.5	77.4	45.5	41.3		36.2	
23	Налайх	856.9	668.5	630.2	538.3	226.8	130.2	
24	Бусад	824.7	127.1	234.7	127.1	589.9		
25	ИАТ	41.7	18.4	31.7	16.8	10.0	1.6	
26	Төмөр зам	1118.9	1464.4	296.3	1167.4	822.6	297.0	
27	Мөрдөн байцаах алба	2633.7	28812.9	1256.5	28596.8	1377.2	216.1	
28	Эрүүгийн цагдаагийн алба	27953.0	6554.6	3700.0	2857.0	24253.0	3697.6	
29	Замын цагдаагийн газар	2220.4	2367.9	2109.8	2184.9	110.6	183.0	
30	Экологийн цагдаагийн алба		274.9		242.4		32.5	
31	НЦУГ	ХГХТХ	7944.0	389.0	1240.7	192.4	6703.3	196.7
32		ХОХГХТХ	992.8	318.5	618.2	66.7	374.6	251.9
33	Хар тамхитай тэмцэх газар	0.1	8.9	0.1	8.1		0.8	
34	АТГ	2049.4	2245.8	287.0	1893.6	1762.4	352.3	
35	ТЕГ -ын МБХ	10.8	289.9	10.3	289.9	0.5		
36	Улсын дүн	162346.6	254937.3	91418.8	219962.0	70927.8	34975.3	
Өсөлт бууралт/тоогоор/		92590.7		128543.2		-35952.5		
Өсөлт бууралт /хувиар/		57.0		2.4 дах		-50.7		

Хүснэгт №3. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол орон нутагт /2019-2020/

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Учирсан хохирол (сая.төг)					
			Нийт		Гэмт хэргийн ангилал			
			2019	2020	Хөнгөн		Хүнд	
					2019	2020	2019	2020
А			1	2	3	4	5	6
1	Баруун бүс	Баян-Өлгий	1131.4	822.9	859.6	540.0	271.8	282.9
2		Говь-Алтай	1196.4	697.0	1066.7	341.3	129.7	355.7
3		Завхан	677.6	1214.5	332.4	738.1	345.3	476.5
4		Үүнээс: Тосонцэнгэл	202.4	259.4	58.7	62.1	143.7	197.3
5		Увс	618.7	444.4	351.3	210.4	267.5	234.0
6		Ховд	1124.7	936.6	685.2	745.4	439.4	191.2
7		Үүнээс : Булган	185.4	169.2	62.3	144.6	123.1	24.6
8	Хангайн бүс	Архангай	2169.0	1645.5	1509.2	779.3	659.7	866.2
9		Баянхонгор	1665.7	1168.0	807.1	779.9	858.5	388.0
10		Булган	1471.9	1603.7	901.2	1295.6	570.7	308.1
11		Орхон	2610.9	1859.7	1233.1	1107.7	1377.9	752.0
12		Өвөрхангай	1060.2	772.9	681.0	558.3	379.2	214.6
13		Үүнээс: Хархорин	361.7	279.8	244.1	188.9	117.6	90.8
14		Хөвсгөл	2515.6	2158.5	772.7	1538.2	1742.9	620.2
15	Төвийн бүс	Говьсүмбэр	405.1	3585.9	346.9	3541.9	58.2	44.0
16		Дархан-Уул	2586.9	1681.6	1738.7	1450.9	848.1	230.6

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ - 2020

17		Дорноговь	3558.9	1127.6	1414.4	893.1	2144.4	234.6
18		Үүнээс: Замын-Үүд	1982.3	497.1	924.6	407.1	1057.7	90.0
19		Дундговь	683.7	692.9	411.9	411.3	271.8	281.6
20		Өмнөговь	1574.5	2471.8	1358.6	1074.9	215.9	1396.9
21		Үүнээс:Цогтцэций сум	1182.3	1961.3	1069.2	777.4	113.1	1184.0
22		Сэлэнгэ	2700.7	1294.2	2002.6	1038.5	698.1	255.7
23		Үүнээс: Мандал	752.2	254.9	595.3	178.5	157.0	76.4
24		Төв	4153.6	3250.1	2605.6	2504.4	1547.9	745.7
25		Үүнээс: Заамар	350.8	1133.0	238.7	811.9	112.2	321.1
26	Зүүн бүс	Дорнод	3988.6	1387.9	2446.6	986.4	1541.9	401.5
27		Сүхбаатар	1492.4	1445.6	962.0	428.3	530.4	1017.3
28		Хэнтий	2426.4	2291.4	1353.0	1631.6	1073.4	659.8
29		Үүнээс: Бор-Өндөр	509.8	242.8	216.7	131.4	293.2	111.4

Учирсан эд хөрөнгийн хохирлыг өмчийн төрлөөр нь ангилбал, төрд нийт 6537.5 сая төгрөгийн хохирол учирснаас төрийн өмчийн оролцоотой эд хөрөнгөнд 1875.7 сая төгрөгийн, төрийн оролцоотой өмчийн эдийн хөрөнгөд 1875.7 сая төгрөгийн, гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай өмчийн 1327.1 сая төгрөгийн хохирол тус тус учирсан бол өнгөрсөн оны мөн үетэй нийт эд хөрөнгийн хохирлын хэмжээг харьцуулбал 2579.4 сая төгрөг буюу 65.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт №4. Төрийн өмчийн хэлбэрээр

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Учирсан хохирол (сая.төг)							
			Өмчийн хэлбэр							
			Төрийн		Үүнээс					
			2019	2020	Өмчийн		Өмчийн оролцоотой		Гадаадтай хамтарсан хөрөнгө оруулалттай	
А			1	2	3	4	5	6	7	8
1	Улсын дүн		3958.2	6537.5	2244.0	3334.7	820.7	1875.7	893.4	1327.1
	Өсөлт бууралт/тоогоор/		2579.4		1090.7		1055.0		433.7	
	Өсөлт бууралт /хувиар/		65.2		48.6		2.3 дах		48.5	

Орон нутгийн өмчийн нийт 2395.1 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирснаас орон нутгийн өмчийн 1446.6 төгрөгийн, орон нутгийн өмчийн оролцоотой 935.9 төгрөгийн, гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай орон нутгийн өмчид 12.7сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол тус тус учирсан бол өнгөрсөн оны мөн үетэй нийт хохирлын хэмжээг харьцуулбал 925.6 сая төгрөг буюу 27.9%-иар буурсан үзүүлэлттэй байна

Хүснэгт №5. Орон нутгийн өмчийн хэлбэрээр

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Учирсан хохирол (сая.төг)							
			Өмчийн хэлбэр							
			Орон нутгийн		Үүнээс					
			2019	2020	Өмчийн		Өмчийн оролцоотой		Гадаадтай хамтарсан хөрөнгө оруулалттай	
А			15	16	17	18	19	20	21	22
1	Улсын дүн		3320.7	2395.1	2515.1	1446.6	606.3	935.9	199.4	12.7
	Өсөлт бууралт/тоогоор/		-925.6		-1068.5		329.6		-186.7	
	Өсөлт бууралт /хувиар/		-27.9		-42.5		54.4		-93.6	

Хувийн өмчийн нийт 246004.7 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирснаас Монгол улсын иргэний өмчийн 241641.3 сая төгрөгийн, гадаад улс болон иргэнтэй хамтарсан 4362.5 сая төгрөгийн, гадаад улсын болон иргэний 0.8 сая төгрөгийн хохирол тус тус учирсан орон нийт хохирлын хэмжээг өнгөрсөн мөн үетэй харьцуулбал 91986.1 төгрөг буюу 61.5%-иар өсжээ. Мөн энэ хугацаанд мөрдөн байцаалтын шатанд нийт 6421.3 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсан байна.

Хүснэгт №6. Хувийн өмчийн хэлбэрээр

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Учирсан хохирол (сая.төг)								Битүүмжилсэн хөрөнгө /сая.төг/			
			Өмчийн хэлбэр								Нийт			
			Хувийн		Үүнээс									
					Монгол улсын иргэний өмч		Гадаад улс болон иргэнтэй хамтарсан		Гадаад улсын болон иргэний		Үүнээс			
2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	
А			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Улсын дүн		155067.7	246004.7	149655.3	241641.3	5411.0	4362.5	1.4	0.8	7005	6421	7005	6421
	Өсөлт бууралт/тоогоор/		90936.9		91986.1		-1048.5		-0.6		-584.3		-584.3	
	Өсөлт бууралт /хувиар/		58.6		61.5		-19.4		-43.0		-8.3		-8.3	

Хохирол нөхөн төлүүлэлтийн хувьд хэрэг бүртгэлтийн шатанд 2020 оны байдлаар 278.2 сая төгрөгийн төлбөр нөхөн төлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 81.4 сая төгрөг буюу 41.3%-иар өссөн үзүүлэлттэй байгаа бол мөрдөн байцаалтын шатанд 81801.2 сая төгрөг нөхөн төлүүлсэн бол өнгөрсөн мөн үетэй харьцуулахад 38238.5 сая төгрөг буюу 87.8%-иар өссөн байна.

